



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

ШУДАРГА ЁС

2024/02 (28)

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Зөвлөлийн дарга:

Л.Түвшинбат, АТГ-ын США-ны дарга, ахлах комиссар

Гишүүд:

Г.Азжаргал, АТГ-ын дэд дарга, эрхэлсэн комиссар

Р.Баярмагнай, АТГ-ын хэлтсийн дарга, доктор (Ph.D), эрхэлсэн комиссар

Ч.Жаргалбаатар, АТГ-ын МШХ-ийн албаны дарга, ахлах комиссар

Б.Баярсайхан, АТГ-ын ХШДШХ-ийн албаны дарга, ахлах комиссар

Д.Цэнд-Аюуш, АТГ-ын УССГХ-ийн ахлах ажилтан, ахлах комиссар

Б.Билэгт, АТГ-ын ТХ-ийн ажилтан, комиссар

Нарийн бичгийн дарга:

Ц.Бадам, АТГ-ын США-ны ахлах ажилтан, ахлах комиссар

©Авлигатай тэмцэх газар, 2024 он

Энэхүү эмхэтгэлд орсон бүтээлийг бүхэлд нь болон хэсэгчлэн ашиглахад зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай Монгол Улсын хуулийн холбогдох заалт үйлчилнэ.

ISSN 2791-3619

Цаасны хэмжээ: В5

Хэвлэлийн хуудас: 14

Хэвлэсэн тоо: 500

Хэвлэлийн газар: Урангар пресс ХХК-ийн хэвлэх үйлдвэр

ӨМНӨХ ҮГ

Авлигатай тэмцэх газраас эрхлэн гаргадаг “Шударга ёс” онол, практик, арга зүйн цуврал сэтгүүлийн 2024 оны сүүлийн дугаарыг уншигч Та бүхэндээ толилуулж байна.

Авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг авлигын эсрэг соён гэгээрүүлэх ажил нь Авлигатай тэмцэх газрын үндсэн чиг үүргийн нэг юм. Тус ажлын хүрээнд бид эрдэмтэн, судлаачид, мэргэжлийн шинжээчдийн авлигын талаар болон улс орны нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, чиг хандлагыг тодорхойлох чиглэлээр хийсэн судалгаа, шинжилгээний ажлуудын үр дүн, шинжлэх ухааны салбарт гарсан өөрчлөлт, дэвшүүлсэн олон талт таамаглалыг уг сэтгүүлээр дамжуулан уншигч та бүхэнд хүргэсээр байгаа билээ.

Энэ удаагийн дугаарт “Монгол улсын эрүүгийн процессын дагуу нэгжлэг хийх, хураан авах ажиллагааг явуулахад анхаарах асуудал”, “Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын ажилд хиймэл оюун ухааныг хэрхэн ашиглах боломж”, “Төрийн худалдан авалт: онцлог, авлигаас ангид явуулах нь”, “Авлигын гэмт хэрэгтэй тэмцэхэд тусгай, нууц арга, хэрэгсэл ашиглах нь”, “Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох эрүүгийн процессын ажиллагааны анхаарах зарим асуудал”, “Сонголт хэл ярианы бэрхшээл эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд хөнгөрүүлэх хүчин зүйл болох нь”, “Ашиг сонирхлын зөрчлийн зарим асуудалд” болон “Мөрдөн шалгах ажиллагаа: эрх зүйн зохицуулалт, анхаарах асуудал” сэдвээр бичигдсэн эрдэм шинжилгээний өгүүллүүдийг сонгон нийтэлсэн.

Уг бүтээлүүд нь өргөн хүрээтэй, чухал ач холбогдолтой мэдээ, мэдээлэл агуулсан бөгөөд бодлого боловсруулагчид, төрийн байгууллагын албан хаагчдад болон эрдэмтэн судлаачдад авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөр үйл ажиллагааг боловсруулах, төлөвлөхөд мэдээллийн нэг эх сурвалж болно гэдэгт итгэж байна.

Авлигатай тэмцэх үйл хэрэгт хамтран ажиллаж үнэтэй санал, дэмжлэг, туслалцаа үзүүлж буй эрдэмтэн судлаачид, байгууллагууд болон эрдэм шинжилгээний бүтээлээ ирүүлсэн бүх хүмүүст талархлаа илэрхийлье.

Шударга ёс, хөгжил дэвшилд

Та бүхэн сэтгүүлтэй холбоотой санал, хүсэлтээ shudargayos@iaac.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

АГУУЛГА

ӨГҮҮЛЭЛ, ИЛТГЭЛ

**Монгол улсын эрүүгийн процессын дагуу нэгжлэг хийх,
хураан авах ажиллагааг явуулахад анхаарах асуудал**

Р.Баярмагнай

6

Ашиг сонирхлын зөрчлийн зарим асуудалд

С.Пүрэвдорж

17

**Мөрдөн шалгах ажиллагаа: Эрх зүйн зохицуулалт,
анхаарах асуудал**

Н.Манлайбаатар

34

**Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох эрүүгийн
процессын ажиллагааны анхаарах зарим асуудал**

Ч.Болд

43

**Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын ажилд
хиймэл оюун ухааныг хэрхэн ашиглах боломж**

Г.Чагдар

53

**Авлигын гэмт хэрэгтэй тэмцэхэд тусгай, нууц арга,
хэрэгсэл ашиглах нь**

Ч.Доржсүрэн

67

**Төрийн худалдан авалт: Онцлог, авлигаас
ангид явуулах нь**

Д.Очбаяр

86

**Сонсгол, хэл ярианы бэрхшээл эрүүгийн хариуцлага
хүлээлгэхэд хөнгөрүүлэх хүчин зүйл болох нь**

Н.Бадамцэцэг

100



Р.БАЯРМАГНАЙ

*Хууль зүйн доктор, профессор
АТГ-ын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар*

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ДАГУУ НЭГЖЛЭГ ХИЙХ, ХУРААН АВАХ АЖИЛЛАГААГ ЯВУУЛАХАД АНХААРАХ АСУУДАЛ

/Авлигын гэмт хэргийн жишээн дээр/

Challenges on Search and confiscation operations

Хураангуй: Авлигын гэмт хэргийг уламжлалт арга тактикаар /илээр/ мөрдөж тогтооход хугацаа их шаардагддаг, нотлох баримтын шинж чанар алдагдах, хүндрэлбэрхшээл тулгардаг тул төлөвлөгөөний дагуу хойшлуулшгүй, хэргийн нууцлалыг хангаж мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүн, мэдээ, баримт сэлт дээр тулгуурлан мөрдөн шалгах ажиллагаа явуулах нь илүү өндөр үр дүнтэй бөгөөд нэгжлэг, хураан авах ажиллагааны өнөөгийн байдалд судалгаа шинжилгээ хийж, тухайн ажиллагааг зохион байгуулахад анхаарах асуудлын талаар дүгнэлт гаргахад чиглэгдсэн билээ.

Abstract: When investigating corruption crimes using traditional tactics, it often takes a significant amount of time to establish the case. The nature of the evidence can be compromised, leading to difficulties. Thus, any delays in the process cannot align with the planned schedule. Drawing conclusions regarding the issues to be addressed in organizing the event is imperative.

Түлхүүр үг: Нэгжлэг, хураан авах, авлига, гэмт хэрэг, мөрдөн шалгах ажиллагаа, эрх зүйн зохицуулалт, анхаарах асуудал.

Key words: Search, conduct, corruption, crimes, operation, legal, issues to consider.

Нэг. Эрх зүйн зохицуулалтын талаар

Нийгэм хөгжихийн хирээр хүн төрөлхтний дунд үүсдэг элдэв харилцааг хуулиар зохицуулах шаардлага бий болдог. Хууль хэрэгжих нэг баталгаа нь тухайн хуулийг зөрчигдсөн эсэхийг нотлох баримтаар тогтоож зохих шийдвэр гаргахад оршдог. Түүнчлэн хүний эрх, эрх чөлөөг дээдлэх асуудал нь нэг улсын хүрээнээс хальж, дэлхий нийтийн асуудал болсон нь төрөөс, иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх мөн түүнчлэн эрх, эрх чөлөө нь дахин зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх талаар Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд үйл ажиллагаагаа олон түмний нийтлэг хүсэл сонирхол, дэлхий нийтийн түгээмэл зарчимд нийцүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай болжээ.

Иргэд, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээн, буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхэд өндөр ур чадвар, мэдлэг, боловсрол бүхий оролцогчдын хуульч, шуурхай ажиллагааны үр дүнд бий болсон нотлох баримтад тулгуурлан шүүхийн шийдвэр гаргахыг нийгэм, цаг үе шаардаж байна. Хэдий тийм боловч хүн төрөлхтөн сайн дураараа тухайн хууль дүрмийг даган мөрдөх эрх зүйн ухамсар одоо болтол бүрэн дүүрэн бүрдэхгүй байгаа нь цаашид оновчтой арга замуудыг эрэлхийлэх шаардлагыг зүй ёсоор бий болгосоор байгаа билээ.

Онолын хувьд тайлбарлан авч үзвэл аливаа шинжлэх ухааны онол нь түүний судлах зүйл болсон нийгмийн үзэгдэл, үйл явцын агуулга, эрэл хайгуулын шууд үр дүн байдаг. Энэ нь эцсийн дүндээ онолын үндэслэлтэй, бодит хэлбэржсэн, шинжлэх ухаанч байх уг чанарыг илтгэдэг. Онол гэдэг нь нэр томъёоны хувьд **theoria- судлах**¹, **танин мэдэх** гэсэн утгыг илэрхийлэх грек үгнээс гаралтай², агуулгын хувьд мэдлэгийн аль нэгэн салбарын үндсэн үзэл санааны цогц гэсэн утгаар ойлгож болно.³ Онол нь эрх зүйгээ улам боловсронгуй болгоход чиглэгддэг бол эрх зүй нь онолоо хөгжүүлэхэд чиглэгдэнэ. Энэ хоёр нь бие биетэйгээ салшгүй холбоотой байдаг.⁴ Нотлохуйн

¹ Дашдаваа.Д. Равдан.Э. Нэр томъёоны тухай. Уб., 1980. 9 дэх тал

² Словарь русского языка".М.1985., с.354,

³ Монголын нэвтэрхий толь /боть-2"/. Уб. 2000., 672 дахь тал.

⁴ Батзориг.Б. Гэмт хэрийн нотолгооны ерөнхий онол. Уб., 2002. 23 дахь тал


ухааны үндэс нь шинжлэх ухаан судалгааны арга, арга зүйн асуудлыг танин мэдэх, үйл ажиллагаандаа хэлбэрэлтгүй ашиглах явдал юм.

Тэр дундаа авлигын гэмт хэрэг нь эрх мэдэлтэй, улс төрийн болон нийтийн албаны тушаал, шийдвэр гаргах болон зөвшөөрөл олгох эрх бүхий албан тушаалтны шийдвэр гаргах замаар далд хэлбэрт үйлдэгддэг гэмт хэрэг юм. Энэ төрлийн гэмт хэргийн улмаас улс орны эдийн засагт ихээхэн хэмжээний хохирол учирдаг, харин хор уршиг нь нийгмийн гишүүн бүрт учирч байдгаараа онцлогтой.

Хоёр. Өнөөгийн нөхцөл байдал

Авлигын эсрэг гэмт хэрэг 2023 оны байдлаар нийт 1670 гомдол, мэдээлэл хүлээн авч, 41.9 хувьд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг нээж, 52.1 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 2.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж, 55 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй, шийдвэрлэлт 96.7 хувьтай байна⁵.

Хүснэгт: 1. Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан гомдол, мэдээллийн шийдвэрлэлт



Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан 1670 гомдол, мэдээллийн 59.1 хувийг Улаанбаатар, 40.9 хувийг орон нутгийн гомдол, мэдээлэл эзэлж байна.

Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан харьяаллын 2183 үйлдэлтэй, 1402 холбогдогчтой, 1837 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсныг өмнөх онтой харьцуулбал 16.3 хувиар өссөн байна. Авлигын гэмт


⁵ Авлигатай гэмцэх газрын 2023 оны гэмт хэргийн тоон мэдээ. Уб., 2023. 2 дахь тал

Монгол улсын эрргийн процессын дагуу нэгжлэг жийж, жураан авах ажиллагааг явуулажад анжаарах асуудал

хэргийн үйлдэл өмнөх оноос 17,2 хувиар, холбогдсон хүн хуулийн этгээд 15,5 хувиар өссөн.

Нийт шалгасан хэргийн 325 буюу 17.7 хувийг шүүхэд шилжүүлэх саналтай, 544 буюу 29.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хаах, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай, 57 буюу 3.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж, 132 хэргийг нэгтгэн шалгаж, 12 хэргийг түдгэлзүүлж, одоо 767 эрүүгийн хэргийн үлдэгдэлтэй байгаагаас хэрэг бүртгэлтийн 690 хэрэг, мөрдөн байцаалтын 77 хэрэг байна. Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн шийдвэрлэлт 57.6 хувьтай, өмнөх оноос 5,4 хувиар өсч, шүүхээр 192 хэрэг /2022 онд 188/ шийдвэрлэгдсэн байна⁶.

Хүснэгт:2. Хэргийн шийдвэрлэлт




2023 онд шалгагдсан гэмт хэргийн улмаас 845,797,805,525.00 /найман зуун дөчин таван тэрбум, долоон зуун ерэн долоон сая, найман зуун таван мянга таван зуун хорин тав/ төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 238,689,979,559.00 /хоёр зуун гучин найман тэрбум, зургаан зуун наян есөн сая, есөн зуун далан есөн мянга таван зуун тавин ес/ төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 17,137,615,448.00 /арван долоон тэрбум, нэг зуун гучин долоон сая, зургаан зуун арван таван мянга, дөрвөн зуун дөчин найм/ төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна⁷.

⁶ Авлигатай гэмцэх газрын 2023 оны гэмт хэргийн тоон мэдээ. Уб., 2023. 3 дахь тал

⁷ Авлигатай гэмцэх газрын 2023 оны гэмт хэргийн тоон мэдээ. Уб., 2023. 4 дэх тал

Хүснэгт: 3. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт



Нийт учирсан хохирлын 28.2 хувийг нөхөн төлүүлж, хахуулийн 8,680,730,871 төгрөгийн үнэ бүхий бэлэн мөнгө, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө хураан авсан.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 24.1 дүгээр зүйлд заасны дагуу 60 хэрэгт холбогдуулан нийт 334 объектод нэгжлэг хийж, хураан авах ажиллагааг явуулсан байна.

Үүнээс үзвэл авлигын гэмт хэрэг нь цаашид өсөх хандлагатай байгаа нь харагдаж байна. Тиймээс авлигын гэмт хэргийн нэгжлэг хийх, хураан авах ажиллагаа болон, мөрдөгч нарын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэн, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлж нотлох ажиллагааг илүү сайжруулах шаардлагатай байна. Тэгвэл энэхүү гэмт хэргийн нэгжлэг, хураан ажиллагааг явуулахад анхаарах асуудлыг тодорхойлох асуудал үүнээс үүдэн гарч ирж байна.

Авлигын гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах процессын үед нотолгоо болон нотлох баримт гэж ангилан хууль тогтоомжид тайлбарласан байдаг. Нотолгоо нь хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгагдсан шийдвэр гаргахын тулд тодорхой этгээдээс нотолгооны зүйлийг гэмт хэргийн бүрэлдэхүүн болон түүнтэй холбогдон бий болох бусад нөхцөл байдлуудыг тогтоох үйл явцыг хэлдэг⁸.

⁸ Өнөрмаа.Б. Галдаа.Б нарын Авлигын гэмт хэрэг ба прокурорын хяналт.Уб., 2022. 116 дахь тал

Монгол улсын эрүүгийн процессын дагуу нэгжлэг хийж, хураан авах ажиллагааг явуулахад анхаарах асуудал

Харин Нотлох баримт гэж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээллийг ойлгох⁹ ба нотлох баримтуудаар тогтоогдсон нөхцөл байдал буюу дүр зургийг үйл баримт гэж тайлбарладаг. Авлигын гэмт хэргийг илрүүлэх явцад нэгжлэг хийх, хураан авах ажиллагаагаар хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулан, бэхжүүлж авч, хэргийг тал бүрээс нь бүрэн дүүрэн нотлох шаардлага тулгардаг.

Гурав. Нэгжлэг, хураан авах ажиллагааны анхаарах асуудлын талаар

Нэгжлэг хийх, хураан авах ажиллагааг онол, практикийн хувьд тайлбарлан авч үзвэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт “Мөрдөгч хэргийн эд мөрийн баримт, бичмэл нотлох баримт эсвэл эрэн сурвалжилж байгаа хүн, эд зүйл байна гэх хангалттай үндэслэл байвал тэдгээрийг илрүүлэхээр прокурорын зөвшөөрлийн дагуу нэгжлэг хийх тогтоолд заасан орон байр, бусад газар, хүний бие нэгжлэг хийнэ¹⁰” гэж хуульчилсан.

Мөрдөн шалгах ажиллагаа болон мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнд авлигын гэмт хэрэгт ач холбогдолтой эд зүйлс, баримт сэлт, хууль бус эх үүсвэртэй хахуулийн мөнгө, эдийн болон эдийн бус баялаг зэрэг нь аль нэг газарт эсвэл хэн нэгэн этгээдийн эзэмшлийн газар орон, орон байранд байна гэсэн хангалттай үндэслэл тогтоогдвол нэгжлэг хийх ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр эсхүл хойшлуулшгүй тохиолдол мөрдөгч бие даан явуулдаг.

Авлигын гэмт хэргийг шалгах явцад нэгжлэг хийх процесс нь бэлтгэл үе, нэгжлэгийн ажиллагаа хийх, дараах гэсэн 3 үе шатаас бүрдэх бөгөөд тухайн үе шат бүр өөр өөрийн гэсэн онцлогийг агуулж байдаг.

Бэлтгэл үед нэгжлэг хийх гэж байгаа объектын хаяг, байршил, орц, гарц, хэдэн цонхтой, хаашаа харсан, ямар загвар, моделийн дуу-дүрсний хяналтын камертай, цоожны систем, гэрэлтүүлэг зэргийг судлахаас гадна нэгжүүлэгчийн нас, хүйс, мэргэжил, боловсрол, эрхэлсэн ажил, дадал зуршил, амьдралын хэв маяг, хань харилцаа, гэр бүлийн байдал, хэрэгт ач холбогдолтой баримтуудыг хадгалдаг байршил зэргийг урьдчилан судлан, бэлтгэх шаардлагатай юм. Өргөн цар хүрээний хэд хэдэн байршилд нэгжлэг

⁹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль//Төрийн мэдээлэл. Уб., 2017. №34

¹⁰ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль//Төрийн мэдээлэл. Уб., 2017. №34

хийх тохиолдолд мөрдөгчдийн багийг ээлж дараатайгаар эсхүл нэгэн зэрэг явуулах зэргээр төлөвлөгөөг урьдчилан боловсруулна.

Хойшлууулшгүй тохиолдолд мөрдөгч нь прокурорын зөвшөөрөлгүйгээр нэгжлэг хийх ажиллагааг явуулж, нэгжлэгийн ажиллагаагаар илэрсэн хураан авсан эд мөрийн баримтууд зэргийг ажиллагаа явуулж дууссанаас хойш 24 цагийн дотор хяналтын прокурорт мэдэгдэж ажиллагаагаар тогтоогдсон нөхцөл байдлыг хуульд заасан үндэслэл журмын дагуу бэхжүүлэн авсан тухай мөрдөгчийн хүчинтэйд тооцуулах тухай тайлбарын хамт хүргүүлэх үүрэгтэй. Хойшлууулшгүй тохиолдол гэдэгт гэмт хэргийг таслан зогсоох үед, эсвэл гэмт хэргийг шуурхай илрүүлэх ажиллагааны явцад эд мөрийн баримт болон гэмт этгээд нуугдаж байгаа газрыг гэрч шууд зааж байгаа, гэмт этгээд үйлдэл дээрээ буюу эд мөрийн баримттайгаа баригдсан зэрэг тохиолдлуудыг ойлгох бөгөөд мөрдөн шалгах ажиллагаа явуулж болохгүй шөнийн цаг¹¹аар хэрэгт ач холбогдол бүхий баримт бичиг, эд зүйлс, эд мөрийн баримт нь устах, зөөвөрлөгдөх, шинж чанараа алдах, нотлох баримт, ул мөрөө устгаж байгаа тухай мэдээлэл авагдсан бол гэмт этгээдээс өрсөж ажиллагааг явуулах шаардлага үүсэхийг ойлгох юм.

Нэгжлэг хийх ажиллагаа нь мөрдөн байцаалтын үзлэг хийх ажиллагаатай зарим талаараа адил төстэй учир практикт үзлэгийн оронд нэгжлэг, нэгжлэгийн оронд үзлэг хийх тохиолдол үүсдэг. Үзлэг, нэгжлэгийн алинд ч хэрэгт ач холбогдолтой эд зүйл, баримтыг илрүүлэн хураан авдаг бөгөөд тактикийн ижил аргуудыг хэрэглэдэг. Дээрх ажиллагаанууд нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах зорилго, эрх зүйн шинжээрээ ялгаатай. Өөрөөр хэлбэл, нэгжлэгийн зорилго үзлэгийнхээс илүү өргөн цар хүрээтэй албадлагын шинж чанартай байдгаараа ялгагдана.

Нэгжлэг эхлэхийн өмнө мөрдөгч нэгжлэг явуулах объектой биечлэн танилцаж, урьдчилан тооцоолж байсан нөхцөлд онцын өөрчлөлт ороогүй бол төлөвлөгөөний дагуу ажиллах бөгөөд харин эрс ялгаатай бол тухайн газарт ажиллах тактикийн шинэ шийдвэр гарган, оролцогчдод ажил үүргийг нь дахин хуваарилна. Нэгжлэгийн ажиллагаа хийх аргыг хэсэгчилсэн, ерөнхий, хэд хэдэн мөрдөгчид огтолцох байдлаар, цагийн зүүний дагуу, ертөнцийн зүгээр баримжаалан явуулах зэрэг хэд хэдэн аргыг сонгон явуулах боломжтой.

¹¹ Шөнийн цаг гэж тухайн өдрийн 22.00 цагаас дараа өдрийн 06.00 цаг хүртэлх хугацааг

Монгол улсын эрргийн процессын дагуу нэгжлэг хийж, жураан авах ажиллагааг явуулахад анхаарах асуудал

Нэгжлэгийн хамгийн хариуцлагатай үе нь нэгжих байранд нэвтрэн орох явдал бөгөөд нэвтрэн орохдоо мөрдөгчдийн баг өөрсдийгөө танилцуулж, бичиг баримтаа үзүүлээд, нэгжлэгийн ажиллагаа явуулах тухайгаа тайлбарлан, нэгжлэг хийх тогтоолыг уншуулж танилцуулаад нэгжүүлэгчээр гарын үсэг зуруулж дуу-дүрсний бичлэгээр ажиллагааны явц байдлыг нэг бүрчлэн бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах замаар ажиллагааг эхэлнэ. Дараа нь аюулгүй байдлын арга хэмжээг авч хамгаалалт гарган, нэгжлэг хийх байранд байгаа хүмүүсийг хэн болохыг шалгана.

Энэ үед алдаа гаргахад уг ажиллагааны үр дүнд шууд сөргөөр нөлөөлөх, ажиллагаагаар тогтоогдсон нөхцөл байдал нотлох баримтаар үнэлэгдэхгүй байх, хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөө зөрчигдөж болзошгүй тохиолдол гарахыг үгүйсгэхгүй, учир нь илэрч болох нотлох баримтаас хамаарч нэгжүүлж буй хүн, хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтны зүгээс огцом эрсдэлтэй үйлдэл хийх, улмаар ажиллагаа явуулж буй мөрдөгч, албан тушаалтнуудын биед халдах зэрэг асуудал үүсэх магадлалтай байдаг тул ажиллагаа хэвийн явуулах нөхцөл байдлыг ажиллагааны явцын турш хяналтдаа байлгах зайлшгүй шаардлагатай.

Ажиллагааг явуулах үед нэгжүүлэгчийн зүгээс эсэргүүцэл үзүүлэх, ажиллагаа явуулж буй мөрдөгчийг өдөөн хатгах, хэл амаар доромжлох, ажиллагаанд санаатай болон санаандгүй байдлаар саад учруулах, амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах, завдах зэрэг үйлдэл гарч болзошгүй тул нэгжүүлэгчийн сэтгэхүйд нөлөөлж, тайвшруулах, эсэргүүцэл үзүүлэх боломжийг хязгаарлах зэрэг ажиллагааг хэвийн явагдах нөхцөл байдлыг бүрэн хангахыг анхаарах шаардлагатай билээ.

Авлигын гэмт хэрэгт нэгжлэгийн ажиллагаа явуулах явцад үүсдэг практикт хэргийн оролцогчид нь өөрийн гэмт үйлдлийг нуун далдлах зорилгоор мөрдөгчийн нэгэнт мэдэж байгаа, прокурорын зөвшөөрөлд заагдсан хайж байгаа эд зүйлийг сайн дураараа гаргаж өгөөд цаанаа өөр бусад ач холбогдолтой эд мөрийн баримт сэлт, хуулиар хориглосон /галт зэвсэг, хар тамхи, түүхийн үнэт олдвор, ховор ан амьтны эд зүйлс/ зэргийг далдалж нууж авч үлдэхийг завддаг тул мөрдөгч нь нэгжлэг хийх ажиллагааны зорилго биелсэн эсэхэд дүгнэлтийг хийж ажиллагааг зогсоох, эсвэл үргэлжлүүлэн объект нэг бүрийн өрөө тасалгаа бүрийг үзэж шалгах шийдвэрийг гаргах нь зүйтэй байдаг.

Нийгэм хөгжихийн хэрээр авлигын гэмт хэрэгт холбогдогчийн үйлдлийн арга нарийсч байдаг тул тухайн этгээдийн өдөр тутамдаа ашигладаг гар утас, таблет, компьютер, цахим мэдээлэл тээгч зэргийг хураан авч, нууц үгийг өөрөөр нь гаргуулж, нэгжлэг явуулах тухай саналыг прокурорт гаргахдаа энэ талаар дурдаж өгөх нь ач холбогдолтой.

Тухайн цахим мэдээлэл хадгалдаг төхөөрөмжид агуулагдаж буй мэдээллүүд нь хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой байдаг тул түүний анх ямар мэдээлэлтэй байхад нь хэрхэн хураан авсан зэргийг тэмдэглэлд сайтар тусгаж, онлайннар хоёрдогч, гуравдагч этгээд интернэтээр дамжин мэдээллийг өөрчлөхөөс сэргийлж онгоцны горим дээр идэвхжүүлж хураан авах шаардлагатай. Олон улсад Faraday bag гэх гаднаас хандах хандалтын богино долгионыг хязгаарласан тусгай уут, цүнхэнд хийж бэхжүүлдэг жишээ байдаг. Холбогдогч этгээд нь өөрийн мэдээллийг цахим мэдээлэл хадгалдаг зөөврийн компьютер, хард диск, icloud, флаш диск-нд хадгалагдаж байгаа хар данс тооцоо, мөн хахууль авахдаа цахим крипто валютаар авсан, түүнийгээ хөдөлгөөнгүй болгож хадгалсан флаш дисктэй төстэй Cold wallet¹² болох ledger¹³, мөн идэвхтэй эргэлтэд орж захиран зарцуулалт хийж Hot wallet¹⁴-ийн нэвтрэх нууц нэр, код бичсэн бичвэр зэргийг анхааралтай нэг бүрчлэн үзэхийг анхаарах хэрэгтэй.

Мөрдөгч нь нэгжлэгийн тэмдэглэлийг үйлдэхдээ ажиллагаагаар олж илрүүлсэн эд зүйл, бичиг баримтыг нэгжүүлэгчид үзүүлж тоо ширхэг, өнгө дүрс, содон тэмдэг, хаанаас хэрхэн гаргаж авсан зэргийг тэмдэглэлд нэг бүрчлэн тусгана. Эдгээрийг бичихдээ тэдгээрийн зориулалт, хэлбэр, хэмжээ, тоо ширхэг, хуудасны тоо, жин, өнгө, дугаар болон бусад онцлог шинж тэмдэг, ул мөрийг тусгана. Ажиллагаагаар их хэмжээний бэлэн мөнгө гарсан тохиолдолд мөрдөгч нь мөнгө тоологч, серийн дугаар бүртгэгч машинаар уншуулж тэмдэглэлд тусгаж, тухайн валютын лац ломбыг шалгана, тухайн лац ломбыг шалгаснаар хэзээ, хаанаас хэрхэн авсан, аль банк, салбарын теллерээс хэдний өдөр авсан зэрэг огноотой байдаг тул, хэргийг нотлох ажиллагаанд ач холбогдолтой байдаг.

¹² Онлайн халдлагаас хамгаалахын тулд криптовалютыг офлайнр хадгалах процесс.

¹³ Цаг, огноо, илгээгч, хүлээн авагч зэрэг мэдээллийг багтаасан гүйлгээний мэдээлэл

¹⁴ Криптовалютыг хадгалах, илгээх, хүлээн авах боломжтой цахим түрийвч

Монгол улсын эрргийн процессын дагуу нэгжлэг хийж, хураан авах ажиллагааг явуулахад анхаарах асуудал

Нэгжлэгийн ажиллагаагаар нуувч, цоожтой хана тааз, өрөө илэрсэн бол тэмдэглэлд түүний байршил, хэрхэн нэвтрэх, байдал хэмжээ дотор нь байгаа эд зүйлс зэргийг тодорхой тэмдэглэн, хяналтын камерын бичлэгээр нэг бүрчлэн бэхжүүлэх бөгөөд хэрэв цоожтой, эзэмшигч онгойлгохгүй тохиолдолд мэргэжлийн этгээдээр /мэргэжилтэн/ онгойлгуулах арга хэмжээг авч хана, тааз, хаалга, цоожийг эвдлэн орж ажиллагааг явуулна, энэ талаараа тэмдэглэлд нэг бүрчлэн тусгах нь зүйтэй гэдгийг анхаарах шаардлагатай юм.

Дүгнэлт:

Хэдийгээр нэг талаас 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдөр Улсын их хурлаас Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль шинэчлэгдэн батлагдаж эрх зүйн зохицуулалтын орчин боловсронгуй болж, нэгжлэг, хураан авах ажиллагааг хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудал, хүндрэл бэрхшээл байхгүй мэт ойлгогдох боловч газар орон, объектод нэгжлэгийн ажиллагааг явуулж хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтуудыг илрүүлэн хураан авах гэхэд хяналтын прокурорын олгогдож буй зөвшөөрөл нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “... **илрүүлэхээр...**” гэж хуульчилсан нь мөрдөгч шууд хураан авах зохицуулалтыг тусгаагүй байна.

Мөрдөгчийн зүгээс тухайн нөхцөл байдалд прокурорт мэдэгдэж явуулсан ажиллагаагаар тогтоогдож буй эд зүйлсийг хураан авах талаар мөрдөн шалгах ажиллагааг хүчинтэйд тооцуулах санал гаргаж дахин хүргүүлж хураан авсан эд зүйлийг хүчинтэйд буюу нотлох баримтаар тооцуулж байгаа нь хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго, зорилтыг хангахад цаг хугацаа алдах, улмаар нотлох баримтын шинж чанар алдагдах гэх зэрэг асуудал үүсэж байна.

Мөн нөгөө талаас ажиллагаа явуулж байгаа алба хаагчдын мэдлэг, ур чадварын түвшнээс хамаарч нэгжлэг, хураан авах ажиллагааг зохион байгуулахад алдаа дутагдал гаргах, ажиллагааг дутуу бэлтгэх, төлөвлөлт хангалтгүйгээс болж ажиллагааны зорилгодоо хүрэхгүй байх, алба хаагч болон нэгжүүлэгч иргэний амь нас, эрүүл мэндэд хохирол учирч болзошгүй нөхцөл байдал үүсэх цаашлаад дахин ажиллагааг явуулах зэрэг эрсдэл үүсдэг.

Иймд авлигын гэмт хэргийг шалгаж, шийдвэрлэх явцад нэгжлэг, хураан авах ажиллагааны эрх зүйн орчин, түүний удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, шинэ шатанд гаргах, олон улсын туршлагыг нэвтрүүлэх, шинээр томилогдсон алба хаагч нарт чиглэсэн сургалт зохион байгуулах зэрэг цогц бодлого, арга хэмжээг зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлага бий болсон байна.

Ашигласан материал:

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль//Төрийн мэдээлэл. Уб., 2017. №34
- Дашдаваа.Д. Равдан.Э. Нэр томъёоны тухай. Уб., 1980,
- Словарь русского языка”.М.1985.,
- Монголын нэвтэрхий толь /боть-2/”. Уб., 2000,
- Батзориг.Б. Гэмт хэрийн нотолгооны ерөнхий онол. Уб., 2002,
- Өнөрмаа.Б. Галдаа.Б нарын Авлигын гэмт хэрэг ба прокурорын хяналт. Уб., 2022,
- Ө.Энхтөр. Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах арга зүй. Уб., 2022,
- Авлигатай тэмцэх газрын 2023 оны гэмт хэргийн тоон мэдээ. Уб., 2023.



С.ПҮРЭВДОРЖ

БХЯ-ны харьяа БХЭШХ-ийн Цэргийн урлаг судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах судлаач, доктор (Ph.D), дэд профессор

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН ЗАРИМ АСУУДАЛД

Хураангуй: Дэлхий нийтээрээ эрүүл нийгэм, эрүүл эдийн засаг, авлига, ашиг сонирхлын зөрчилгүй төр, байгууллагуудын төлөө тэмцэж байна. Гэтэл авлига, ашиг сонирхлын зөрчлийн асуудал нийгмийн хөгжлийн аль ч шатанд ямар ч хэлбэр, хэмжээгээр байсаар ирсэн. Авлига, ашиг сонирхлын зөрчил нь нийгэмд эдийн засагт эрүүл бус орчин бүрдүүлж, шударга ёс, тэгш байдлыг алдагдуулж буй хууль бус сөрөг үзэгдэл төдийгүй улс орны эдийн засгийн хөгжлийг сааруулж, эрх зүйт төрийн бодлогод сөргөөр нөлөөлж байна. Иймд авлига, ашиг сонирхлын зөрчил нь нийтийн эрх ашгийг ноцтойгоор хохироож байгаа тул өнөөгийн нийгэмд тулгамдсан асуудлын нэг болох авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар өгүүлэлдээ авч үзэхийг зорилоо.

Summary: The world is fighting for a healthy society, a healthy economy, and government and organizations without corruption and conflict of interest. However, the problem of corruption and conflict of interest has existed in any form and extent at any stage of social development. “Corruption and conflict of interest is not only an illegal negative phenomenon in the society that creates an unhealthy environment in the economy and undermines justice and equality, but also slows down the economic development of the country, has a negative effect on the legal state policy, and is therefore a dangerous act for the society

of the country manifested by inaction. One type of crime that has a significant impact on corruption and conflict of interest is the crime of abuse of power and position, which occurs when an official abuses his power and official duties, or refuses to do something. Therefore, since corruption and conflict of interest have been causing serious damage to public interests for a long time, we have discussed some of the problems of corruption and conflict of interest, which is one of the pressing problems in today's society.

Keywords: Corruption, conflict of interest, personal interest, organizational conflict of interest, prevention of conflict of interest, ways to reduce corruption.

Оршил хэсэг:

Ашиг сонирхлын зөрчил – нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд болон этгээдүүд нийтийн албанд ажил алба хаах, үүрэг гүйцэтгэхдээ, өөртөө болон нэгдмэл ашиг сонирхолтой хуулийн бусад этгээдэд эдийн болон эдийн бус ашиг олох зорилго бүхий үйлдэл, эс үйлдэл явуулах, энэ нь иргэн, байгууллага, нийгэм, төрийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулах нөхцөл байдал үүсгэхийг ойлгоно.

Мөн ашиг сонирхлын зөрчил – төр, нийгмийн албан тушаалтан, хувь хүн өөрт ногдуулсан үүргийг биелүүлэхэд энэ нь хувийнх нь ашиг сонирхолтой зөрчилдөх нөхцөл байдлыг ч бас ойлгодог.

Үүнээс харахад ашиг сонирхлын зөрчил нь нэгд, иргэн, байгууллага, нийгэм, улсын хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулах нөхцөл байдал үүсгэхийг; хоёрт, төр, нийгмийн албан тушаалтан, хувь хүн өөрт нь хохирол учруулах нөхцөл байдал үүсгэхийг ойлгож байна.

Ашиг сонирхлын зөрчил нь ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй байдал нь олон нийтийн байгууллага, байгууллагад итгэх итгэлийг алдагдуулж, авлигын үйл ажиллагаанд хүргэдэг. Иймд ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх нь ёс зүйн, хууль эрх зүйн хувьд тулгамдсан асуудлын нэг болоод байгаа ажээ.

Хүн төрөлхтний нийгмийн соёл иргэншил бүрэлдэн тогтсон үеэс л ашиг сонирхлын зөрчил үүсэж, түүнээс улбаалсан авлигатай тэмцээр иржээ. Өнөөг хүртэл бие биедээ харилцан бэлэг сэлт, өглөг өгөх нь соёл иргэншлийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг хэвээр байсаар байна. Бие биедээ харилцан бэлэг

сэлт, өглөг өгөх явдлыг: нэгд, хүндэтгэлээ илэрхийлж буй шинж; хоёрт, талархаж, баярлаж явдгийн илэрхийлэл; гурав, тал засаж буйн шинж; дөрөвт, “Би ингэлээ, Та дараа нь надад” гэсний шинж гэх зэргээр ойлгож, тайлбарлаж болох талтай. Хуульд бол “бэлэг” гэж нийтийн албан тушаалтанд үнэ төлбөргүй эд хөрөнгө өгөх, үйлчилгээ үзүүлэх болон эрх шилжүүлэх, үүргээс чөлөөлөх, нийтийн албан тушаалтантай хамаарал бүхий этгээдийн тусын тулд эрхээс татгалзах зэрэг бусад хэлбэрийн санхүүгийн үр ашгийг”¹ хэлнэ гэж тодорхойлжээ.

Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх нь дэлхий дахины өмнө тулгарсан тэргүүлэх асуудлын нэг юм. Авлига хээл хахууль өгч авч, улс төр, намын зөвхөн ашиг сонирхлын тодорхой бүлэгт үйлчилж, танил талдаа давуу байдал олгож байгаа нь тогтвортой хөгжлийн төлөвшил, нийгмийн шударга ёсыг алдагдуулж байдаг.

Ашиг сонирхлын зөрчил, авлигад автсан төрийн албан хаагчид төсвийн мөнгийг тонон дээрэмдэж, бодлого зохицуулалтын үр өгөөжийг үгүйсгэж, албан хаагчид, иргэдийн идэвх санаачилгыг боомилж байна. Авлига, ашиг сонирхлын хорт үр дагавар нь төрийн бодлогыг хоёр нүүрт хоосон хөөс болгож, хууль, шударга ёсонд давхар стандарт тогтоож, төсөл, төлөвлөлтийг гараан дээр нь будилуулж, компанийн эзэд, эрдэмтэд, төрийн албанд ажиллагсдын эрч хүчийг мохоодог тогтолцоог бүрдүүлэх боллоо.

Хэдийгээр авлига, ашиг сонирхлын зөрчил нь танил талдаа давуу байдал олгох, үгсэн хуйвалдаж, хувааж идэх боломжийг хазаарлаж болох ч уг үндсээр нь бүрэн устгах боломжгүй. Тиймээс хууль бусаар олж авсан давуу байдлаа хойч үе, үр хүүхдэдээ өвлүүлэхээс урьдчилан сэргийлэх нь чухал болжээ. Ашиг сонирхол, авлигатай тэмцэхэд тулгарч байгаа саад тотгор, бэрхшээлийн мөн чанарыг таньж, бүрэн ойлгоогүйгээс эхлүүлсэн тэмцэл бүтэлгүйтэх нь тодорхой юм.

Учир нь шилжилтийн үедээ байгаа манай орны хувьд авлига, ашиг сонирхлын зөрчлийн үйлдэлтэй хийх тэмцлийг илүү амжилттай үргэлжлүүлэхэд байгууллагын удирдлагын менежмент чухал болно.

¹ **Монгол Улсын хууль.** 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр. “Нийгмийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”. 3.1.9.заалт; <https://legalinfo.mn/mn/detail?lawId=397>;

Үндсэн хэсэг:

Монгол Улсын хувьд авлига, ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг Авлигын эсрэг хууль, Төрийн албаны тухай зэрэг хуулиар зохицуулж байгаа бөгөөд тусгайлсан хууль баталсан нь зөрчлийн асуудлыг цогцоор авч үзэх зохистой шийдэл болж чадсан² гэж НҮБ-ын Авлигын эсрэг конвенц, Авлигын эсрэг эрх зүйн баримт бичигт тодорхойлсон байна. Төрийн албаны тухай хуульд зааснаар ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нь төрийн албанд баримтлах гол зарчмын нэг мөн.

Албан тушаалтны хувийн ашиг сонирхол нь нийтийн ашиг сонирхолтой буюу албан хаагчийн ажил үүргээ тэгш шударгаар, хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх үүрэгтэй нь зөрчилдөх, зөрчилдөж болзошгүй тул энэхүү зөрчлийг зүй зохистойгоор удирдан зохицуулаагүйгээс улмаар авлига үүсэх орон зайг бий болгож байна. Албан тушаалаа урвуулан ашиглах боломжийг бууруулж, ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй буюу үүсэх нөхцөл байдал бий болсон тохиолдолд зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шаардлагатай албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх замаар шударга байдлыг тогтоох нь шийдлүүдийн гол зорилго юм³ гэжээ.

2016 онд Улсын Их Хурлын 51 дүгээр тогтоолоор Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталсан бөгөөд уг хөтөлбөрийн нэг чухал зорилт бол шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, ёс зүйг дээшлүүлэх явдал бөгөөд энэ хүрээнд авлига, ашиг сонирхлын зөрчил, ёс зүйтэй холбоотой гомдол мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх зэрэг чиглэлээр авлигын эсрэг богино болон урт хугацааны, давтан сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах гэх мэт олон арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан нь ашиг сонирхлын зөрчлөөс ангид, ёс зүйтэй, мэргэшсэн төрийн албыг бэхжүүлэхэд олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байгаагийн илрэл болж байна.

Бодит байдал дээр ашиг сонирхлын зөрчил бол үйлдэл биш харин нөхцөл бөгөөд төрийн албан тушаалтан сонирхлын зөрчлийн нөхцөл тулгарсан ч авлигад автахгүйгээр асуудлыг шийдвэрлэх боломжтой юм. “Ашиг сонирхлын зөрчил гэдэг ойлголт нь заавал буруу үйлдлийг хэлдэггүй харин буруу үйлдэл

² НҮБ-ын Авлигын эсрэг конвенци, Авлигын эсрэг эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл, УБ, 2016;

³ М.Полейни, НҮБАЭЖ-ийн гарын авлага, 2015, Лондонгийн Олон улсын хуулийг практикт хэрэгжүүлэх төв, Авлигын эсрэг форум;

хийж болзошгүй байдлыг хэлдэг” гэж судлаач эрдэмтэн В.Спек өгүүлсэн байдаг. Албан тушаалтны албан үүргээ гүйцэтгэх явцад нийтийн ашиг сонирхол түүний бусад сонирхлуудтай зөрчилдөх нөхцөл байдал үүссэн, үүсэж болзошгүй тийм байдал тулгарч болохоор байна.

Байгууллага дахь авлигаас урьдчилан сэргийлэх хамгийн чухал арга хэрэгслийн нэг бол ашиг сонирхлын зөрчлийг илрүүлэх, шийдвэрлэх явдал юм. Байгууллагууд, ялангуяа төрийн оролцоотой байгууллагууд авлигатай тэмцэх арга хэмжээний тогтолцоог бүрдүүлэхдээ энэ хэрэгсэлд ихээхэн анхаарал хандуулах бөгөөд хувийн байгууллагуудын хувьд ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах нь корпорацийн луйвартай тэмцэх хүрээнд хамааралтай болно.

Ашиг сонирхлын зөрчил нь тухайн байгууллагад үргэлж сөрөг үр дагаварт хүргэдэггүй ч тийм нөхцөл байдал нь байгууллагын хувьд олон тооны эрсдэлийг дагуулдаг. Байгууллагад эерэг үр дагаварт хүргэх шийдвэр гарсан ч ашиг сонирхлын зөрчилтэй байгаа тохиолдолд ийм нөхцөл байдал нь байгууллагын ажилтнуудын бодитой байдлын талаар эргэлзээ төрүүлж, компанийн соёлыг алдагдуулж болзошгүй юм. Үүнтэй холбогдуулан ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх журамтай холбоотой зохих бодлого боловсруулах нь байгууллагуудын удирдлагын үүрэг байна. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх арга хэмжээ авах хүсэлтэй байгууллага нь байгууллагын нийт ашиг сонирхол, байгууллагын ажилчдын хувийн ашиг сонирхлын тэнцвэрийг хадгалах хүнд хэцүү асуудалтай тулгардаг.

Нэг талаас, байгууллагын ажилтнууд үндсэн ажлаасаа чөлөөт цагаараа бусад өмчийн харилцаанд орох эрхтэй. Нөгөөтгээгүүр, ажилтны хувийн үйл ажиллагаа, түүнчлэн ажилчдын гэр бүлийн болон бусад хувийн харилцаа нь байгууллагын ашиг сонирхолд харшлах магадлалтай. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх байгууллагын үйл ажиллагааны гол зорилго нь ажилчдын гүйцэтгэж буй хөдөлмөрийн чиг үүрэг, бизнесийн шийдвэрт хувийн ашиг сонирхлын нөлөөллийг хязгаарлах явдал юм.

Энэхүү хэрэгслийн өндөр ач холбогдол нь түүний хэрэглээ нь авлигын гэмт хэрэг үйлдэхээс өмнөх нөхцөл байдлыг нэн даруй илрүүлж, зохих хариу арга хэмжээг цаг тухайд нь авах боломжтой болсонтой холбоотой юм. Энэ тохиолдолд зохицуулалтын объект нь ажилтан нь өөрт нь олгосон эрх мэдэл, нөөцийг ажлын үүргээ биелүүлэх, байгууллагын зорилгод хүрэхэд хувь нэмрээ оруулах бус харин өөртөө болон түүнтэй гэр бүл, эд хөрөнгийн болон

бусад харилцаатай холбоотой хүмүүсийн хувьд төлөвлөөгүй үр өгөөж авах боломжийг олж авах нөхцөл байдал юм.

Нөхцөл байдал нь энэ төрлийн эрсдэлд онцгой өртөмтгий байдаг бөгөөд энэ нь ажил үүргээ гүйцэтгэхдээ ажилтанд энэ болон хязгаарлагдмал тэтгэмжийг хэний талд хуваарилахыг сонгох эрх мэдэлтэй байдаг. Ажилтан өөртэй нь холбоотой хүмүүс эсвэл ажилтны хувьд «гаднын» хүмүүст ийм “тэтгэмж” олгох сонголттой тулгарвал тэрээр уруу таталтад автаж, бодитой байдлаа алдаж, хуульд заасан шалгуурыг баримтлахаа больж болох бөгөөд түүнийг ажил олгогчоос гаргаж, хөдөлмөрийн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй гэж үзнэ.

Ашиг сонирхлын зөрчил нь өөрөө гэмт хэрэг биш бөгөөд авлигатай адилгүй гэдгийг ойлгох хэрэгтэй: хувийн ашиг сонирхлоо хэрэгжүүлэх боломж байсан ч ажилтан боломжит тэтгэмжээс татгалзаж, үүргээ зохих ёсоор гүйцэтгэх боломжтой. Гэсэн хэдий ч ашиг сонирхлын зөрчил нь авлигын гэмт хэрэг болон даамжирдаг тул ийм нөхцөл байдлыг илрүүлж, зохицуулах арга хэмжээ авах нь байгууллагын тулгамдсан асуудал байна.

Байгууллага дахь ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах үндэс нь:

- бодит болон болзошгүй ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээллийг задруулах;
- ашиг сонирхлын зөрчил бүрийг тодорхойлох, түүнийг шийдвэрлэхэд тухайн байгууллагын нэр хүндийн эрсдэлийг нэг бүрчлэн авч үзэх, үнэлэх;
- ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээллийг задруулах үйл явц, түүнийг шийдвэрлэх үйл явцын нууцлал;
- ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэхдээ байгууллага, ажилтны ашиг сонирхлын тэнцвэрийг хадгалах;
- ажилтны ашиг сонирхлын зөрчлийг нэн даруй илчилж, байгууллага шийдвэрлэсэн (урьдчилан сэргийлсэн) талаар мэдээлэлтэй холбогдуулан ажилтныг яллахаас хамгаалах зэрэг нөлөөллийн зарчмуудыг ашиглаж болно.

Байгууллага дахь ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах механизмыг нэвтрүүлэхдээ одоогийн байдлаар хууль тогтоомжид ашиг сонирхлын зөрчил гэсэн ойлголт, түүнийг шийдвэрлэх журмын янз бүрийн тодорхойлолтыг

тусгасан болохыг анхаарч үзэх нь чухал болно.

Ашиг сонирхлын зөрчил нь аливаа байгууллагын нэр хүнд, үйл ажиллагаанд хохирол учруулж, албан хаагчдын итгэх итгэлийг сулруулдаг тул шударга шийдвэр гаргах хэрэгтэй төдийгүй шийдвэр шударга гарч байгаа гэдэгт эргэлзээ төрүүлэхгүй байх явдал юм.

Тухайлбал, ОХУ-ын «Авлигатай тэмцэх тухай» хуульд “ашиг сонирхлын зөрчил” гэсэн ойлголтыг “Албан тушаал эрхэлж буй хүний хувийн ашиг сонирхол (шууд болон шууд бус) нь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх арга хэмжээ авах үүрэг бүхий албан тушаалыг зохих ёсоор, бодитой, шударга хэрэгжүүлэхэд нөлөөлж болзошгүй нөхцөл байдал түүний эрх мэдлээ хэрэгжүүлэх албан ёсны үүрэг болно⁴ гэж тодорхойлсон байна.

Түүнчлэн “Авлигатай тэмцэх тухай” Холбооны хуульд “хувийн ашиг сонирхол”⁵ гэсэн ойлголтод тухайн зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээдийн мөнгө, бусад эд хөрөнгө, түүний дотор эд хөрөнгийн эрх, эд хөрөнгийн үйлчилгээ, гүйцэтгэсэн ажлын үр дүн эсвэл аливаа ашиг тус (давуу тал) хэлбэрээр орлого олж авах боломж, ба эсхүл түүний ойр дотнын хүмүүс (эцэг эх, эхнэр, нөхөр, хүүхэд, ах, эгч, дүү) болон (эсвэл) түүнтэй нягт холбоотой хүмүүс эд хөрөнгө, аж ахуйн нэгж, бусад ойр дотно харилцаатай байдаг иргэн, байгууллагын өмч гэсэн тодорхойлолтыг тусгажээ.

Зарим ангиллын байгууллагууд нь тухайн байгууллагын үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрийг зохицуулж, холбогдох ойлголт, тэдгээрийн тодорхойлолт, (эсвэл) тайлбарыг агуулсан зохицуулалтыг дагаж мөрдөх ёстой.

“Ашиг сонирхлын зөрчил” гэсэн ойлголтыг тодорхойлоход сонгосон арга барилаас үл хамааран тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг харгалзан ашиг сонирхлын зөрчлийн ердийн нөхцөл байдлын жагсаалтыг гаргадаг байна. Энэ нь албан хаагчид “ашиг сонирхлын зөрчил” гэсэн тодорхойлолт нь тэдний өдөр тутмын ажлын үйл ажиллагаатай хэрхэн холбогдож байгааг ойлгоход зайлшгүй шаардлагатай.

⁴ 2008 оны 12 дугаар сарын 25-ны N 273-ФЗ “Авлигатай тэмцэх тухай” Холбооны хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг;

⁵ Авлигатай тэмцэх тухай” Холбооны хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг;

Ашиг сонирхлын зөрчил байгаа эсэхийг тодорхойлохдоо дараах нөхцөл байдал нэгэн зэрэг байгааг:

1. Хувийн ашиг сонирхол байгаа эсэх;

2. Албан тушаалтан хувийн ашиг сонирхлыг хэрэгжүүлэх бодит эрх мэдэлтэй байх;

3. Албан тушаалтан болон (эсвэл) түүний хувийн ашиг сонирхолд холбогдсон хүмүүсийн орлого, ашиг тусыг хүлээн авах (хүлээн авах боломж) болон албан тушаалтан түүний бүрэн эрхийг хэрэгжүүлэх (боломжтой хэрэгжих) хоорондын холбоо байгаа эсэхийг зайлшгүй харгалзан үзнэ.

Нөхцөл байдлыг ашиг сонирхлын зөрчил гэж ангилахдаа ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, (эсвэл) шийдвэрлэх арга хэмжээ аваагүй тохиолдолд хуулийн хариуцлага хүлээлгэдэг байна.

Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах тогтолцоог бий болгохдоо энэ үйл явц нь ажил олгогч болон албан хаагчдын оролцоог шаарддаг гэдгийг санах нь зүйтэй. Ийм тогтолцооны гол элементүүд нь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шийдвэрлэх явдал юм.

1. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь:

- албан хаагчдыг ашиг сонирхлын зөрчилтэй байдалд оруулахад хүндрэл учруулдаг авлигатай тэмцэх арга хэмжээний сайн боловсруулсан тогтолцоог (жишээлбэл, ажилтны үүрэг хариуцлагатай холбогдуулан түүний ашиг сонирхлыг сонирхож буй хүмүүсээс бэлэг сэлт авах онцлогийг тогтоох) бүрдүүлэх;
- хүний нөөцийн шийдвэр гаргах, үүрэг хариуцлагыг хуваарилахдаа ашиг сонирхлын зөрчил үүсэх магадлалыг тодорхойлох шалгалтын журмыг нэвтрүүлэх зэрэг зүйлийг агуулна.

2. Ашиг сонирхлын зөрчлийг тодорхойлохдоо:

- ажилтны тодорхой (хувийн) ашиг сонирхол байгаа тухай мэдүүлэг;
- мэдэгдлийг ажилд авсны дараа нь тогтмол (жишээлбэл, жил бүр) болон (эсвэл) нөхцөл байдлын дагуу (тодорхой нөхцөл байдал үүссэн тохиолдолд шууд) хийж болох зүйлс орно.

Байгууллага дахь авлигаас урьдчилан сэргийлэх үүрэг бүхий нэгж (албан тушаалтан) ашиг сонирхлын зөрчлийн нөхцөл байдлыг бие даан тодорхойлох, ажилтны өгсөн мэдээллийг төрийн болон арилжааны янз бүрийн мэдээллийн

санд байгаа мэдээлэлтэй харьцуулах замаар (жишээлбэл, хуулийн этгээдийн улсын нэгдсэн бүртгэл, хувиараа бизнес эрхлэгчдийн улсын нэгдсэн бүртгэл, гэх мэт) шалгах бөгөөд боломжтой бол тухайн байгууллагад ашиг сонирхлын зөрчлийг илрүүлэхэд чиглэсэн тусгай программ хангамжийг нэвтрүүлж хөгжүүлэх нь чухал байна.

Ашиг сонирхлын зөрчлийг илрүүлэхийн тулд албан хаагчид өөрсдийн ашиг сонирхлын мэдүүлгийг заавал биелүүлэх ёстой. Мэдэгдлийн хэлбэр, түүнийг хэлэлцэх журмыг боловсруулахад онцгой анхаарал хандуулах шаардлагатай юм.

Ашиг сонирхлын мэдүүлэг нь албан хаагчид болон ажил олгогчийн хувьд нэлээд ачаалалтай журам гэдгийг санах нь зүйтэй. Үүнтэй холбогдуулан ямар албан хаагчийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах, мэдүүлгийн маягтыг хэр нарийвчилсан байх зэрэг асуудлыг шийдвэрлэхдээ тухайн байгууллага, авлигатай тэмцэх үүрэг бүхий албан хаагчдын мэдүүлэг цуглуулах, боловсруулах бодит чадамжийг үнэлэх нь чухал болно.

Иймээс уг мэдэгдлийг байгууллагын бүх ажилчдад биш, зөвхөн тодорхой хүрээний хүмүүст хамруулах нь зүйтэй бөгөөд тэдгээрийн жагсаалтад юуны түрүүнд авлигын эрсдэл нэмэгдэж буй албан тушаалтай ажилчдыг оруулах ёстой. Өгөгдсөн мэдээллийн хэмжээ, нарийвчилсан байдлаараа ялгаатай янз бүрийн ангиллын ажилтнуудад мэдүүлгийн янз бүрийн хэлбэрийг ашиглах боломжтой. Өөр нэг хувилбар бол байгууллагын ажилтнуудад нөхцөл байдлын мэдүүлэг өгөх, албан тушаал нь авлигын эрсдэл ихэссэн ажилтнуудад тогтмол мэдүүлэг өгөх явдал юм.

Өгөгдсөн мэдээллийн анхан шатны дүн шинжилгээ хийх цахим мэдүүлгийн маягт, программыг ашиглах нь холбогдох мэдээллийг цуглуулах, боловсруулах үйл явцыг ихээхэн хөнгөвчлөх боломжтой.

3. Ашиг сонирхлын зөрчлийг янз бүрийн аргаар шийдвэрлэх боломжтой.
Жишээлбэл:

- ажилтны ажил үүргээ гүйцэтгэх явцад ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй байдалд тавих хяналтыг сайжруулах;
- ажилтныг хувийн ашиг сонирхол нь холбоотой хуулийн этгээд, хувь хүнтэй холбоотой үйлдэл хийхээс (шийдвэр гаргахаас) хасах;
- ашиг сонирхлын зөрчилд хүргэж болзошгүй мэдээлэлд ажилтны хандалтыг хязгаарлах;

- ажилтныг бүтцийн нэгж болон байгууллагын өөр нэгжид өөр ажилд шилжүүлэх;
- ашиг сонирхлын зөрчлийн шалтгаан болсон, хүлээн авсан эсвэл авахаар хүлээгдэж буй тэтгэмжээс татгалзах тухай ажилтны санал зэрэг орж болно.

Ашиг сонирхлын зөрчлийг үр дүнтэй шийдвэрлэхийн тулд албан хаагчдыг авлигын гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх хамгийн чухал арга хэмжээг тодорхойлохын тулд тодорхой нөхцөл байдал бүрийг нарийвчлан шинжлэх шаардлагатай гэдгийг анхаарах нь зүйн хэрэг. Зарим тохиолдолд, ялангуяа томоохон аж ахуйн нэгжүүдэд ашиг сонирхлын зөрчлийн нөхцөл байдлын талаар мэргэшсэн зөвлөлдөх байгууллагын оролцоотойгоор хэлэлцэх боломжийг олгох нь (жишээлбэл, албан ёсны үйл ажиллагаа, зөрчлийг шийдвэрлэх шаардлагыг дагаж мөрдөх комисс) чухал байна.

Өнөөгийн байгаа ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэхдээ одоо байгаа нөхцөл байдлыг харгалзан шийдвэрлэх хамгийн «зөөлөн» арга хэмжээг сонгохыг анхаарах нь зөв болно. Илүү хатуу арга хэмжээг зөвхөн бодит хэрэгцээ байгаа эсвэл «зөөлөн» арга хэмжээ хангалттай үр дүнд хүрээгүй тохиолдолд л хэрэглэнэ. Ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэх тодорхой аргыг сонгохдоо албан хаагчдын хувийн ашиг сонирхлын ач холбогдол, энэ хувийн ашиг сонирхол нь байгууллагын ашиг сонирхлыг хохироох магадлалыг харгалзан үзэх нь чухал юм.

Бичил аж ахуйн нэгж, жижиг, дунд үйлдвэрийн ажилчдын ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх боломжит арга замуудын нэг бол хамтын шийдвэр гаргах явдал юм. Энэ хандлагыг юуны түрүүнд тухайн байгууллагын бүтцийн онцлогоор тодорхойлдог. Тиймээс, эдгээр нөхцөл байдалд ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд, жишээлбэл, ажилтны хувийн ашиг сонирхол бүхий бизнесийн түнштэй гэрээ байгуулахдаа тухайн байгууллагын ажилтан ийм гэрээ байгуулах талаар эцсийн шийдвэр гаргах эрхтэй эрх бүхий албан тушаалтан (жишээлбэл, байгууллагын орлогч дарга) холбоо барих нь чухал болно.

Үүний зэрэгцээ тодорхой төрлийн байгууллагууд (хувьцаат компани, хязгаарлагдмал хариуцлагатай компани, ашгийн бус байгууллага) нь сонирхогч талуудын гүйлгээг зохицуулахтай холбоотой одоогийн хууль тогтоомжийн шаардлагыг харгалзан үзэх ёстой. Ийм хэлцлийн хяналтын арга хэмжээ,

түүний дотор нэмэлт зөвшөөрөл олгох журмыг нэвтрүүлэх нь ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах тогтолцооны нэг хэсэг гэж үзэж болно.

Сонирхсон этгээдийн гүйлгээтэй холбоотой заалтуудыг агуулсан зохицуулалтын эрх зүйн актад:

- Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам;
- Ашиг сонирхлын зөрчлийн заалтад хамаарах хүмүүсийн хүрээ;
- Байгууллага дахь ашиг сонирхлын зөрчлийг илчлэх, шийдвэрлэх зарчим;
- Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ил болгох, шийдвэрлэхтэй холбогдсон албан хаагчдын үйл ажиллагаа, түүнийг хэрэгжүүлэх журам;
- Ашиг сонирхлын зөрчлийг ил болгох журам (мэдэгдэл);
- Үүссэн ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авсан хариуцлагатай этгээдийг тодорхойлох, уг мэдээллийг авч үзэх зэрэг асуудлыг багтааж болохоор байна.

Төрийн албан хаагч нь ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүрэгтэй.

Сонирхлын зөрчлөл - албан тушаал эрхэлж буй этгээдийн (албан тушаалтан) хувийн ашиг сонирхол (шууд болон шууд бус)-д нөлөөлж, түүнийг орлуулах нь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх арга хэмжээ авах үүрэг бүхий нөхцөл байдал эсвэл албан үүргээ (бүрэн эрхээ хэрэгжүүлэх) зүй зохистой, бодитой, шударга бус биелүүлэхэд нөлөөлж болно. Ашиг сонирхлын зөрчлийн үед албан тушаалтны хувийн ашиг сонирхол - мөнгө, үнэт зүйл, бусад эд хөрөнгө, эд хөрөнгийн үйлчилгээ хэлбэрээр ашиг тус хүртэх боломж, бусад хүмүүсийн эрх ба эсвэл албан хаагчид, иргэд, байгууллага, нийгэм, төрийн хооронд хууль ёсны ашиг сонирхлын зөрчил үүсдэг.

Хувийн ашиг сонирхол - албан тушаалтан болон (эсвэл) түүнтэй ойр холбоотой хүмүүсээс мөнгө, бусад эд хөрөнгө, түүний дотор эд хөрөнгийн эрх, эд хөрөнгийн шинж чанартай үйлчилгээ, гүйцэтгэсэн ажлын үр дүн, ашиг тус (давуу тал) хэлбэрээр орлого олж авах боломж түүний (эцэг эх, эхнэр, нөхөр, хүүхэд, ах, эгч, дүү, тэдгээрийн хүүхэд, эхнэр, нөхөр) түүнтэй ойр холбоотой байгаа иргэн, байгууллага, өмч хөрөнгө, корпорац гэх мэт бусад ойр дотно харилцаагаар илэрдэг байна.

Хувийн ашиг, сонирхлын шууд ба шууд бус хэлбэр, эдийн засгийн ашгийн зөрчлөлийн болон улс төрийн ашиг сонирхлын зөрчлийн хүрээ, төрийн албанд элсүүлэх албан ёсны ашиг сонирхлын зөрчлийн талбарыг хүснэгтээр харуулав.

1 дүгээр хүснэгт

Хувийн ашиг, сонирхлын хэлбэр, хүрээ, талбар

ХУВИЙН АШИГ СОНИРХОЛ	
Хувийн ашиг сонирхлын тухай албан тушаалтан, түүний гэр бүлийн гишүүд, хамаатан садан, бусад иргэн, байгууллагатай найрсаг, ажил хэргийн харилцаатай байгаа бусад иргэн, байгууллага мөнгөн болон эд хөрөнгийн үндэслэлгүй орлого, эд хөрөнгийн болон бусад ашиг тусыг авах боломж	
ШУУД	ШУУД БУС
Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүнд албан тушаалтны бусад ашиг сонирхол	Ихэвчлэн хяналтгүй, албан тушаалтны албан үүргээс давсан хүчин зүйлийг харгалзан үзэх шаардлагатай.
ЭДИЙН ЗАСГИЙН АШГИЙН ЗӨРЧЛӨЛИЙН ХҮРЭЭ	
<ul style="list-style-type: none">- Хяналтын болон захиргааны чиг үүргийг хэрэгжүүлэх;- Уралдаан, тендер, худалдан авалтыг зохион байгуулах, явуулах;- Төрийн болон хотын өмчийн менежмент;- Төрийн болон хотын өмчийг хувьчлах;- Тодорхой төрлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл.	
УЛС ТӨРИЙН АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨЛИЙН ХҮРЭЭ	
<ul style="list-style-type: none">- Албан ёсны үйл ажиллагааг олон нийтийн холбооны удирдах байгууллагын гишүүнчлэлтэй хослуулсан тохиолдолд олон нийтийн холбоог хувийн ашиг сонирхлоо хэрэгжүүлэхэд ашиглах; - Сонгууль, бүх нийтийн санал асуулга явуулах үед захиргааны нөөц ашиглах;- Олон нийтийн байгууллага, иргэдийн холбоог бүртгэх;- Нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон хотын төрийн байгууллагуудын олон нийтийн байгууллага, иргэдийн холбоодтой харилцах;- Гадаад харилцаа холбоо.	

**ТӨРИЙН АЛБАНД ЭЛСҮҮЛЭХ АЛБАН ЁСНЫ АШИГ СОНИРХЛЫН
ЗӨРЧЛӨЛИЙН ТАЛБАР**

- Төрийн албанаас халах;
- Ажлын үүргийн хуваарилалт;
- Албан тушаал ахих, ажил мэргэжлийн өсөлт;
- Урамшуулал, торгууль;
- Нууц мэдээллийг задруулах;
- Нэг талын давуу тал олгох;
- Бэлэг, эд хөрөнгийн үйлчилгээ, бусад материаллаг бараа, ашиг тусыг хүлээн авах;
- Зохион байгуулалт, засаг захиргаа, эдийн засгийн чиг үүргийг хэрэгжүүлэх, хяналт, хяналтын үйл ажиллагаа;
- Төрийн худалдан авалт, төрийн үйлчилгээ үзүүлэх, санхүүгийн болон бусад эх үүсвэрийг хуваарилах зэрэг эрх мэдэл, удирдлагын бүрэн эрх бүхий этгээдэд авлигын эсрэг хязгаарлалт, хориглолт, үл хөдлөх хөрөнгийн менежмент үүргийг тогтоох гэх мэт.

Дээрхтэй холбогдуулан ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, (эсвэл) шийдвэрлэх арга хэмжээ авах үүргийг төрийн болон хотын албан хаагчид болон бусад ангиллын хүмүүс гэсэн байдлаар хэрэгжүүлдэг.

Ашиг сонирхлын зөрчлийг илрүүлэх, шийдвэрлэх арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд ажилтнууд өөрсдийн үйлдлээ үнэлж дүгнэх, ашиг сонирхлын зөрчлийг илрүүлж сурах, албан ёсны харилцааны бусад хэлбэрээс ялгах чадвартай байх ёстой.

Ашиг сонирхлын зөрчлөлийг тогтоох арга зам нь:

- ашиг сонирхлын зөрчлийн тухай албан тушаалтны хувийн мэдүүлэг;
- албан тушаалтны хууль бус үйлдлийн хохирогч болсон гэж үзэж буй хувь хүн, хуулийн этгээдийн мэдэгдэл;
- тухайн улсын хууль тогтоомжийн дагуу албан тушаалтнуудын өөрсдийнхөө талаар өгсөн мэдээллийн материалд дүн шинжилгээ хийх;
- төр, иргэний ашиг сонирхлыг хохироож болзошгүй ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэж буй гуравдагч этгээдийн мэдэгдэл, тэр дундаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мессежээр тогтоогдоно.

Ашиг сонирхлын зөрчлийг тогтоохдоо: ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх; болзошгүй ашиг сонирхлын зөрчлийг тодорхойлох; ашиг сонирхлын зөрчлийн сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэхэд анхаарах болно.

Ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн асуудлаар шийдвэр гаргахад албан тушаалтан оролцохоос бусад ашгийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зүйд;

- ашиг сонирхлын зөрчил үүсэх үед албан тушаалтны үүргээ биелүүлэхэд тавих хяналтыг бэхжүүлэх;
- ашиг сонирхлын зөрчилд оролцогч албан тушаалтны албан тушаал, албан тушаалын байдал өөрчлөгдсөн;
- албан тушаалтныг албан үүргээс нь чөлөөлөх;
- ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн тэтгэмжээс татгалзах;
- сахилгын зөрчлийн шинж тэмдэг илэрсэн, албан тушаалтанд сахилгын хариуцлага хүлээлгэх нөхцөл байдал тогтоогдвол, захиргааны зөрчил, гэмт хэрэг тогтоогдвол хууль сахиулах байгууллагад мэдээлэл шилжүүлэх;
- ашиг сонирхлын зөрчилд оролцогч албан тушаалтан өөрөө татгалзах зэрэг орно.

Төрийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны хүрээнд авлига гэж үзэж болох үйлдлүүд нь дараах шинж чанараар:

- тусгай байгууллага (дүрмээр бол өргөн эрх мэдэлтэй төрийн албан хаагчид) үйлдсэн;
- холбогдох албан тушаалтны албан тушаал, эрх мэдлийн улмаас үйлдсэн;
- албан тушаалтны хувийн ашиг тусыг олж авахад чиглэсэн байх;
- төрийн хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн;
- албан тушаалтан санаатайгаар үйлдсэн;
- албан тушаалтанд нэг буюу өөр төрлийн цалин хөлс (жишээлбэл, хахууль гэх мэт) өгөхийг санал болгож буй хүний ашиг сонирхлын үүднээс хийгдсэн зэргээр тодорхойлогдоно.

Ихэнхдээ бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа ашиг сонирхлын зөрчил үүсэх нь дараах нөхцөл байдалтай:

а. ханган нийлүүлэгчийг тодорхойлох журамд оролцогч өрсөлдөгч (дуудлага худалдаа, үнийн санал) - ийг комиссын гишүүний ойрын хамаатан садан эсвэл албан тушаалтныг ажиллуулдаг байгууллагыг тодорхойлох;

б. өрсөлдөөний (дуудлага худалдаа, үнийн санал) комиссын гишүүн, эсвэл ханган нийлүүлэгч (гүйцэтгэгч, биелүүлэгч) - ийн тодорхойлолтоос

хамаарах албан тушаалтны дүрмийн санд хувь эзэмшдэг байгууллага, тухайн байгууллагыг үүсгэн байгуулагчид эсвэл эдгээр хүмүүс хамтран ажилладаг өрсөлдөгч оролцох;

в. удирдах албан тушаал хашиж байсан албан тушаалтан, эсвэл өрсөлдөөний (дуудлага худалдаа, үнийн санал) комиссын гишүүн, өмнө нь өрсөлдөөнд оролцох хүсэлт гаргасан байгууллагад хөдөлмөрийн чиг үүргийг гүйцэтгэж байсан;

г. өрсөлдөөний журамд оролцох хүсэлт гаргасан хуулийн этгээдийн байгууллага, удирдлагын байгууллагад өмнө нь энэ байгууллагад удирдах албан тушаал хашиж байсан, эсвэл хяналтын чиг үүрэг гүйцэтгэж байсан хүн ажиллаж байгаа;

д. албан тушаалтан нь оюуны үйл ажиллагааны үр дүнд бий болсон бараа бүтээгдэхүүнийг худалдан авах шийдвэр гаргахад оролцож, түүний онцгой эрх, түүний хамаатан садан эсвэл энэ ажилтны хувийн ашиг сонирхол холбогдсон бусад хүмүүс;

е. ханган нийлүүлэгчийг (гүйцэтгэгч, гүйцэтгэгч) тодорхойлох өрсөлдөөнт журамд оролцох хүсэлт гаргасан байгууллагын өөрийн үнэт цаасны албан тушаалтан (түүний хамаатан садан, эсвэл дуудлага худалдаа, үнийн санал өгөх) ба комиссын гишүүд;

ж. албан тушаалтан, түүний хамаатан садан, хувийн ашиг сонирхол бүхий бусад хүмүүс нь үйл ажиллагаанд оролцож буй хувь хүн, байгууллагаас бэлэг, бусад хөнгөлөлт (үнэгүй үйлчилгээ, хөнгөлөлт, зээл, зугаа цэнгэл, амралт, аяллын зардал гэх мэт) авахаар өрсөлдөөний журам, эсвэл төрийн гэрээ байгуулсан байдагтай холбоотой байна.

Ашиг сонирхлын зөрчлийн өвөрмөц байдал, түүний илрэлийн олон янз байдал нь ямар нэгэн хатуу хууль тогтоомжийн хүрээнд хязгаарлах боломжгүй юм. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа хамгийн түгээмэл авлига, ашиг сонирхлын зөрчлийн бүдүүвч нь:

- Хуйвалдаанд оролцож буй боломжит ханган нийлүүлэгч бусад худалдан авалтад оролцогчдоос илт доогуур үнийн дүнтэй өргөдөл гаргах;
- Захиалагчийн зүгээс гэрээг хэрэгжүүлэх маш богино хугацааг тогтоох, энэ тохиолдолд гэрээг зөвхөн урьдчилан бэлтгэсэн ханган нийлүүлэгч - луйврын системд оролцогчоор гүйцэтгэх боломжтой байх;

- засгийн газрын захиалгыг тодорхой хэмжээгээр гүйцэтгэхэд бусад боломжит ханган нийлүүлэгчдийн сонирхлыг татахгүй байх, зориудаар өрсөлдөх чадваргүй үнийг тогтоох;
- засгийн газрын захиалгыг гүйцэтгэхэд тааламжгүй төлбөрийн бүдүүвчийг бий болгох (жишээлбэл, удаан хугацаагаар хойшлуулах гэх мэт);
- худалдан авах ажиллагааны мэдээллийн нэгдсэн системд өгөгдлийг буруу оруулах (жишээлбэл, худалдан авах ажиллагааны мэдэгдлийн нэрийг бичихдээ кирилл, латин үсгийг холих);
- худалдан авах ажиллагаанд оролцогчдын хүсэлтийг сонирхогч талуудын үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийн тайлбарыг бүрэн гүйцэд биш хийх гэх мэт бүрдэлтэй байдаг зэрэг болно.

Энэхүү бүдүүвчийн мөн чанар нь хуйвалдаанд оролцож буй шударга бус ханган нийлүүлэгч нь худалдан авалтын параметрууд юу болохыг үргэлж мэдээлж байх явдал юм. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа ашиг сонирхлын зөрчлийг тодорхойлохын тулд худалдан авалтад оролцогчдын харьяалалд дүн шинжилгээ хийж, шалгах шаардлагатай болно.

Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх арга хэмжээ аваагүй, түүний дотор ашиг сонирхлын зөрчил, үүсэх боломжийн талаар ажил олгогчийн төлөөлөгчдөд мэдэгдээгүй тохиолдолд албан тушаалтанд хуулийн хариуцлага хүлээлгэж болно.

Дүгнэлт:

Ашиг сонирхлын зөрчил нь нэг талаас нийтийн албан тушаалтны ёс зүйн асуудал, нөгөө талаасаа авлигын урьдчилсан нөхцөл, шалтгаан бөгөөд албан тушаалтныг ажил үүргээ гүйцэтгэхэд хувийн сонирхол нь зүй бусаар нөлөөлсөн үед авлига үүснэ. Ашиг сонирхлын зөрчил нь авлига биш, харин авлига бий болох хөрс суурь, шалтгаан болдгоороо ялгаатай байна. Нэг үгээр хэлбэл, авлига бол ашиг сонирхлын зөрчлийн төгсгөлийн үе шат юм. Түүнчлэн авлига нь гэмт хэрэг бол ашиг сонирхлын зөрчил нь авлигатай харьцуулахад албан тушаалаа зүй бусаар ашиглан хувьдаа санхүүгийн ашиг олохгүй ч албан үүргээ танил тал, ар өврийн хаалга харсан, алагчилсан байдлаар гүйцэтгэхэд хүргэдэг тодорхой гэмт хэрэг болж хуульчлагдаагүй олон төрлийн зан үйлийн асуудлын хэлбэрийг багтаадаг байна. Иймээс төрийн албан тушаалтны хувийн

сонирхол албан үүрэгтэй зөрчилдөхөд үүнийг зөв тодорхойлж, зөв удирдаж, оновчтой зохицуулахгүй бол ашиг сонирхлын зөрчил нь төрийн болон байгууллагын нөөц, боломжийг буруу аргаар ашигласан хууль бус үйлдэл, явцдаа авлига болж хувирдаг байна.

Авлига нь цаг ямагт өөртөө ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг агуулдаг бол харин ашиг сонирхлын зөрчлийн тохиолдол бүр авлига болдоггүй. Тиймээс ашиг сонирхлын зөрчлийг дүрэм, журмын хүрээнд зохицуулах нь авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх чухал түлхүүр юм

Эх сурвалж:

1. **Монгол Улсын хууль.** 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр. “Нийгмийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”. 3.1.9.заалт; <https://legalinfo.mn/mn/detail?lawId=397>;

2. НҮБ-ын Авлигын эсрэг конвенц, Авлигын эсрэг эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл, УБ, 2016;

3. М.Полейни, НҮБАЭЖ-ийн гарын авлага, 2015, Лондонгийн Олон улсын хуулийг практикт хэрэгжүүлэх төв, Авлигын эсрэг форум;

4. 2008 оны 12 дугаар сарын 25-ны N 273-ФЗ “Авлигатай тэмцэх тухай” Холбооны хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг;

5. “Авлигатай тэмцэх тухай” Холбооны хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг;



Н.МАНЛАЙБААТАР

*Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний
хүрээлэнгийн Аюулгүй байдал судлалын төвийн эрхлэгч,
цагдаагийн дэд хурандаа*

МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА: ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, АНХААРАХ АСУУДАЛ

Товч агуулга: Мөрдөн шалгах ажиллагаа нь эрх зүйн зохицуулалтын хувьд сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд өөрчлөлт, шинэчлэлтээр баяжин, хүний эрх суурьтай хөгжих зүй тогтолд нэгэнт шилжсэн билээ. Бид уг өгүүллээр мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн зохицуулалтын шинэчлэл, өөрчлөлт, түүнд нөлөөлж ирсэн зарим хүчин зүйлийг тодорхойлохыг зорилоо.

Түлхүүр үгс: Мөрдөн шалгах ажиллагаа, эрүүгийн процесс, гэмт хэрэг, мөрдөн байцаалт, уламжлал, шинэчлэл

Шинжлэх ухааны мэдлэгийн тогтолцоо баяжин хөгжихөд хууль зүйн шинжлэх ухааны мэдлэгийн тогтолцоо боловсронгуй болж, бидний судлан буй мөрдөн байцаалт ч шинэчлэгдэн, өөрчлөгдөж, шинэ чиг хандлагатайгаар хөгжих нөхцөл нэгэнт хэлбэржин тогтоод 30 гаруй жил болжээ.

Өөрөөр хэлбэл, 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хуульд зааснаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан хуулиудыг тогтоосон хуваарийн дагуу 1993 онд багтаан батлан гаргах (Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг), мөн БНМАУ-ын олон улсын гэрээг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэх асуудлыг тухайн гэрээнд заасан болзол, журмын дагуу 1993 онд багтаан шийдвэрлэх, (Зургаадугаар зүйлийн 3 дахь хэсэг), хууль тогтоомжийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн бүрэн шинэчлэх ажлыг 1996 онд багтаан

дуусгах (Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэг) зорилтыг хуульчлан тодорхойлсон¹ бөгөөд 1992 оны VII дугаар сараас 1996 оны VII сар хүртэл хугацаанд 177 хууль баталж, 144 хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан² нь эрүүгийн процессыг өөрчлөх үндэслэл, хэрэгцээ, шаардлагыг нөхцөлдүүлсэн билээ.

Монгол Улсын Их хурлаас 1994 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж³ мөн оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн⁴ билээ. Уг өөрчлөлт нь нийгэм, эдийн засаг, улс төрийн тогтолцооны шинэчлэл, өөрчлөлттэй уялдаатайгаар хийгдсэн бөгөөд доктор, профессор Д.Зүмбэрэллхам “манай улсын байцаан шийтгэх ажиллагаа болон тогтолцоонд мэтгэлцэх зарчмын эзлэх байр суурь улам батжиж, энэ зарчмыг шүүн таслах ажиллагааны практикт хэрэгжүүлэх эрх зүйн орчин үндсэндээ бүрдлээ⁵ гэж дүгнэсэнтэй нэг байна. Мөн доктор, профессор Б.Бат-Эрдэнэ мэтгэлцээний сонгодог хэлбэр бол мэтгэлцээний эхлэл буюу гараа нь талуудад адил байх боломжийг хангаж өгөхийг ихээхэн чухал гэж үздэг⁶ гэсэн нь манай улсад тэрхүү сонгодог хэлбэр төлөвших болоогүйг илэрхийлсэн. Нэгэнт мэтгэлцүүлэн шүүх тогтолцоо ийнхүү хэлбэржиж, бүрэлдэн төлөвшсөн нь мөрдөн байцаалт, түүний эрх зүйн зохицуулалт, зорилт, мөн чанарыг дахин авч үзэх шаардлагыг бий болгосон.

Нэгэнт хэргийн бодит байдлыг тогтоох, мэтгэлцүүлэн шүүх тогтолцооны холимог хэлбэр манай улсын эрүүгийн процесст нутагшиж буй нь мөрдөн байцаалтад гарах аливаа шийдвэрийг талууд мэтгэлцэх замаар шийдвэрлэх, улмаар тэрхүү шийдвэрийн үндэслэлийг шүүхээс хянах процесс одоогийн ЭХХШ тухай хуульд тусгалаа олоод байна. Тухайлбал: ЭХХШ тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.20 дахь заалтад “талууд гэж шүүх хуралдааны мэтгэлцээнд тэгш эрхтэй оролцож, яллах, өмгөөлөх чиг үүргийг хэрэгжүүлэгчийг”, 13.1 дүгээр зүйлд “Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах шүүхийн

¹ Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээ. Тайлан. Захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам. Нэгдсэн тайлан бэлтгэсэн: Т.Мэндсайхан нар. Уб., 2008. 5-6 дугаар тал.

² Эрх зүйн шинэтгэл ба үндэсний эрх зүйн тогтолцоо. Олон улсын симпозиум. Хууль зүйн яам, Улсын Их хурлын тамгын газар. Эмхэтгэн хэвлүүлсэн: Ханнс – Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар. 9 дэх тал.

³ Төрийн мэдээлэл сэтгүүл. Улсын Их хурал. Уб., 1994. №5 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Хууль зүйн үндэсний хүрээлэн. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал. (1911-2009 он) Уб., 2012. 318-364 дүгээр тал.

⁵ Д.Зүмбэрэллхам. Шүүхийн мэтгэлцээн. Уб., 2002. 17 дахь тал.

⁶ Хууль сахиулахын их сургууль. Хууль сахиулахуй. Онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл. №1. Уб., 2014. 34 дэх тал.

шийдвэр гаргах үндэслэл”-ийн 4 дэх хэсэгт “Шүүх энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан арга хэмжээг авахад яллах талд давуу байдал олгохгүй, эсхүл шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дордуулахгүй, талуудад мэтгэлцэх боломжийг тэгш хангана⁷” зэргээр хуульчилжээ. Энэ нь мөрдөн байцаалтыг илүү хариуцлагатай, нээлттэй, хүний эрхийг дээдэлсэн олон улсын чиг хандлагад нийцсэн хэлбэртэй явагдах суурь нөхцөлийг бүрдүүлж байна.

Мөрдөн байцаалт нь өөрийн зорилтоо хангах чиглэлээр тодорхой ажиллагаанаас бүрдсэн цогцолбор үе шат болохын хувьд бид эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход чиглэсэн хэд хэдэн онцлох зүйлсийг авч үзэж байна.

Хүчин төгөлдөр ЭХХШ тухай хуулийн зорилт нь “...гэмт хэргийг шуурхай бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон⁸...” гэсэн нь эрүүгийн процессын мөрдөх чиг үүргийг тодорхойлсон агуулга илэрхийлнэ. Харин мөрдөх чиг үүрэг нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанаас бүрдсэн цогц ажиллагаа бөгөөд эдгээр нь мөн өөр өөрийн зорилтыг хэрэгжүүлнэ. Тухайлбал, ЭХХШ тухай хуулийн Гучдугаар бүлэг: “Хэрэг бүртгэлт”-ийн талаар хуульчлан бэхжүүлсэн бөгөөд энэ бүлгийн 30.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: “Мөрдөгч гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн хуулийн этгээдийг олж тогтоох зорилгоор гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авснаас эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах хүртэл явуулж буй ... ажиллагааг хэрэг бүртгэлт гэнэ⁹” гэж тодорхойлжээ. Харин мөрдөн байцаалтын ажиллагааны талаар ЭХХШ тухай хуулийн Гучин нэгдүгээр бүлэг: “Мөрдөн байцаалт”-ын талаар хуульчлан бэхжүүлсэн бөгөөд энэ бүлгийн 31.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: “Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэнээс хэргийг шүүхэд шилжүүлэх хүртэл хэргийн талаар нотлогдвол зохих байдлыг тогтоох зорилгоор явуулж байгаа ... ажиллагааг мөрдөн байцаалт гэнэ¹⁰” хэмээн тодорхойлсон бөгөөд шүүхийн өмнөх шатанд гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн хуулийн этгээдийг олж тогтоон, нотлогдвол зохих байдлыг тогтооход чиглэсэн ажиллагаа болохыг илэрхийлж байна.

⁷ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12694>

⁸ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл: Уб., 2017. №23 дугаарт хэвлэгдсэн.

⁹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. Дурдсан бүтээл. Мөн тэнд.

¹⁰ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. Дурдсан бүтээл. Мөн тэнд.

Хэрэг бүртгэлтийн ажиллагааны талаар бид тусгайлан судлах шаардлагатайг дээр дурдсан тул мөрдөн байцаалтын зорилт, хэм хэмжээний талаар хууль тогтоогчийн үзэл баримтлал, хүсэл зориг юунд чиглэж байсан талаар авч үзэх нь зүйтэй.

Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэн нь мөрдөн байцаалт эхэлж байгааг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, мөрдөн байцаалт нь гэмт хэрэг илэрсний дараа явагдах ажиллагаа болохын хувьд нотолгооны зүйлийг тогтооход чиглэсэн байдгаараа онцлогтой. Бид нотлогдвол зохих байдлын тухай авч үзсэн.

Уг үзэл баримтлал, хэм хэмжээ нь 2013 оноос эхэлсэн Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд боловсрогдсон бөгөөд “мөрдөн байцаалт”-ын агуулгыг өөрчлөх, уг ажиллагааг явуулах албан тушаалтныг “мөрдөгч” гэж нэрлэх, түүнчлэн “байцаах” гэдэг үгнээс татгалзах, улмаар мөрдөн шалгах ажиллагаа явуулах арга, хэлбэрийг нэмэгдүүлэх, мөрдөгч бие даан явуулах мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын зөвшөөрлөөр явуулах мөрдөн шалгах ажиллагааг тодорхойлох, прокурорын зөвшөөрлийг тогтолцоог нарийвчлан тусгах, мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүн болох баримт, мэдээллийн талаар мөрдөгч магадалгаа үйлдэж мөрдөн шалгах ажиллагааны дүнг прокуророор баталгаажуулах¹¹ зэрэг үзэл санааг тууштай дэмжсэн билээ. Түүнчлэн, мөрдөн шалгах нууц ажиллагааг Улсын Ерөнхий прокурор, түүнээс эрх олгосон прокурор хяналт тавихаар хуульчилсан нь өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байна.

Хууль тогтоогчоос мөн гол анхаарлаа хандуулж байсан зүйл бол мөрдөн байцаалтыг явуулах албан тушаалтанд хялбар, амар байх нь зохисгүй гэж үзэж байсантай холбоотой асуудал бөгөөд энэ нь хуульд тусгалаа олсон билээ. Өөрөөр хэлбэл, мөрдөгч мөрдөн байцаалт явуулахад хүний эрхийг хязгаарлах буюу хүний халдашгүй эрхэд халдах тодорхой ажиллагаа явуулах бүрд прокурор, шүүхээс хянаж байхаар зохицуулсан явдал юм. Энэ нь тухайн үеийн улс төрийн нийтлэг хүсэл зориг болж байсан тул мөрдөх албадын төлөөлөл, эрдэмтэн судлаачид мөрдөн байцаалтыг бүхэлд нь прокурор чиглүүлж байх зохицуулалтыг тухайн үед төдий л эсэргүүцээгүй билээ.

¹¹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлал, танилцуулга. Хууль зүй, дотоод хэргийн яам. 2015. Монгол Улсын Засгийн газарт өргөн барьсан эх хувиас оруулсан болно.

Ийм ч учраас мөрдөн байцаалтын зорилтыг нотолбол зохих байдлыг тогтооход чиглэсэн ажиллагаа болгож, гэмт хэргийг ирлүүлэх зорилтыг уг ажиллагааны явцад мөрдөгч хэрэгжүүлэхгүй байхыг хуульчилсан байна. Энэ нь хэрэг бүртгэлт явуулах эрх бүхий мөрдөгч /хуучнаар эрүүгийн төлөөлөгч, хэсгийн төлөөлөгч/-ийг хэрэг бүртгэлтийн ажиллагааг хангалттай, бүрэн дүүрэн, шуурхай явуулах төдийгүй хэргийг илрүүлж, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг эргэлзээгүй тогтоох, хуульд заасан бүхий л арга хэрэгслээр тодорхой ажиллагаа явуулахыг илэрхийлсэн ойлголт билээ.

Нөгөөтэйгүүр, хэрэг бүртгэлт бүрэн дүүрэн, хангалттай, эргэлзээгүй явагдсан байх нь нотлогдвол зохих байдлыг эрх бүхий мөрдөгч эрүүгийн хэрэг үүсгэн магадлах, шалгах, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах замаар нотлон тогтоох нөхцөлийг бүрдүүлсэн. Гэсэн хэдий ч өнөөгийн практикт үүссэн хүндрэл нь мөрдөгчийн бие даасан, хараат бусаар ажиллах нөхцөлийг үгүйсгэсэн¹² гэж үзэж байгаа нийтлэг хүсэл зориг илэрхийлэгджээ.

Мөрдөн байцаалтын зорилтыг хангахад мөрдөгчийн бие даасан хараат бусаар ажиллах нөхцөл боломж нь ажлын үр дүнд шууд нөлөөлнө. Энэ нь мөрдөгч бие даан шийдвэр гаргах боломжийг хуулиар олгох явдал юм. Гэтэл эрүүгийн процессын хөгжлийн нийтлэг чиг хандлагаас үзвэл *due process of law*¹³ буюу зүй зохист эрх зүйн хөгжлийн баримжаатай хөгжих нь гарцаагүй болжээ. Өөрөөр хэлбэл, мөрдөн байцаалт хуульд заасан үндэслэл, журмын дагуу, аливаа зөрчилгүй, шударгаар явагдсан байх, түүнчлэн аливаа шийдвэрийг гаргахдаа талуудын оролцоонд үндэслэн гаргах, гарч буй аливаа шийдвэр хянагдах /шүүх, прокурор/, үе шатуудыг алгасахгүй байх зэрэг шинжээр илэрдэг.

Уг нөхцөл байдал нь нэгэнт мөрдөн байцаалтад нэвтрээд байгаа нь бидний судалгааны ажлаар бататгагдаж байна. Тухайлбал, Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн хөгжлийн замналаар үндсэндээ замнасан 1949 оны ЭБШ хуулиас

¹² Хууль зүй, дотоод хэргийн яамнаас практик байгууллагуудаас Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар авсан саналын материалаас. Ялангуяа Цагдаагийн байгууллагын Мөрдөн байцаах алба, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын Ерөнхий газар зэргээс ирүүлсэн саналуудаас үзвэл “мөрдөгч” тодорхой ажиллагааг бие даан явуулах, прокурорын зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлэх, бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэх, тодорхой шийдвэрийг мөрдөгч өөрөө гаргаж, үүсэх эрх зүйн үр дагаврыг хариуцдаг байх зэргээр нийтлэг давтагдсан санал ирүүлсэн.

¹³ *Зохист эрх зүйн* тухай үзэл санаа нь XIII зуунд Английн Магна Хартад бодитойгоор бэхэжсэн гэж үздэг. Орчуулагч П.Амаржаргал. Магна Харт. Уб., 2016. 28 дахь талд 39 дүгээр зүйлийг үзнэ үү.

2017 оныг хүртэлх 70 орчим жилийн хугацаанд мөрдөн шүүх тогтолцоо давамгайлсан хэлбэртэй процесс хөгжсөн. Гэхдээ мэтгэлцүүлэн шүүх тогтолцоог огт үгүйсгэхгүй бөгөөд 1994 оны ЭБШ хуульд оруулсан нэмэлт нь хэлбэрийн хувьд мэтгэлцээний үндсэн дээр шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлсэн билээ.

Эрүүгийн процессын хөгжлийн чиг хандлага нь “байцаан шийтгэх” нэр томъёоноос татгалзаж “хянан шийдвэрлэх”, “мэтгэлцүүлэн шийдвэрлэх”, “шалган шийдвэрлэх” гэсэн чиг хандлагатай хөгжиж эхлээд байна.

“Байцаан шийтгэх” агуулга нь 1992 оноос өмнөх социалист нийгмийн тогтолцоонд тохирох шинжтэй буюу ардчилсан улсад уг нэр томъёог хэрэглэх нь төдий л зохимжтой биш гэж зарим улс төрч, хууль зүйн эрдэмтэн, судлаачид үзэл санаагаа илэрхийлж байсан¹⁴ нь эрүүгийн процессын суурь үзэл баримтлал, үнэт зүйлийг шинэчлэх эхлэл болсон билээ. Бидний үзэж байгаагаар 2002 оны ЭБШ хууль нь хэдийгээр социалист агуулгатай биш боловч зорилго, үе шат, хэрэгжих аргын хувьд яллах процедур бүхий байцаалт, мөрдөлт шийтгэх үйл явцыг зохицуулсан гэж үзэх хандлага судлаачдын дунд давамгайлах болсон¹⁵ гэсэнтэй санал нийлэхгүй байгаа билээ. Өөрөөр хэлбэл, 2002 оны ЭБШ хууль 15 жил үйлчлэхдээ мөрдөн байцаалтыг бүхэлд нь гагцхүү ЭБШ хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулах зохицуулалтыг, мэтгэлцэх зарчимтай хамтатган хуульчилсан билээ.

Энэ нь мөрдөн байцаалтыг хууль ёсны төдийгүй, шударга ёсны тогтолцоонд шилжүүлсэн томоохон түлхэц болсон. Өөрөөр хэлбэл, 1963 оны эрүүгийн процесс нь хэдийгээр хүний халдашгүй эрхийг бататгасан, нотлох баримт, нотлох ажиллагааг хэлбэржүүлсэн, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхэд прокурорын хяналтад хэрэглэх, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн ажиллагааг харилцан чиг үүргийн хувьд ялгаж өгсөн хэдий ч хорьж мөрдөх шинжтэй байжээ. Тухайлбал, 1963 оны ЭБШ хуулийн 94 дүгээр зүйлийн гарчиг “Цагдан хорих” гэсэн томъёололтой хэдий ч 95 дугаар зүйлийн гарчигт “Хорьж мөрдөх хугацаа¹⁶” гэсэн томъёолол хэрэглэсэн нь бидний үзэж байгаагаар уг процесс “социалист эрх ашгийг хамгаалахын

¹⁴ Д.Баярсайхан. Эрүүгийн процессын эрх зүй. Уб., 2014. 17 дахь тал. Мөн 2012-2014 онд Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ажиллаж байсан Х.Тэмүүжин уг үзэл санааг тууштай дэмжиж, хууль зүйн шинжлэх ухааны нэр томъёонд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж улс төрийн хүсэл зориггоо тууштай илэрхийлж байсан билээ.

¹⁵ Д.Баярсайхан. Эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын шинэтгэлийн асуудлууд. Уб., 2019. 259-260 дахь тал.

¹⁶ Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал. (1911-2009 он) Хууль зүйн үндэсний хүрээлэн. Уб., 2012 он. 219-220 дугаар тал.

тулд мөрдөн байцаалтыг хорьж мөрдөх” гэсэн агуулгыг хуульчлан бэхжүүлсэн байжээ гэж үзэх үндэслэлийг бүрдүүлж байсан. Үүнийг 2002 оны ЭБШ хуулиар халж, сэжигтнийг баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг шүүгчийн зөвшөөрлөөр авдаг болжээ.

Мөрдөн байцаалтын агуулга нь яллах шинжтэй явагддаг ажиллагаа бөгөөд цаашид улам бүр эрх зүйн зохицуулалтын хувьд боловсронгуй болгох шаардлага түүхэн эх сурвалжаас тодорхой байна. Иймд үзэл сэтгэлгээний хувьд мөрдөн байцаалтыг яллах ажиллагаа бус төвийг сахисан /нейтраль/, идэвхтэй ажиллагаа болгохыг зорих шаардлагатай. Энэ нь хүчин төгөлдөр эрүүгийн ЭХХШ тухай хуульд тодорхой хэмжээнд тусгалаа олж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд мөрдөн байцаалт, мөрдөн байцаалтын ажиллагаа, мөрдөн шалгах ажиллагаа зэрэг нэр томъёогоор хуульчлагдсан боловч зарим судлаачдын дунд эдгээр нэр томъёог цэгцлэх шаардлагатай байгааг ном, бүтээлдээ дурджээ. Тухайлбал, доктор Т.Оюунчимэг нарын “Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаа¹⁷” бүтээл нь мөрдөн байцаалтад тулгуурласан процесс болохыг авч үзсэн байна. Уг бүтээлд “эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагаа” гэсэн ойлголттой хамт “эрүүгийн хэрэг шүүхэд хянан хэлэлцэх ажиллагаа” хэмээх нэр томъёог хууль зүйн салбарт хэрэглэдэг гээд хэл зүйн үүднээс авч үзвэл, эдгээр нь ижил ойлголт бус, учир нь “эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагаа” гэдэгт эрүүгийн хэрэг шалгах, хянах, шийдвэрлэх, шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаа бүхэлдээ багтана¹⁸ гэсэн нь бидний яллах шинжтэй процесс бөгөөд мөрдөн байцаалт голлох байр суурьтай гэсэн агуулгыг илтгэж байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх гэсэн нэр томъёоны агуулга нь шүүхийн үе шатыг илэрхийлдэг, шүүхийн бүхий л үйл ажиллагаа гэсэн үндэслэл бүхий тайлбарыг бидэнд санал болгосон байна. Үүгээрээ эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагаа гэсэн гэвэл шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлдэг мөрдөн шалгах ажиллагаа мөн багтаж байгааг илэрхийлж байна¹⁹ гэсэн дүгнэлт хийжээ. Бид уг дүгнэлттэй агуулгын хувьд санал нийлж, дэмжиж байгаа хэдий ч хууль тогтоомжийг эрх зүйн эх сурвалжийн хувьд шууд утгаар хэрэглэх зүй ёсны шаардлагаар онолын хувьд гарцаагүй авч үзэх ёстой, судалгаа шинжилгээг эрүүгийн процессын

¹⁷ Т.Оюунчимэг нар. Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаа. Уб., 2020. 9 дэх тал.

¹⁸ Дурдсан бүтээл. Мөн тэнд.

¹⁹ Т.Оюунчимэг нар. Дурдсан бүтээл. 10 дахь тал.

тэр дундаа мөрдөн байцаалт дахь нэр томъёог боловсронгуй болгох чиглэлээр эрчимжүүлэх шаардлагатайг илэрхийлнэ.

Дүгнэлт:

Мөрдөн шалгах ажиллагааны агуулга нь сүүлийн 100 гаран жилийн турш тодорхой төрлийн гэмт хэргийг илрүүлэх, нотлох, шүүхэд хэргийн гэрч, баримтыг бүрдүүлж өгөх, яллах болон цагаатгах нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлэх талаар хуульчлан бэхжүүлж ирсэн нь эрх зүйн зохицуулалтын хувьд дэлхий нийтийн чиг хандлагаас гажаагүйг илэрхийлэх онцлогтой. Энэ нь монголчуудын хууль бүтээх өндөр соёлтойг илэрхийлэх хэдий ч хэрэглэх, хэрэгжүүлэх явцад алдаа, нугалаа гаргадаг байдлыг судалгааны ажлууд баталсаар байна. Тийм ч учраас эрүүгийн хэрэгт явуулж байгаа мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн зохицуулалт нь өнөөдөр ч нотолбол зохих байдлуудыг тогтооход чиглэсэн байгаагаараа уламжлал хадгалсан боловч, мөрдөн шалгах ажиллагааны явцад процессын эрх зүйн хэм хэмжээг зөрчих, хүний эрхийн зөрчил гарч байгааг анхаарах шаардлага одоо ч байгаа нь илэрхий байна.

Ном зүй:

1. Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээ. Тайлан. Захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам. Нэгдсэн тайлан бэлтгэсэн: Т.Мэндсайхан нар. Уб., 2008 он.
2. Эрх зүйн шинэтгэл ба үндэсний эрх зүйн тогтолцоо. Олон улсын симпозиум. Хууль зүйн яам, Улсын Их хурлын тамгын газар. Эмхэтгэн хэвлүүлсэн: Ханнс – Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар. Уб., 2000 он.
3. Төрийн мэдээлэл сэтгүүл. Улсын Их хурал. Уб., 1994 он.
4. Хууль зүйн үндэсний хүрээлэн. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал. (1911-2009 он) Уб., 2012 он.
5. Д.Зүмбэрэлхам. Шүүхийн мэтгэлцээн. Уб., 2002 он.
6. Хууль сахиулахын их сургууль. Хууль сахиулахуй. Онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл. №1. Уб., 2014 он.
7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл: Уб., 2017 он.
8. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлал, танилцуулга. Хууль зүй, дотоод хэргийн яам. 2015. Монгол Улсын Засгийн газарт өргөн барьсан эх хувь.
9. Орчуулагч П.Амаржаргал. Магна Харт. Уб., 2016 он.
10. Д.Баярсайхан. Эрүүгийн процессын эрх зүй. Уб., 2014 он.
11. Д.Баярсайхан. Эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын шинэтгэлийн асуудлууд. Уб., 2019 он.
12. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал. (1911-2009 он) Хууль зүйн үндэсний хүрээлэн. Уб., 2012 он.
13. Т.Оюунчимэг нар. Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаа. Уб., 2020 он.



Ч.БОЛД

Хуульч, судлаач

ХОРИХ ЯЛААС ХУГАЦААНААС ӨМНӨ СУЛЛАЖ, ХЯНАЛТ ТОГТООХ ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН АЖИЛЛАГААНЫ АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

ISSUE OF CONCERN AND IMPLEMENTATION OF THE CRIMINAL PROCESS FOR PAROLE AND PROBATION

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд хорих ялаас хугацааны өмнө суллаж хяналт тогтоох ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал, эрх зүйн үндэс, практикт тулгарч буй хүндрэл бэрхшээлийн талаар авч үзсэн ба прокурор, шүүх, цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн статистик тоо мэдээлэл, эрх зүйн орчин тодорхой бусаас болж, төрийн алба хаагчдын авлигал, албан тушаалын гэмт хэрэгт холбогдох эрсдэл үүсэж болох талаар санал дэвшүүлсэн болно.

Энэхүү ажиллагаа нь олон салбарын дунд өөрөөр хэлбэл, шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаа, өмгөөллийн зэрэг байгууллагын харилцааны үр дүнд хүний эрхийг хангах чухал процесс, ялын бодлогын нэг чухал эерэг тал гэж хэлж болохоор байна. Ялтныг хугацааны өмнө суллаж, хяналт тогтоох асуудлыг шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийн заалтыг зөв хэрэглэх нь гэмт халдлагаас иргэн, нийгмийг хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, засаж хүмүүжүүлэх, ялтныг болон бусад хүнийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх хохирол нөхөн төлөх ажиллагаанд томоохон үүрэг гүйцэтгэдэг төдийгүй ЭХХШтХ-ийн үндсэн зарчмыг хэрэгжих чухал ач холбогдолтой юм.

Бид энэхүү институтийг шүүхийн процесс талаас нь судлан үзэж, онол, практикт тулгарч буй хүндрэл бэрхшээл, нөхцөл байдлыг судлан үзэхийг зорилоо.

Удиртгал

Түүхийн хувьд дэлхий нийтэд энэхүү институтийг “Parole” гэж нэршсэн¹ байна. Франц хэлний “parole”² гэдэг үг нь “амлалт” “хэлсэндээ хүрэх” гэсэн үгнээс гаралтай энэ нэр томъёо нь Дундад зууны үед амлалт өгсөн хоригдлуудыг суллахтай холбоотой байв. Энэ нь өршөөл үзүүлэх, дахин боломж олгож байсан ба ялыг хөнгөвчлөхөөс эрс ялгаатай бөгөөд тэнсэн суллагдсан хүмүүс ял эдэлж байгаа гэж тооцогдож, “Probation”³ буюу тэнссэн, хяналтад байх хугацаандаа шүүгчээс өгсөн үүргийг зөрчсөн тохиолдолд хорих ангид буцаадаг хэлбэрээр хэрэглэж ирсэн байна. Тухайн үед шоронгийн асуудал хүнд байсан тул зарим хөнгөн төрлийн гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг заавал удаан хугацаагаар хорих биш тэднийг дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх амлалтыг авч суллаж байсан байна.

Шотландын аялагч, газарзүйч, Хааны Тэнгисийн цэргийн флотын ахмад **Александр Маконочи** 1840 онд Австралийн Норфолк арал дахь Британийн хорих колониудын захирагчаар томилогдсон үедээ тэнсэн суллах орчин үеийн санааг анх нэвтрүүлсэн гэж түүхэнд тэмдэглэгдэн үлджээ⁴.

Гол асуудал

Манай улсын хувьд энэхүү институт нь мөн эрт дээр үеэс хэрэглэж ирсэн байна. Нүүдлийн соёл иргэншилтэй бидний хувьд хоригдож буй этгээд төдийлөн удаан хугацаанд байлгах боломж, зардал байсангүй. Тиймээс хэрэв дуулгавартай байж, учруулсан хохирол, төлбөрөө нөхөн төлөхөөр болсон бол хааны зарлигаар суллаж байв. Орчин цагийн анхны Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулиудад өөрийн тусгалаа олон хэлбэржсээр, бэхэжсээр өнөөдөртөө золгосон байна.

Эдүгээ Улс орон хөгжин дэвшихийн хэрээр эрх зүйн орчин нь улам бүр боловсронгуй болж, цоорхой, хийдэл, давхардлыг арилгах тал дээр хууль

¹ <https://en.wikipedia.org/wiki/Parole>

² “Probation”. gov.uk. Government Digital Service. Retrieved 13 June 2013.

³ “Probation and Parole in the United States, 2011” (PDF). Bulletin. U.S. Department of Justice. April 2014. Retrieved 29 August 2017.

⁴ Joel Samaha (2006). Criminal Justice. Belmont, CA: Thomson/Wadsworth. ISBN 9780534645571. OCLC 61362411

тогтоох байгууллага, эрдэмтэн судлаачид, иргэдийн оролцоотойгоор хөгжин боловсронгуй болж байна. Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хүрээнд 2015 онд Эрүүгийн хууль, 2017 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль мөн онд Цагдаагийн албаны тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай зэрэг хуулиуд батлагдан гарснаар зарчмын хувьд нэлээдгүй өөрчлөлт орж эдгээр хуулийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий салбарын асуудлыг судалгааны талбарт гүнзгийрүүлэн судлан үзэх зайлшгүй нөхцөлийг бий болж байна.

Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох ажиллагаа гэдэг нь “ялтан гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлж зан байдлаараа нийтэд аюулгүй болсноо нотлон харуулж ял эдлэх хугацаандаа ноцтой зөрчил гаргаагүй, оногдуулсан ялын дараах хувийг эдэлсэн бол прокурорын саналыг харгалзан шүүх хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоохоор шүүхээр шийдвэрлэгдэж байгаа процесс ажиллагааг” ойлгохоор хуульчилсан. Харин практикт **“магадланд орох”** гэж хэлж заншсан байна.

ЭХХШтХ-ийн 37.6 дугаар зүйл⁵-ийг удирдлага болгон хорих ялаас хугацаанаас өмнө суллах үндэслэлийн хүрээнд тухайн ялтны гэм буруугаа хүлээн зөвшөөрч, зан төлөвөө зөв дадал, амьдралын хэв маягт суралцан өөрчлөх гэсэн хүсэл зорилго, авир, араншин, зан, онцлог, ёс суртахууны өөрчлөлт зэргээс хамаарах ба тэдний гэм буруугаа хэрхэн ухамсарлаж, засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулсан, хохирлоо хэрхэн барагдуулсан, нас, гэр бүлийн байдлыг сайтар нягтлан үзэж хугацааны өмнө суллах тухай асуудлыг тухайн хорих анги байрлаж буй нутаг дэвсгэрийн шүүхийн ерөнхий шүүгч авч үзэн шийдвэрлэдэг. Өөрөөр хэлбэл, процессыг хэрэгжүүлэх эцсийн шийдвэрийг шүүгч гаргаж байна.

Ингэхдээ хорих ялаас хугацаанаас өмнө суллахдаа ялтны эдлээгүй үлдсэн ялын хугацаатай тэнцүү хяналтын хугацаа тогтоодог. Хорих ялаас хугацаанаас өмнө суллах тухай шийдвэр гарсан бол уг ялтныг даруй суллаж, суллагдсан хүний оршин суугаа газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад мэдэгдэж, хувийн хэргийг хүргүүлдэг.

Монгол Улсын Шүүхийн шүүн таслах ажиллагааны статистикаас гаргасан мэдээллээр шинэ Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиуд хэрэгжиж эхэлснээс хойш дараах тоон мэдээлэл гарсан байна.

⁵ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай /Шинэчилсэн найруулга/ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №23

(2017-2023 онд шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хорих ялаас хугацааны өмнө суллагдсан ялтны тоог харуулсан байдал)

Үзүүлэлт		2017 ОН	2018 ОН	2019 ОН	2020 ОН	2021 ОН	2022 ОН	2023 ОН
ЭХ-ийн 6.12, 6.13, 6.14, ЭХХШТХ-ийн 37.5, 37.6, 37.7, 37.8, 37.9, 37.10-д заасны дагуу эрх бүхий байгууллагаас тодорхойлолт, дүгнэлт гарган ирүүлсэн хүний тоо		1139	1637	2380	2580	6496	1760	2178
Өвчний учир хугацаанаас өмнө ял эдлэхээс чөлөөлсөн	Бүгд хүн	6	6	17	26	21	16	25
	Үүнээс Хорих ял	6	6	17	25	18	13	20
	Зорчих эрхийг хязгаарлах ял	0	0	0	1	3	3	6
Хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллаж хяналт тогтоосон хүний тоо		873	1087	1302	1386	1115	834	1125
Үлдсэн хорих ялыг өөр төрлийн хөнгөн ялаар сольсон	Бүгд хүн	0	1	6	0	544	11	76
	Торгох	0	0	1	0	32	0	0
	Нийтэд тустай ажил хийлгэх	0	0	0	0	5	0	3
	Зорчих эрхийг хязгаарлах ял	0	0	1	0	504	11	13
	Бусад	0	1	4	2	3	0	60

Үүнээс харвал коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахал гарсан үед илүү олон хүнийг Хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллаж хяналт тогтоосон байна.

Хорих ялаас хугацааны өмнө суллаж хяналт тогтоох ажиллагаа:

Хугацаанаас өмнө суллагдсан этгээдэд хяналт тогтоох ажиллагаа нь анхаарал татсан чухал асуудал болж байна. 2017 он батлагдан гарсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар суллагдсан этгээдийг хяналтдаа байлгах чиг үүргийг Цагдаагийн байгууллагаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлэн өгсөн билээ. 2020 онд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан

сэргийлэх тухай хууль батлагдсанаар хорих ял эдлээд суллагдсан хүнд хяналт тавих харьяаллыг тодорхой зааж өгсөн байна. Гэсэн ч практикт хөдөө орон нутагт суманд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэгж байдаггүй тул цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах журам, харилцан хамтран ажиллах санамж бичгийг байгуулан хяналт тогтоож байна. Гэсэн хэдий ч хяналт тавих процессын хувьд засаж сайжруулах, бүтэц зохион байгуулалт, эдийн засгаас хамаарсан томоохон шийдвэрлэх асуудал үүссэн хэвээрээ байна.

ЭХХШТХ-ын 37.6 дугаар зүйлд заасны дагуу шүүгч нь хорих ялаас хугацаанаас өмнө суллахдаа ялтны эдлээгүй үлдсэн ялын хугацаатай тэнцүү хяналтын хугацаа тогтоох шийдвэрийг гаргадаг.

Хорих ялаас хугацаанаас өмнө суллах тухай шүүгчийн шийдвэр гарсан бол уг ялтныг даруй суллаж, суллагдсан хүний оршин суугаа газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад мэдэгдэж, хувийн хэргийг хүргүүлдэг.

Хяналт тогтоох ажиллагааны хувьд практик дээр нэлээдгүй хүндрэл бэрхшээл гарч байна. Тухайлбал, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 41 дүгээр зүйл / Хорих ял эдлээд суллагдсан хүнд хяналт тогтоох/-ийн 41.1 дэх хэсэгт Эрүүгийн хуулийн 10.1, 11.2, 12.1, 12.3, 15.1, 15.5, 15.6, 16.2, 17.1, 18.6, 19.2, 19.5, 19.6, 19.8, 20.3, 20.7, 20.8, 26.1, 26.2, 26.3, 29.8, 29.10 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдэж, хоёроос дээш жилийн хугацаагаар хорих ял эдэлж суллагдсан болон хоёроос дээш жилийн хугацаагаар хорих ял эдэлж, Эрүүгийн хуулийн 6.12, 6.13, 6.14 дүгээр зүйлд заасны дагуу хорих ялаас хугацааны өмнө суллагдсан, чөлөөлөгдсөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан хяналтын хугацаа нь дууссан **хүнд гэмт хэрэг** үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн байгууллагаас захиргааны хяналт тогтоодог⁶.

Хорих ялаас хугацааны өмнө суллаж, хяналт тогтоох ажиллагаанд прокурорын тавих хяналт:

Прокурорын тухай хуулийн 48.1.9-д “гэмт хэрэгтэй тэмцэх, зөрчил шалган шийдвэрлэх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан хуулийн заалтыг хэрэгжүүлэх заавар, журам хуульд нийцэж байгаа эсэхийг

⁶ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай /Шинэчилсэн найруулга/ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2019 он, №42

хянаж зөвшөөрөл олгох, хэрэгжилтэд хяналт тавих,” гэж Улсын ерөнхий прокурорын бүрэн эрхийг зааж өгсөн байдаг. Үүний дагуу 22.1-д “Прокурор ял эдлүүлэх ажиллагаанд дараахь хяналт тавина:

22.1.1.хорих, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, тэнсэх, албадлагын арга хэмжээ биелүүлэх ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа эсэх;

22.1.2.ял эдлүүлэх ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг зөв хэрэглэсэн эсэх;

22.1.3.ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн эсэх;

22.1.4.баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх ажиллагаа хуулиар тогтоосон нөхцөл, журамд нийцэж байгаа эсэх.” гэж заасны дагуу хяналтыг тавин улирал бүр шалгаж, сар тутам танилцдаг.

Ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналт хариуцсан прокурор нь Хорих ялаас хугацааны өмнө суллахдаа уг арга хэмжээг хэрэглэх хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг анхаарах нь чухал билээ. Хорих ялаас хугацаанаас өмнө суллах, ял хойшлуулах, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг ялтны хувийн хэрэгтэй танилцах, шаардлагатай тохиолдолд ялтантай уулзах, тайлбар гаргуулах, тодорхойлолт авах хэлбэрээр хянадаг. Үүний дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг үндэслэн гаргасан прокурорын дүгнэлтийн дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын оршин байгаа газрын шүүхийн шүүгч захирамж гаргаж шийдвэрлэнэ.

Харин энэ оны эхний хагас жилийн байдлаар Прокурорын байгууллагаас хорих ял эдэлж байгаа 6006, цагдан хоригдсон 11.896, Зөрчлийн тухай хуульд зааснаар баривчлах шийтгэлээр шийтгүүлсэн 19.189, албадан саатуулагдсан 6541, хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан 21.480 хүн, хуулийн этгээдийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд хяналт тавьж, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн эрхийг сэргээхэд анхаарч ажилласан байна. Хорих ял эдэлж байгаа 6006 иргэний 73.7 хувь нь нээлттэй дэглэмд, 24.8 хувь нь хаалттай дэглэмд, 1.5 хувь нь сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж байгаагийн 254 нь эмэгтэй, 30 нь гадаадын иргэн, 82 нь өсвөр насны хүн байна⁸.

⁷ Прокурорын тухай /Шинэчилсэн найруулга/ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №24

⁸ УЕПГ-ын үндсэн сайт.<https://prokuror.mn/post/110934>

Авлигын эрсдэл:

Шүүхийн шийдвэрийн санг харвал ЭХ-ийн 22.4, 17.3 дугаар зүйлд заасан үндэслэлээр гэмт хэрэг үйлдсэн гэмт буруутайд тооцож, ял шийтгэсэн тохиолдлууд байна. Үүнээс харвал хорих байгууллагын ажилтан, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих прокурор зэрэг албан тушаалтанд нөлөөлөхийг оролдсон тохиолдлууд бүртгэгдсэн байна.

Энэхүү ажиллагаа нь ялтан бүрийн эрхийн асуудал хэдий ч улс төрийн нөлөө бүхий этгээдүүдийн зүгээс шийдвэр гаргах эрх бүхий тушаалтанд ямарваа нэгэн аргаар нөлөөлөх эрсдэлтэй юм.

Практикт хоригдол бүрийн хүсэн хүлээдэг нэг боломж бол хорих ялаас хугацаанаас өмнө суллагдах явдал байдаг. Хорих ангид хоригдож байгаа хоригдлуудаас авсан судалгаагаар санал асуулга авсан нийт 300 хоригдлын 282 нь буюу 94 хувь нь хугацаанаас өмнө суллагдах боломжоо авах хүсэлтэй гэдгээ илэрхийлсэн байна. Мэдээж үр өгөөжийн хувьд нийгмийн эерэг үр дагавар, эдийн засгийн хувьд ашигтай, хоригдлуудын хувьд хуульд заасан шаардлагыг хангахын тулд хүсэж тэмүүлэн зан байдлаа засаж, учруулсан хохирлоо нөхөн төлөх зэрэг эерэг үр дүн авчирч байна.

Харин хорих байгууллагын алба хаагчдаас авсан санал асуулгаар “Хорих ялаас хугацааны өмнө суллахад тулгарч буй хүндрэл бэрхшээлийг дурдана уу? гэсэн асуултад “Эрх зүйн орчин сайжруулах”, “хуулийн зарим заалт ойлгомжгүй байдаг”, “Зан байдлаараа аюулгүй болсноо нотлон харуулж” гэсэн шалгуур нь ойлгомжгүй байна”, “шалгуур шаардлагыг хангаагүй байж нөлөөлөхийг оролддог”, “улс төрийн нөлөө бүхий хүмүүст илүү нээлттэй гэж боддог”⁹ гэх мэт хариултыг өгсөн байна.

Хорих ялаас хугацаанаас өмнө суллах үндсэн шалгуурын нэг болох “Зан байдлаараа аюулгүй болсноо нотлон харуулж” гэсэн шалгуурыг тодорхой болгож, чухам ямар зан байдлыг аюулгүй болсонд тооцох, шалгуур үзүүлэлтийг хэрхэн хангах талаар хуульд тодорхой зааж өгөх шаардлага үүсэж байна. Тухайлбал, хорих ангийн дэргэдэх Арга зүйн зөвлөл өөр хэлэлцэх талаар нарийвчлан авч үзээгүй ба анги бүүр өөр өөрийн аргаар энэхүү шалгуур үзүүлэлтийг дүгнэж байна.

⁹ Судлаачийн хоригдлуудаас авсан судалгаа. 2024 он.

Өөрөөр хэлбэл, хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулаагүй, шалгуур шаардлагыг сайтар нягтлан үзээгүйгээс хорих ялаас хугацааны өмнө суллагдсан этгээд нийгэмшиж чадаагүйгээс дахин гэмт хэрэг үйлдэх тохиолдол гарч байна.

Үүнээс харвал эрх зүйн орчин бүрдээгүй, хууль хэрэглээ өөр өөр байгаагаас тухайн асуудлыг шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнууд ямарваа нэгэн авлига, албан тушаалын хэрэгт холбогдох эрсдэл үүсдэг.

Ач холбогдол

Ач холбогдлын хувьд энэхүү ажиллагаа нь ялтанд төрөөс олгож буй боломж, итгэл үзүүлж буй нэг хэлбэр төдийгүй, дахин гэмт хэрэг үйлдэхгүй байхад чиглэсэн ялын нэг бодлого юм. Улсын төсвөөс нэг өдөрт ялтан зарцуулж буй хөрөнгийг хэмнэх эерэг арга хэрэгсэл төдийгүй үр өгөөжтэй институт гэж үзэж болохоор байна.

Практикт хоригдол бүрийн хүсэн хүлээдэг нэг боломж бол хорих ялаас хугацаанаас өмнө суллагдах явдал байдаг. Мэдээж үр өгөөжийн хувьд нийгмийн эерэг үр дагавар, эдийн засгийн хувьд ашигтай, хоригдлуудын хувьд хуульд заасан шаардлагыг хангахын тулд хүсэж тэмүүлэн зан байдлаа засаж, учруулсан хохирлоо нөхөн төлөх зэрэг эерэг үр дүн авчирч байна.

Үүнээс гадна мэдээж хохирол нөхөн тохиолдолд болзол шаардлагыг хангаж байгаа тул ЭХХШТХ-н үндсэн зарчим хэрэгжих чухал нөлөөтэй гэж дүгнэж болохоор байна.

Дүгнэлт

Энэхүү институц нь шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, өмөглөлийн зэрэг салбар хоорондын үйл ажиллагаатай шууд холбогддог ялтанд төрөөс олгож буй боломж, итгэл үзүүлж буй нэг хэлбэр төдийгүй, дахин гэмт хэрэг үйлдэхгүй байхад чиглэсэн ялын нэг бодлого юм.

Эрх зүйн орчин тодорхой болоогүйгээс болж төрийн албан хаагч авлига албан тушаалын гэмт хэрэг, зөрчилд холбогдох эрсдэл үүсдэг. Хорих ялаас хугацаанаас өмнө суллах үндсэн шалгуурын нэг болох “Зан байдлаараа аюулгүй болсноо нотлон харуулж” гэсэн гол шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох шаардлага үүсэж байна.

Энэхүү институтийн ач холбогдлыг нэмэгдүүлэн шүүхээс хуульд заасан үндэслэл, журмын дагуу хорих ялаас хугацааны өмнө суллах ажиллагааг цаашид нэмэгдүүлэх нь эдийн засгийн болон хохирол нөхөн төлөх ажиллагаанд томоохон хөшүүрэг болж, онцгой үүрэгтэй төдийгүй шаардлагатай, ач холбогдолтой гэж үзэж байна.

Санал

Хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллах ажиллагааг нэмэгдүүлэх ялын бодлогыг төрөөс үр дүнтэй хэрэгжүүлэх.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хянан харгалзах чиг үүргийг гүйцэтгэж буй алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлж, орон тоог нэмэх, машин техник хэрэгслээр хангах.

Хорих ялаас хугацаанаас өмнө суллах үндсэн шалгуурын нэг болох “Зан байдлаараа аюулгүй болсноо нотлон харуулж” гэсэн шалгуурыг тодорхой болгон хуульчилж өгөх.

Хяналт тавих процессыг практикт зөв зохион байгуулалтад оруулж, эрх зүйн үндсийг илүү тодорхой болгож, төрийн байгууллагуудын уялдааг нэмэгдүүлэн, бүтцийн хувьд .

Эх сурвалжийн жагсаалт:

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай /Шинэчилсэн найруулга/ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №23
2. Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2016 он, №07
3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай /Шинэчилсэн найруулга/ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2019 он, №42 “Probation”. gov. uk. Government Digital Service. Retrieved 13 June 2013.
4. ШШГЕГ-ын даргын 2017 оны А/165 дугаар тушаал.
5. УЕПГ-ын үндсэн сайт.<https://prokuror.mn/post/110934>
6. ЦЕГ-ын хагас жилийн тайлан. 2024 он.

7. Joel Samaha (2006). Criminal Justice. Belmont, CA: Thomson/Wadsworth. ISBN 9780534645571. OCLC 61362411
8. Joan Petersilia, When Prisoners Come Home: Parole and Prisoner Reentry. Oxford: Oxford University Press, 2003.
9. “Probation and Parole in the United States, 2011” (PDF). Bulletin. U.S. Department of Justice. April 2014. Retrieved 29 August 2017.

<https://en.wikipedia.org/wiki/Parole>



Г.ЧАГДАР

*Нийслэлийн прокурорын газрын ЯЭАХТХ-н хяналтын прокурор,
хууль цаазын ахлах зөвлөх*

ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНД ТАВИХ ПРОКУРОРЫН ХЯНАЛТЫН АЖИЛД ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫГ ХЭРХЭН АШИГЛАХ БОЛОМЖ

Хураангуй: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд прокурор хиймэл оюун ухааныг ашиглан дэвшилтэд технологийг хэрэглэх нь ялтан, хоригдлын талаарх холбогдох хууль, Олон улсын гэрээнд заасан эрх, үүргийн хэрэгжилтийг бүрэн хангуулах, аливаа төрлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн эрхийг богино хугацаанд сэргээх, хангах, хамгаалах, нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэгт холбогдохгүй байх, хууль сахиулах байгууллага хоорондын ажлын уялдаа холбоо сайжирч, төрийн албаны шуурхай байдал хангагдах чухал ажил болно.

Түлхүүр үгс: Хиймэл оюун ухаан, прокурорын байгууллагад дэлхийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, прокурор хүний мэргэжлийн ур чадвар олон улсын түвшинд танигдах, хорих байгууллагын дэглэм, нөхцөл болон хоригдлын ял эдлэлтийн байдал “ smart “ болж нийгэмшүүлэх ажлын чанар, үр дүн сайжрах гэх мэт.

Удиртгал

Хүн төрөлхтөн агнасан ангаа гал ашиглан борлуулж идэж эхэлсэн хүний хөгжил 100 мянган жилийг туулж өнгөрүүлсэн бол шинэ чулуун зэвсгийн үеэс мал аж ахуй, газар тариалан үүсэн хөгжсөн “неолитын эрин үе” 12 мянган жилийг туулжээ.

Бидний амьдарч буй өнөө үе бол 2010 оноос эхэлсэн аж үйлдвэрийн IV дүгээр хувьсгал явж байна. Аж үйлдвэрийн III дугаар хувьсгалын хоёрдугаар хагаст шинжлэх ухаан- мэдээллийн буюу дижитал хувьсгал эхэлж эдүгээ хиймэл оюун ухаанд байр сууриа тавьж өгч эхэлж байна.¹

Хүн ба робот, бодит ба бодит бус хийсвэрийн ялгаа арилж, дэлхий нийтэд шинжлэх ухааны бүх салбарт ямар нэг хэлбэрээр хиймэл оюун ухаан давамгайлах шинжтэй байна. Одоогоос 2.5 мянган жилийн өмнө гүн ухаантан Пифагор “ Бүх зүйлийг тоо илэрхийлнэ “ гэжээ. Тухайн үед хэн ч ойлгосонгүй. Өнөөдөр бид тоон хувьслын үед амьдарч “ Дижитал хүн “ болон төлөвшиж байна. Тоон орон зайд тоон иргэн, тоон сургууль, тоон мөнгө, тоон эдийн засаг бий болж, роботууд нэхэмжлэл бичиж, роман уншиж, хөгжим зохиож, аль ч хэлнээс орчуулга хийж, хүний сэтгэшгүй их мэдээллийг боловсруулж байна.

2030 он гэхэд нэг хүний тархи нөгөө хүний тархитай компьютерын тусламжтай холбогдох зарчимд үндэслэсэн шинэ Web 4.0 -р солигдох ирээдүй харагдаж байгааг судлаачид хэлж байна. Мэдээллийн хувьслын энэ үед хүн төвтэй эрин үе үгүй болж мэдээллийн шинэ эрин дунд монголчууд бид дэлхийн энэ хөгжлийн гадна үлдэх боломжгүй юм.

Монгол Улсын Их хурал 2015 оны 11 дүгээр сард “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль “батлан гаргаж, энэхүү хуульд “Төрөөс баримтлах бодлого гэж Монгол улсын хөгжлийн үзэл баримтлалд суурилсан, түүнд заасан тэргүүлэх чиглэлийн хүрээнд салбарын болон салбар хоорондын хөгжлийн бодлогын зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлно “ гэж заасан.²

Төрөөс “Алсын хараа –2050 “ гэж нэртэй урт хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулж суурь 9 зорилго, хөгжлийн 50 зорилттой бөгөөд Монгол улсын 2050 он хүртэлх ирээдүйн гучин жилийг 3 үе шаттайгаар хэрэгжүүлэх чиглэлүүдийг төлөвлөсөн байна. ³

Уг зорилтод зааснаар гэмт явдалтай тэмцэх чиглэлээр уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, хүн -нийгмийн амар тайван орчныг хангаж, хууль сахиулах болон тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын үүрэг гүйцэтгэх

¹ Гэмт явдалтай тэмцэх асуудал. Сэтгүүл 2020 он №03 5, 6 дахь тал

² Хөгжлийн бодлогын тухай хууль

³ - Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого

чадавхыг олон улсын түвшинд өрсөлдөх хэмжээнд хүргэх зорилтыг дэвшүүлсэн.

Социалист системийн үед ял бол гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн хэрэгсэл гэж дүгнэн МАХН-н төв хорооноос ялыг чангаруулах замаар гэмт хэргийг бүрэн устгах тухай зорилт дэвшүүлж байсан баримт байгаа. Энэ үзэл санааны нөлөөгөөр хүмүүсийн ухамсарт гэмт хэрэг үйлдсэн хүн бүрийг “шоронд хийдэг” гэх хатуу ойлголттой байсан, одоо энэ ойлголт бага зэрэг өөрчлөгдсөн. / *Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг өнөөдрийг хүртэл дулимаг* /

Гэтэл хөгжингүй зарим орнуудад шоронд ял эдэлж суллагдсан этгээдийг шүүхээс гэм буруутгүй, ялтайд тооцохгүй гэсэн шийдвэрийг гаргаж хүний эрхийг хангаж, хорих ангиас суллагдсан хүмүүст зориулсан сургалтын хөтөлбөрүүдэд хамруулах, нийгэмшүүлэх тусгай журмын тухай хууль үйлчилдэг байна. Мөн шоронгоос суллагдсан хүмүүсийг нийгмийн амьдрал руу нь хөтлөн оруулах үүргийг төрийн бус байгууллага, иргэний байгууллага, өрх гэр, хөршийн холбоод шүүх болон шийдвэр биелүүлэх байгууллагуудтай байгуулсан гэрээг үндэслэн хариуцан ажилладаг байна.⁴ / Монголд ... /

Дээрх ажлын хүрээнд прокурорын байгууллагаас олон шинэлэг ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд энэ удаа миний бие зөвхөн хорих ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавихдаа бид ямар ажлыг төлөвлөн хийж болох талаар санал дэвшүүлэх, ял эдлүүлэх ажиллагааны онол, арга зүй, зарчим энэхүү сэдвийн хүрээнд тодрох мэдээллээр ирээдүйд өөрчлөгдөх хандлагатай тул энэ / **өөр** / сэдвийг сонирхон авч сонгон судаллаа.

Энэхүү сэдвийн хүрээ хорих ял эдлүүлэх харилцааг хамрах хэдий боловч хиймэл оюун ухааныг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа эсэх талаар Монгол Улсад өмнө нь төдийлөн сайн судлагдаагүй тул холбогдох материал, мэдээлэл маш хомс байсныг дурдах нь зүйтэй. Иймд хорих ял эдлүүлэх ажиллагаанд прокуророос хэрхэн технологийн дэвшлийг ашиглан хяналт тавьж болох бэ гэдэг асуултад хариулт олохын тулд гадаадын зарим орны хорих байгууллагын үйл ажиллагаанд хиймэл оюун ухааныг яаж ашиглаж, тухайн орны прокурорын байгууллагаас хэрхэн хяналт тавьж байгааг харьцуулан судлах байдлаар, мөн өмнө нь уншиж судалж байсан гадаадын зарим сайт дээр бичигдсэн мэдээ, мэдээлэлд дүгнэлт хийх байдлаар өөрийн саналыг тусган энэхүү илтгэлийг бичлээ.

⁴ -<http://www.baabar.mn/article/3986> Амьдралын хулгай нийтлэлээс

Үндсэн хэсэг:

AI-н тухай ойлголт Хиймэл оюун ухаан (artificial intelligence - AI) гэж хүний адил тодорхой зорилтыг биелүүлэх чадвар, ухаалаг эргэцүүлэл, учир зүйн үйлдлийг тооцоолон бодох болон бусад хиймэл байгууламжийн тусламжтайгаар мэдээллийг сэргээх, сэтгэн бодох алгоритм бүхий робот-компьютер юм. Өөрөөр хэлбэл одоогоор AI нь харааны мэдрэмж, оюун ухааныг таних, шийдвэр гаргах, хэл хоорондын орчуулга зэрэг хүний оюуны үйл явцыг дуурайхаас илүүг одоогоор хийж чаддаггүй гэнэ. Цаашид тун удахгүй AI –тай робот, машин нь өөрөө сэтгэдэг, өөрийгөө хөгжүүлдэг, сэтгэл хөдлөлийг илэрхийлдэг болно гэж олон улсын судлаачид бичиж байна.

Өндөр хөгжилтэй, богино хугацаанд цахимжсан нийгэмд шоронгийн системүүд мөн хурдацтай дижитал болж байгаа бөгөөд энэхүү хөгжлийн хамгийн сүүлийн жишээ бол аюулгүй байдлын техник, хоригдлуудад чиглэсэн менежментээр хэрэгжсэн AI шийдлүүд байна.⁵

Гадаадын зарим улсын хорих байгууллагад хэрэгжиж буй AI нь 2 үндсэн чиглэлээр хөгжиж байна. Үүнд: Нэгдүгээрт аюулгүй байдал, тандалтын үйл ажиллагааны технологи, хоёрдугаарт хоригдлуудын ял эдлэлтийн байдал, эрүүл мэнд, санхүү гэх мэт мэдээллүүдийг боловсруулах, нэгтгэн дүгнэх програмуудыг ашиглаж байна.

Тухайлбал: Өмнөд Солонгос улсад роботуудыг хоригдлуудын хүчирхийлэл, амиа хорлох эрсдэлийг хянах зорилгоор харуул хамгаалалтын ажилтны ажлын ачааллыг бууруулахад ашиглаж байгаа бол АНУ-ын Алабама дахь хорих ангиудад хоригдлуудын утасны яриаг бөөнөөр хянах системийг ашиглаж хэл, яриа таних программаар гэмт хэрэг үйлдэхээр төлөвлөж буй олон төрлийн эрсдэл бүхий аюулыг багтаасан сэжигтэй дуудлагыг илрүүлдэг, ганцаарчилсан хоригдлын хямралыг шийдвэрлэхийн тулд Амазон компанийн Alex-тай адил ухаалаг туслахуудыг хоригдлуудад “ Хоригдох хамтрагч “ болгон ажиллуулж байна.

Мөн зураг болон хэв маягийг таних технологиуд нь Энэтхэг улсын зарим хорих ангиудад хэрэгжиж байгаа бөгөөд Англи улсын Ливерпүүл дэх хорих ангид AI-д суурилсан видео аналитик платформыг ашиглаж хар тамхи, утас, зэвсэг зэргийг нэвтрүүлэхийг хянаж, бусад сэжигтэй үйлдлийг илрүүлдэг байна.

⁵ <https://rm.coe.int/ai-in-prisons-2030-acjournal/1680a40b83> Artificial Intelligence in prisons in 2030: An exploration on the future of AI in prisons

*Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын
ажилд хиймэл оюун ухааныг хэрхэн ашиглах боломж*

Үүн дотор хамгийн дэвшилтэт програмууд нь Хятад улсад ашиглаж байгаа бөгөөд хоригдлуудыг хорих ангид байх цаг мөч бүрд хянах “ ухаалаг “ хяналтын системийг бүтээж, камер болон мэдрэгчийн / мэдрэл өөр нэршил / сүлжээ нь хоригдлуудыг байнга хянаж , AI системээр тэжээгддэг бөгөөд энэ нь хоригдол тус бүрийн нүүр царай, хөдөлгөөн, зан төрхийн өөрчлөлтийг хянаж, шинжилгээний технологийг ашиглан өдөр бүр бичмэл тайлан гаргаж, аливаа хэвийн бус зан үйлийг тэмдэглэдэг байна. Мөн Хонг Конгын шоронд “ ухаалаг “ видео хяналтын системд хоригдол өөрийгөө гэмтээх болон аливаа хууль бус үйлдэл, гаж зан үйлийг илрүүлэх аналитик хяналтын камерууд, хяналтын бугуйвч зэргийг ашиглаж, хоригдлуудын амин чухал шинж тэмдэг, биометрийн мэдээллийг бүртгэж эрүүл мэнд, сэтгэл хөдлөлийг тогтмол хянадаг байна.

Өнөөдөр “биометр” гэсэн нэр томъёо нь зөвхөн хурууны хээгээр хязгаарлагдахгүй царай, дууны өнгө, биеийн өндөр, жин зэргийг таних программ нэвтэрсэн байна. Шинэ технологийг ашиглан хурууны хээгээр тухайн хүний талаарх бүх төрлийн мэдээллийг авах технологийн сайжруулалт хийгдэж байна. ⁶

Зарим улсын шоронд авч хэрэгжүүлж буй ажлыг жаахан дэлгэрүүлэн судалж үзэхэд:

Оросын Холбооны Улсад 2020 оноос эхлэн эрүүгийн ял эдлүүлэх бодлогыг боловсронгуй болгох ажлын хүрээнд хорих ял эдлүүлэх шинэ төрөл бий болгох, хоригдлуудыг нийгэмшүүлэх шинэ төрлийн арга хэрэгслийг нэвтрүүлэхээр судалгаа хийгдэж байна. Мөн албаны үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болгож хууль сахиулах бусад байгууллагатай холбогдох, мэдээллийн сан бий болгохын зэрэгцээ мэдээллийн аюулгүй байдлыг хангах, ял эдлүүлэх, цагдан хорих ажиллагаанд цахим дэд бүтцийг бий болгох, хоригдол, хоригдогч нарт цахим шуудан болон бусад үйлчилгээг ашиглах боломжийг олгох, ял эдлүүлэх тогтолцооны хөгжлийг дэмжих шинжлэх ухааны төв лабораториудыг байгуулах, хоригдол болон цагдан хоригдож буй этгээдтэй харьцах олон улсын стандартыг хангах, хяналтын цахим тогтолцооны тусламжтайгаар хоригдлын зан үйлд мониторинг хийх, хиймэл дагуулыг ашиглан хяналт тавих зэрэг ажлуудыг хийж хэрэгжүүлэн ажиллаж байна.

⁶ -<https://le.fbi.gov/science-and-lab/biometrics-and-fingerprints/biometrics/next-generation-identification-ngi>

БНХАУ-н улсад “ Шийтгэл, шинэчлэл хоёрыг хослуулж гэмт хэрэгтэнд засрал олгоно “ гэсэн зарчим үйлчилж байна. Хорих анги нь харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангах зорилгоор техник тоног төхөөрөмж болон хяналтын системдээ сайжруулалт хийснээр 2016 оноос хойш хорих ангиас нэг ч хоригдол оргоогүй байна. Мөн гэмт хэрэгтнийг нийгэмшүүлж , тэднийг нийгэмд эргэн ороход бэлтгэхэд хүчин чармайлт гаргаж тусгай сургалтын хөтөлбөр бүхий шинэ төрлийн хорих ангиудыг байгуулж, мэдээллийн технологийн өргөн хэрэглээг дэмжин ажиллаж байна.

Хятадын судлаачид хэргийн материалд дүн шинжилгээ хийж, хүмүүсийг гэмт хэрэгт буруутгах чадвартай дэлхийн анхны хиймэл оюун ухаан (AI) бүтээснээ мэдэгдсэн байна. Орвелийн төхөөрөмж нь төрийн эсрэг “эсэргүүцэл”-ийг тодорхойлж, гэмт хэрэгтнүүдэд ял оноохыг санал болгож байна.⁷

Энэхүү AI машин нь залилах, мөрийтэй тоглох, замын хөдөлгөөний дүрэм зөрчих, жижгээр танхайрах гэх мэт үйлдэгддэг 8 төрлийн гэмт хэргийн материалд дүн шинжилгээ хийж яллах ажиллагаа явуулж байна.

Америкийн Нэгдсэн улсад: Орчин цагийн хорих ангийн аюулгүй байдал, харуул хамгаалалт нь үндсэн гурван зэрэглэлд ангилж үздэг байна.

Дээд зэргийн харуул хамгаалалттай хорих анги нь гадуураа 6-8 метрийн өндөртэй хоёр давхар хашаагаар хүрээлэгдсэн, ажиглалтын цамхгууд дээр зэвсэглэсэн харуултай байна.

Дунд зэргийн харуул хамгаалалттай хорих анги нь дээгүүрээ өргөст торон хамгаалалт бүхий хоёр давхар хашаагаар хүрээлэгдсэн, ганцаарчлан хорих өрөөнүүдтэй байна.

Сул харуул хамгаалалттай хорих анги буюу хашаагаар хүрээлэгдсэн, харуулын постгүй. Дохиолол, камерын тусламжтайгаар хашаан доторх орчноо хянаж байдаг.

Хорих ангид нийгэмшүүлэх ажил хийх нь хоригдлын бодит байдлыг сайтар ойлгуулж, тэднийг хувь заяагаа өөрчлөх шаардлагатайг мэдрүүлэх зорилготой бөгөөд хоригдлуудын утасны ярианд хиймэл оюун ухааныг ашиглан дүн шинжилгээ хийдэг байна. Энэхүү технологи нь хоригдлуудын утасны дуудлагыг автоматаар хуулбарлаж, тэдний харилцааны хэв маягт дүн

⁷ <https://www.ozgunlaw.com/en/it-technology-law/china-has-created-the-worlds-first-ai-prosecutor-935> Хятад дэлхийн анхны AI-ийн прокурорыг бүтээлээ.

шинжилгээ хийж, албан тушаалтнуудын системд урьдчилан программчилсан зарим үг, хэллэгийг тэмдэглэж чаддаг байна.⁸

ХБНГУ-ын хорих байгууллага: Тус улсад нээлттэй, хаалттай гэсэн хорих ангийн хоёр систем үйлчилдэг бөгөөд нээлттэй хорих ангид хоригдол өөрийн зав, боломжийг харгалзан саналаараа хоригддог. Өөрөөр хэлбэл гэмт хэрэгтэн долоо хоногийн эхээр ажил ихтэй байвал долоо хоногийн сүүлээр хорих газарт очихоор шийдвэр гүйцэтгэх байгууллагатай тохиролцох юм уу, эсвэл долоо хоногийн эхээр боломжтой бол тэр хугацаандаа очоод хоригддог, түүнийг нь эрх бүхий байгууллага ялын хугацаанаас хасаж тооцсоноор ялыг бүрэн эдлүүлж дуусгадаг байна.

Хорих ял эдлүүлэх нь хоригдлыг цаашид дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нийгмийн хариуцлагыг ухамсарлуулах, эрх чөлөөт амьдралд нь эргэн ороход туслах зорилготой. Мөн хорих ангид хоригдлыг хөдөлмөрлүүлэх, сургалт орох, мэргэжил олгох нь нийгэмшүүлэх чухал ач холбогдолтой байна. Тухайлбал: Хорих ангид орчин үеийн техникээр тоноглогдсон хэвлэх үйлдвэр ажиллаж, хоригдлыг цөмийн ректорын гагнуурчин болон аливаа үйлдвэрийн автомат шугам дээр ажиллах роботын тохиргооны мэргэжлээр сургаж байна. Энэ нь тухайн хоригдолд нарийн мэргэжил олгож байгаа нь цаашид шоронгоос суллагдсаны дараа ажил олох, амжилттай хөдөлмөрлөхөд тус дөхөм үзүүлж байна.

Мөн шоронд телевизийн буюу алсын зайн сургалтыг олноор нь зохион байгуулж хоригдолд шаардлагатай мэдээ мэдээлэл, мэдлэгийг олгох ажлыг зохион байгуулж, Европын бусад улсын хэд хэдэн телевизийн төвийн сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлсэн байна.

Англи улсад: Хорих ангийг нээлттэй ба хаалттай гэж ангилдаг. Нээлттэй хорих анги нь зэвсэглэсэн хамгаалалт байхгүй, цонх нь төмөр хаалтгүй бөгөөд хоригдлууд нь бусад байгууллагад очиж гэрээгээр, харуул хамгаалалтгүй сайн дурын үндсэн дээр очиж хөдөлмөрлөж болдог байна. Хаалттай хорих анги нь зэвсэглэсэн харуултай, өндөр бөх бат хана зэргээр нийгмээс тусгаарлагдсан байдаг.

Тус хорих байгууллагын үзэж байгаагаар ял эдэлнэ гэдэг нь шийтгэл бус, тухайн хүнийг муу зуршлаас салгах, нөхөн сэргээх ажил арга хэмжээ гэж үздэг байна.

⁸ <https://www.reuters.com/article/idUSKBN2FA0ON/> АНУ-ын шоронгууд хоригдлуудын утасны дуудлагад дүн шинжилгээ хийхийн тулд хиймэл оюун ухааныг авч үздэг

Франц улсад: Төв болон орон нутгийн насанд хүрсэн, насанд хүрээгүйчүүдийг хүмүүжүүлэх тусгай байгууллагаас бүрдэх ба эдгээр нь өөрсдийн онцлог дэглэмтэй байна. Засрах найдлагатай хоригдлуудыг өдрийн цагаар нийтээр нь ажиллуулж, орой нь тэднийг тусгаарладаг. Ийм хоригдол нь гадуур ажил эрхлэх хөнгөлөлт эдэлдэг байна. Засрахад эргэлзээтэй, засрахгүй хоригдлын хувьд хязгаарлагдмал эрхийг эдлэх бөгөөд ял эдлүүлэх асуудлыг тусгай шүүгч хариуцаж хугацаанаас нь өмнө суллах, хорих ялын хугацааг багасгах асуудлыг шийдвэрлэдэг. Нийгмийн аюулаар бага, жижиг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд давтан гэмт хэрэг үйлдэх явдлаас зайлсхийх боломж олгох, гэмт хэрэгт холбогдсон этгээдийн зан төлөвийг ойлгох, засах, тэднийг хүмүүжих, нийгэмших явдалд туслах зорилготой.⁹

Финлянд улсад: Хорих байгууллага нь онцгой, жирийн, нээлттэй гэсэн гурван төрлийн дэглэмд хуваагддаг. Жирийн дэглэмд хорих ял эдэлж буй хоригдлууд хянагчийн хамт гадуур явж болох бөгөөд нээлттэй хорих байгууллага нь хоригдлыг оргон зугтахаас сэргийлсэн хашаа байхгүй, хоригдол өрөөнийхөө түлхүүрийг өөрөө эзэмшиж дотор чөлөөтэй явж, энгийн хувцас өмсдөг байна. Харин аль ч дэглэмд хоригдож байгаа хоригдол ганцаараа нэг өрөөнд ял эдэлдэг онцлогтой.

Зарим хорих ялыг 8 хүртэл сарын хугацаагаар албадан ажил хийлгэх ялд дүйцүүлэн 20 - 200 цагийн ажлыг 7 хоногт 2 удаа, 3 - 4 цаг ажилладаг. Энэ шийтгэлийг эдэлж байх хугацаанд хоригдлын үндсэн ажил, сургуулиас нь чөлөө авахгүй, гэр орондоо байх боломжийг хангаж гүйцэтгэдэг байна.

Тус улсын хуулиар хорих ял нь хүнд шийтгэл тул тухайн төрлийн гэмт хэргийг хүндрүүлэн аливаа шинжийг ял дээр нь нэмдэггүй, мөн хорих ангиас суллагдаад гарахад ямар нэгэн анкет, баримт бичигт ял эдэлж байсныг дурдахгүй байхаар тусгагдсан байна.

Швейцар улсад: Хорих байгууллагын нийгмийн ажил нь дотроосоо болон гаднаас гэсэн хоёр хэлбэртэй бөгөөд тэдний үйл ажиллагааны үндсэн зорилго нь ял эдэлж байгаа хүмүүсийг дахин хорих ангид эргэж ирэхгүй байхаар хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх чиглэлээр ажилладаг байна.

Япон улсад: Ял нь бага хэмжээний торгууль, торгууль, эрүүгийн баривчилгаа, албадан хөдөлмөрлүүлэх болон албадан хөдөлмөрлүүлэхгүйгээр

⁹ Гадаад орны прокурорын байгууллагын бүтэц, чиг үүргийн талаар харьцуулсан судалгаа 38,56 –р тал

хорих, цаазаар авах гэсэн төрөлтэй. Тус улсын ял эдлүүлэх байгууллагын бүтцэд урьдчилан хорих, баривчлах байр, насанд хүрэгчдийн болон насанд хүрээгүйчүүдийг хорих байгууллага орж байна. Хорих ялын нэг онцлог нь хөдөлмөр эрхэлж хорих эсвэл ажил хийлгэхгүй хорих ял оногдуулдаг. Хоригдлыг засрах хамгийн боломжтой нөлөөллийн арга бол биеийн хүчний хөдөлмөр гэж үздэг. Хоригдол өдөрт 8 цаг, долоо хоногт 44 цаг ажилладаг бөгөөд хоригдлуудын дунд нөлөөллийн ажил зохиохдоо аль болох олныг хамруулахгүй байхыг хичээдэг байна. Хоригдлыг хөдөлмөр эрхэлж хорих, хөдөлмөр эрхлэхгүй хорих нь тухайн хэргийн нөхцөл байдлаас шалтгаалж байна.

Дээрх улсуудын хорих ангийн үйл ажиллагаанд тухайн улсын прокурорын байгууллагуудаас хиймэл оюун ухаан ашиглан төдийлөн сайн хяналт тавьдаггүй байна. Учир нь хиймэл оюун ухаан нь шүүх, прокурорын байгууллага, олон нийтийн аюулгүй байдлын тогтолцоонд зарим хэрэглээг хэрэгжүүлсэн боловч эдгээр хэрэглээ нь жигдрээгүй гэж үздэг байна. Энэ нь хиймэл оюун ухаан нь оптик тэмдэгт таних технологи, байгалийн хэл боловсруулах технологи, ухаалаг яриа таних технологи, элемент олборлох технологи, робот сурах чадварыг сайжруулснаар дээд түвшний хиймэл оюун ухааныг ашигласнаар зорилт хангагдах юм байна.¹⁰

Энэ талаар АНУ-ын хуульч, судлаач Бесики Лука Кутателадзе 2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдөр Bloomberg law-д хэвлүүлсэн нийтлэлд “Амжилт ихэвчлэн инновац, технологийг нэвтрүүлэхээс хамаардаг гэтэл прокурорын салбар шинэлэг зүйлд үргэлж эргэлзсээр ирсэн. Прокурорын аливаа шийдвэр гаргах процесс нь хиймэл оюун ухааныг хэрхэн ашиглах талаар судалгаа хийгдэж байна” гэжээ.¹¹

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд хэнд ч эрүү шүүлт тулгах, эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй, хүн бүр хоол хүнс, хувцас хунар, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй, хүн бүр сурч боловсрох эрхтэй, наад зах нь анхан

¹⁰ -<https://www.scirp.org/journal/paperinformation?paperid=120103> Хятад дахь хиймэл оюун ухааны шүүхийн ололт амжилт ба хэтийн төлөв

¹¹ - <https://gordoninstitute.fiu.edu/news-events/the-policy-spotlight/2024/ai-is-here-to-stay-prosecutors-should-adopt-its-metrics-prowess.html> AI энд үлдэх болно. Прокурорууд түүний хэмжүүрийн ур чадварыг батлах ёстой нийтлэл

шатны болон ерөнхий боловсрол үнэ төлбөргүй байвал зохино , анхан шатны боловсролыг заавал эзэмшүүлэх ёстой, техникийн болон тусгай мэргэжлийн боловсрол нийтэд хүртээлтэй байх ёстой, хүн бүр өөрийн туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны бүтээлийн материаллаг болон ёс суртахууны эрх ашгаа хамгаалуулах эрхтэй зэрэг заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуульд тусгалаа олсон байдаг.

Иймд бид Монгол улсын шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу шүүхээс оногдуулсан хугацаагаар тухайн хоригдол ялыг хорих ангийн дэглэм, нөхцөлд эдэлж буй эсэхийг хянаж Эрүүгийн хуулийн энэрэнгүй ёсны зарчмыг үндэслэн бус хуулийн ерөнхий ангийн 6.12 дугаар зүйлд заасан үндэслэлээр хоригдлыг хугацааны өмнө суллах¹² эсэх асуудлыг шийдвэрлүүлэхээр харьяа дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд прокурорын дүгнэлт үйлдэн шийдвэрлүүлж байна.

Гэтэл Ази болон Европын хөгжиж байгаа болон хөгжингүй орны хорих ангиудад тухайн хоригдлыг ямар нөхцөлд ял эдлүүлж, хэрхэн нийгэмшүүлэх ажлыг яаж зохион байгуулж байгаа болохыг олдсон материалын хүрээнд судалж үзэхэд цаашид бид дараах ажлыг хиймэл оюун ухааны тусламжтайгаар хянах боломжтой гэж харсныг дүгнэлт хэсэгт оруулав.

Дүгнэлт

Хиймэл оюун ухаан нь машин жолоодохоос эхлээд зүрхний нээлттэй хагалгаа хийх хүртэл бидний амьдралын ихэнх хэсгийг эзлэхээр төлөвлөж байна. Унших тэвчээр багасаж, бичих чадвар буурч байгаа нийгэмд хиймэл оюун ухаан энэ ажлыг гүйцэтгэх боломж бүрдэж байна.

Прокурорын байгууллага хүний гаргасан шийдвэрийг хиймэл оюун ухаанаас гаргасан шийдвэртэй харьцуулж, асуудал үүсгэж болзошгүй хэргийг илрүүлэх боломжтой. Энэ нь хиймэл оюун ухааныг ашиглан тогтмол статистик мэдээ гаргах замаар энэхүү аналитик цоорхойг үр дүнтэйгээр нөхөж чадна.

Цаашид хиймэл оюун ухааныг чадварыг хурдан тодорхойлж, автомат орчуулга хийх, нүүр царайг таних, дүрсийг баяжуулах, медиа файлуудыг орчуулах, хуулбарлах, эх материал, видео, зургийн аналитик хийх зэрэг бусад хэрэглээнд өдөр тутам ашиглах боломжтой байна.

¹² Монгол Улсын Эрүүгийн хууль, 2017 он

*Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын
ажилд хиймэл оюун ухааныг хэрхэн ашиглах боломж*

Хорих ангийн нийгэм, сэтгэл зүйн албанаас зохион байгуулдаг сургалтуудыг хоригдлуудын үйлдсэн гэмт хэргийн хууль зүйн үр дагаварт тохирсон, сэдвээр хоригдлуудад сургалтыг үе шаттай зохион байгуулж байгаа эсэхийг прокуророос шууд хянах боломжийг бүрдүүлэх нь туйлын ач холбогдолтой. Учир нь тухайн хоригдол гэмт хэргийг ямар сэдлээр үйлдсэн болохыг нийгмийн ажилтан судалж мэдсэний үндсэн дээр сургалтын сэдвийг тохируулан сургалт орж байгаа эсэхийг прокуророос хянаж, тухайн хоригдол хэрхэн нийгэмшиж, дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх боломжийг хэрхэн бүрдүүлж байгааг дүгнэх боломжтой. Тухайлбал: Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн хоригдлууд нь хохирогчтой гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай, удаан хугацаанд гэр бүлийн хүчирхийлэлд байлган, тарчлаасны эцэст хөнөөсөн байдаг бол бага насны хүүхдийг хүчиндэж алсан хоригдлууд үйлдсэн гэмт хэргээ нуун далдлах, гэмт хэргийн ул мөрөө арилгах зорилгоор бага насны хохирогчийг алсан байдагт анхаарч сургалтыг зохион байгуулах нь үр дүнтэй.¹³

Прокурорын шийдвэр хууль зүйн үндэслэлтэй гаргах зорилгоор тухайн хоригдлын талаарх мөрдөн шалгах ажиллагаанд өгч байсан мэдүүлэг, шүүх хурлын бичлэг, хорих ял эдлэх хугацаанд нийгэмшүүлэх сургалтад хэрхэн сууж, оролцож байсан болон зан төрхийн өөрчлөлт, засрал хүмүүжлийн ямар нөлөө үзүүлж байсан зэрэг шаардлагатай бүх мэдээллийг видео хэлбэрээр үзэж дүгнэлт хийхийн тулд хиймэл оюун ухааныг ашиглаж мэдээллийг багцлах боломжтой.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

Прокурорын байгууллагын цахим системийг ашиглан хиймэл оюун ухааныг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх: Прокурорын байгууллагад хяналт тус бүрийн чиглэлээр цахим сүлжээнд бүрэн үйлчилгээтэй ухаалаг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдээллийн сан бүрдүүлэх. Өөрөөр хэлбэл ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналтын чиглэлээр тухайн хоригдлыг хэрэгт холбогдсон үеэс хуулийн сахиулах байгууллагаас түүнд чиглэсэн бүх төрлийн ажил, арга хэмжээний талаарх мэдээлэл, шаардлагатай бичлэгийг хяналтын прокурор хянаж шийдвэр гаргахдаа ашиглах боломжийг бүрдүүлэх.

¹³ - Гэмт явдалтай тэмцэх асуудал. Сэтгүүл 2021 он №01 7 дахь тал

Хорих ангиас хиймэл оюун ухааныг ашиглан хоригдолд чиглэсэн ажил арга хэмжээний талаарх мэдээлэл: Хорих ангид ашиглаж буй царай таних, алхаа таних зэрэг хиймэл оюун ухааны технологиудыг ашиглан зөрчил илрүүлсэн, нийгэмшүүлэх сургалтын үйл явц зэргийг харуулсан бүх төрлийн бичлэгийг прокуророос шууд хянах боломжийг бүрдүүлэх. Өөрөөр хэлбэл гэмт хэргийн хандлагын шинжилгээ, хэргийн шинж чанарын шинжилгээг нэгтгэсэн хиймэл оюун ухааны систем нь бүх төрлийн мэдээлэл, өгөгдлийг автоматаар цуглуулж, холбогдох элементүүдэд ухаалгаар дүн шинжилгээ хийж, эрүүгийн хэрэг, зөрчлийг илрүүлэхэд үр ашгаа өгөх боломжтой.

Шүүхэд төрийг төлөөлөх чиглэлээр: Хиймэл оюун ухааныг ашиглан шүүхийн шийдвэрийн талаарх мэдээллийг нэгтгэн дүгнэх, дүн шинжилгээ хийх, ухаалаг шийдвэр гаргах, шүүх хуралдаанд хяналт тавих боломж бүрдүүлэх.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр: Хиймэл оюун ухааныг ашиглан прокурорын байгууллагаас санаачлан хийсэн видео бичлэг, шторк, контент, баннерууд нэгтгэн сайтаар дамжуулан олон нийтэд байнга хүргэж байх. Холбогдох төрөл бүрийн видео зураг, бичлэгийн сан бүрдүүлэн видео дүрсний мэдээллийг олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах, хянахад ашиглах боломжтой.

Зөвлөмж

Судлаач А.Гиндденс “Нийгэмшил гэдэг нь тасралтгүй үргэлжлэх үйл явц бөгөөд өөрийн ухамсар бүхий ухаант амьтан болон хувирч, төрж өссөн соёлынхоо мөн чанарыг ойлгох явц, зарим нөхцөлд насанд хүрсэн хүмүүс дахин нийгэмшилд орж болно. Өөрөөр хэлбэл урьд өмнө тогтсон үнэт зүйлс, бие хүний зан үйлийн загвараа өөрчилж өмнөхөөс эрс ялгаатай үнэт зүйлсийг эзэмших нь буй. Хүмүүсийн үнэт зүйлс, ертөнцийг үзэх үзэл нь яг хэвэндээ байдаггүй, амьдралын бүхий л мөчлөгийн туршид хуримтлуулсан туршлагатайгаа хамт хувиран өөрчлөгдөнө¹⁴ гэж хэлсэн. Иймд хорих ангид нэн түрүүнд хоригдлыг нийгэмшүүлэх сургалтыг маш оновчтой, үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай юм . Үүнд:

¹⁴ Хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажилд хийсэн шинжилгээ /2015-2020 он / <https://cd.gov.mn/uploads/643623500229a.pdf/> 16 тал

*На эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын
ажилд хиймэл оюун ухааныг хэрхэн ашиглах боломж*

Хорих ял эдлүүлэх ажиллагааны үндсэн зорилго нь хоригдлыг нийгэмшүүлэхийн тулд чанартай сургалтыг зохион байгуулах.

Хорих ангиас суллагдсан хүнийг нийгэмшүүлэх ажлыг хэн, хэрхэн зохион байгуулах талаар хуульчлах.

Хоригдолд албан болон албан бус сургалтаар боловсрол заавал эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах.

Хорих ангийн нийгмийн ажилтан нарт болон хорих ангиас суллагдсан хүнийг дахин нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлж байгаа хүмүүсийг мэргэшүүлэх, мэргэшсэн нийгмийн ажилтны нөөцийг бүрдүүлэх шаардлагатай.

- Хоригдлын ял эдлэх орчин нөхцөл, дэглэмийг олон улсын хууль тогтоомж, хүний эрхийн байгууллагаас гаргасан зөвлөмжид нийцүүлэн дотоодын хууль, тогтоомж холбогдох журам, зааврыг өөрчлөн орчин үеийн дэвшилтэт техник, технологийг ашиглах, мөн хэрэглэж чаддаг боловсон хүчнийг бэлтгэх нь ирээдүйд тохиох үсрэнгүй хөгжлөөс бид хоцрохгүй, зэрэгцэн ажиллаж амьдрах нөхцөл бүрдэх боломжтой байна.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

1. Гэмт явдалтай тэмцэх асуудал. Сэтгүүл 2020 он №03 5, 6 дахь тал
2. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
3. Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого
4. <http://www.baabar.mn/article/3986> Амьдралын хулгай нийтлэлээс
5. <https://rm.coe.int/ai-in-prisons-2030-acjournal/1680a40b83> Artificial Intelligence in prisons in 2030: An exploration on the future of AI in prisons
6. <https://le.fbi.gov/science-and-lab/biometrics-and-fingerprints/biometrics/next-generation-identification-ngi>
7. <https://www.ozgunlaw.com/en/it-technology-law/china-has-created-the-worlds-first-ai-prosecutor-935> Хятад дэлхийн анхны AI-ийн прокурорыг бүтээлээ.

8. <https://www.reuters.com/article/idUSKBN2FA0ON/> АНУ-ын шоронгууд хоригдлуудын утасны дуудлагад дүн шинжилгээ хийхийн тулд хиймэл оюун ухааныг авч үздэг
9. Гадаад орны прокурорын байгууллагын бүтэц, чиг үүргийн талаар харьцуулсан судалгаа 38,56 –р тал
10. <https://www.scirp.org/journal/paperinformation?paperid=120103> Хятад дахь хиймэл оюун ухааны шүүхийн ололт амжилт ба хэтийн төлөв
11. <https://gordoninstitute.fiu.edu/news-events/the-policy-spotlight/2024/ai-is-here-to-stay-prosecutors-should-adopt-its-metrics-prowess.html> AI энд үлдэх болно. Прокурорууд түүний хэмжүүрийн ур чадварыг батлах ёстой нийтлэл
12. Монгол улсын Эрүүгийн хуулийн ерөнхий анги 2017 он
13. Гэмт явдалтай тэмцэх асуудал. Сэтгүүл 2021 он №01 7 дахь тал
14. Хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажилд хийсэн шинжилгээ /2015-2020 он / [/https://cd.gov.mn/uploads/643623500229a.pdf/](https://cd.gov.mn/uploads/643623500229a.pdf) 16 тал



Ч.ДОРЖСҮРЭН

Үндэсний тагнуулын академийн дэд профессор

АВЛИГЫН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХЭД ТУСГАЙ, НУУЦ АРГА, ХЭРЭГСЭЛ АШИГЛАХ НЬ

Товчлол: Авлигын гэмт хэрэгтэй тэмцэхэд түүний онцлог шинжээс шалтгаалан гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулах зайлшгүй шаардлага үүсдэг. Тус өгүүлэлд авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаанд тусгай, нууц арга, хэрэгсэл ашиглах эрх зүйн орчин, тэдгээр арга, ажиллагааны төрөл, онцлог болон хэрэгцээ шаардлага, ач холбогдлыг дүгнэн тодорхойлж, авч хэрэгжүүлэх зарим саналуудыг дэвшүүлсэн болно.

Түлхүүр үгс: гэмт хэрэг, тагнуул, гүйцэтгэх ажил, нууц ажиллагаа, арга хэмжээ

Оршил

Авлигын гэмт хэргийн мөн чанарыг орчин үеийн агуулгаар авч үзвэл энэ нь тухайн улсын эдийн засагт ноцтой хохирол учруулахуйц үр дагаварыг агуулж, төр нийгмийн итгэлийг хөсөрдүүлж, зориуд санаатай үйлдэгддэгээс гадна эд баялгийг хууль бусаар олж авахад чиглэгддэг төдийгүй хүний эрх, ардчилал, шударга ёсны үнэт зүйлсийг эвдэж бусниулдаг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Энэ төрлийн гэмт хэрэг нь аль нэг улс, үндэсний хүрээнээс хальж, бүх улс, эдийн засагт нөлөөлөхүйц үндэстэн дамнасан олон улсын үзэгдэл болсныг Авлигын эсрэг конвенцын оршилд онцлон тэмдэглэсэн байдаг.¹ Иймд

¹ Д.Баярсайхан. Албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа ба хүний эрх. МУИС-ХЗС. “Албан тушаалын гэмт хэрэг: Эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын эрх

улс бүрт авлигатай хийх тэмцлийн механизмыг үндэсний болон салбарын түвшинд хөгжүүлэх зайлшгүй шаардлага үүснэ. Манай улс авлига, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын олон талт гэрээнд нэгдэн авлигын эсрэг болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулиудыг баталж, авлига, албан тушаалын гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг аль хэдийн бүрдүүлсэн билээ.

Авлигын гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх үндэс нь улс төрийн хүсэл эрмэлзэл бөгөөд төр бодлогоо тодорхойлж, төрийн эрх бүхий байгууллагууд урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шалгаж шийдвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг. Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газраас “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд ...авлига, албан тушаалын гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгах, нийгэм, эдийн засаг, эрх зүй, зохион байгуулалтын олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлж, авлига, хууль бус үйлдэлтэй үл эвлэрэх, үл тэвчих хандлагыг олон нийтийн дэмжлэг оролцоотойгоор төлөвшүүлэн бүх шатанд авлигыг таслан зогсоосны үндсэн дээр хүний эрхийг ханган нийтийн эрх ашгийг хамгаалж, хувийн хэвшлийг дэмжин хөгжүүлж эдийн засгийн үр өгөөжийг сайжруулах зорилгоор 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарлаж “Авлигатай тэмцэх таван үйл ажиллагаа”-г² хэрэгжүүлж байгааг жишээлэн дурдаж болно.

Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэлбэрэлтгүй даган биелүүлж, авлигын гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд Авлигатай тэмцэх газар, прокурор, шүүхийн болон аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах байгууллагуудын манлайлал, хамтын ажиллагаа нэн чухал бөгөөд тэдний хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломж, зохион байгуулалтын бүтэц, хүний нөөцийн чадавх, ажилтан, алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, техник хэрэгслийн хангамж зэрэг олон олон хүчин зүйл нөлөөлнө. Энэ төрлийн гэмт хэрэгт “цагаан захтан”-ууд оролцдог, нуугдмал шинж чанартай, зохион байгуулалттай үйлдэгддэг зэргээс шалтгаалан илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаанд тусгай, нууц арга, хэрэгсэл ашиглах хэрэгтэй болдог. Мөн урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор ч явуулах нь цөөнгүй. Тусгай, нууц арга ажиллагааны эрх зүйн орчин, тактик,

зүйн тулгамдсан асуудал” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ, 2015 он. 6 дахь тал
² Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 сарын 08-ны өдрийн 49 дүгээр тогтоол

онцлогийг судлан тодорхойлж, илүү боловсронгуй болгох нь авлигатай тэмцэх үйл ажиллагаанд дэвшил авчрах төдийгүй гүйцэтгэх байгууллага, салбарын хөгжилд тустай.

Үндсэн хэсэг

Дэлхийн түүхэн хөгжлийн явцад олон төрлийн сөрөг үзэгдлүүд үүсч, амь бөхтэй оршсоор ирсний нэг нь “авлига” мөн. Далд хэлбэрээр үйлдэгддэг, олон янзаар илрэн гарч байдаг зэрэг шинж чанараас нь хамаарч олон улсын түвшин (НҮБ-ын Авлигын эсрэг конвенци)-д авлигын талаар нэгдсэн тодорхойлолт хүрээгүй³ хэдий ч гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэн, судлаачид товч байдлаар, эсхүл өргөн хүрээнд өөр өөрөөр тодорхойлсон нь бий. Монгол Улсын Авлигын эсрэг хуульд “авлига” гэж энэ хуулийн 4.1-д⁴ заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг⁵ ойлгоно гэжээ. Тэгвэл 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад 12 зүйл бүхий “Авлигын гэмт хэрэг” бүлгийг шинээр оруулсан бөгөөд авлигын гэмт хэрэг нь нийтийн албан тушаалтан эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, хахууль авах, хахууль өгөх, улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, төрийн өмчийн төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, дураараа

³ Б.Баярсайхан. Авлигын гэмт хэргийн шалтгааныг тодорхойлох нь. АТГ. Шударга ёс. Мэдээлэл, онол, аргагүйн хагас жил тутмын цуврал 2020 (20) 6 дахь тал

⁴ 4.1. Доор дурдсан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна:

4.1.1. төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;

4.1.2. төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;

4.1.3. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;

4.1.4. олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал;

4.1.5. улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;

4.1.6. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч;

4.1.7. бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч;

4.1.8. эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан;

4.1.9. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацийн эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн.

⁵ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2006 он, №35

аашлах, гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах, хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах зэргээр төр, засгийн байгууллагын хэвийн үйл ажиллагаа, нийтийн ашиг сонирхолд халдаж хуульд заасан гэм хор учруулсан буюу учруулах байсан Эрүүгийн хуульд заасан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйн цогц бүрдэл юм.⁶

Аливаа үйл хэргийг булаалдан мэтгэлцэх, хүч чадлаа үзэн тулалдах тэмцлийг амьдралын төлөө, сайн сайханы төлөө, энх тайвны төлөө, үзэл суртлын төлөө, нийгмийн хэв журмын төлөө⁷ гэх мэтээр ангилж, дотор нь тодорхой бүлэг чиглэлд хуваадаг. Үүнээс хүн, нийгмийн сайн сайхан, эрх, эрх чөлөөний төлөөх хамгийн гол тэмцэл бол гэмт хэрэгтэй хийх тэмцэл юм. Гэмт хэрэгтэй тэмцэх гэж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, мөрдөн шалгах зорилгоор хуульд заасан ажиллагаа явуулахыг ойлгоно⁸ гэвэл энэ нь бие даасан 4 төрөлтэй байна. Тодруулбал, 1) гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, 2) гэмт хэргийг таслан зогсоох, 3) гэмт хэргийг илрүүлэх, 4) гэмт хэргийг мөрдөн шалгах зэрэг шууд ба шууд бус харилцан хамаарал бүхий үйл ажиллагааны нийлбэр ажээ. Өргөн хүрээнд буюу гэмт явдалтай тэмцэх чиглэлд ...эрүүгийн шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг засан хүмүүжүүлэх, ял эдлэгсдийн зан үйлд хяналт тавих, гэмт хэргийн хор уршгийг арилгахад чиглэгдсэн эдийн засаг, улс төр (түүний дотор эрх зүйн), сэтгэл зүй, зохион байгуулалт, техникийн шинжтэй арга хэмжээнүүд⁹ дээр нь нэмэгдэнэ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, мөрдөн шалгах явцад нийтлэг арга ажиллагаанаас гадна тухайн хэргийн нөхцөл байдалд тохирсон тусгай, нууц аргуудыг ашигладаг. Тэдгээрийг ерөнхийд нь тагнуулын арга, гүйцэтгэх ажлын арга хэмжээ, мөрдөн шалгах нууц ажиллагаа гэх ба дотроо тодорхой нэр төрлийн тусгай, нууц арга, хэрэгслүүдийг агуулна. Авлига, албан тушаалын гэмт хэрэгт шалган мөрдөгдөж буй ихэнх хүн хэргээ шууд хүлээхгүй, элдвээр саад учруулах, хэргийн үйлдлээ нуун дарагдуулах хандлага түгээмэл байдаг,¹⁰ улс төрд нөлөө бүхий этгээд, нийтийн

⁶ Х.Нямбаатар, Д.Мөрөн нар. Эрүүгийн эрх зүй (ерөнхий ба тусгай анги). УБ, 2017 он. 123 дахь тал

⁷ <https://toli.query.mn/search?q=тэмцэл>

⁸ Цагдаагийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он

⁹ С.Нарангэрэл. Монголын эрх зүйн эх толь бичиг. Дөрөв дэх хэвлэлт. УБ, 2015 он. 129-130 дахь тал

¹⁰ Д.Баярсайхан. Албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа ба хүний эрх.

албан тушаалтнууд ихэвчлэн холбогддог, урьдчилан үгсэн тохирч зохион байгуулалттайгаар үйлддэг зэрэг нь мөрдөн шалгах ажиллагаанд хүндрэл учруулдаг.

1. Эрх зүйн зохицуулалт: Монгол Улсын Гүйцэтгэх ажлын тухай хуульд “Үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор төрийн эрх бүхий байгууллагаас ердийн ба тусгай, нууц арга, хэрэгсэл ашиглан явуулж байгаа мэдээ, мэдээлэл, баримт бичиг, нотолгоо эрж олох, цуглуулах, шалгах үйл ажиллагааг гүйцэтгэх ажил гэнэ”¹¹ гэж тодорхойлоод хоёрдугаар бүлэгт гүйцэтгэх байгууллага, гүйцэтгэх ажил явуулах үндэслэл, хүрээг заажээ. Энэ дагуу Авлигатай тэмцэх газар нь авлигын гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор гүйцэтгэх ажил явуулах, гэм буруутай этгээдийг олж тогтоох, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах,¹² ...авлигын гэмт хэрэг болон хуулиар харъяалуулсан эрүүгийн хэрэгт ГАТХ-ийн 11.2.1-11.2.3, 11.2.5-11.2.6-д¹³ заасан үндэслэлээр гүйцэтгэх ажил явуулах эрхтэй.

Авлигатай тэмцэх газар нь ...авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах... чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага¹⁴ бөгөөд авлигын гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор гүйцэтгэх ажил явуулах, гүйцэтгэх ажил эрхэлдэг бусад байгууллагуудтай хамтран ажиллах¹⁵ бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмаар мөрдөн шалгах нууц ажиллагааг прокурорын

МУИС-ХЗС. “Албан тушаалын гэмт хэрэг: Эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын эрх зүйн тулгамдсан асуудал” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ, 2015 он. 9 дэх тал

¹¹ Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 2 дугаар зүйл. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1998 он, №3

¹² Мөн тэнд. 9 дүгээр зүйлийн 9.1.6 дахь заалт

¹³ 11.2.1.хуулиар харъяалуулсан гэмт хэргийг далд аргаар үйлдсэн буюу үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай үндэслэл бүхий мэдээллийг ердийн арга хэрэгслээр шалгах боломжгүй;

11.2.2.хуулиар харъяалуулсан гэмт хэрэг үйлдсэн этгээдийг өөр арга, хэрэгслээр олж тогтоох боломжгүй;

11.2.3.эрүүгийн хэргийн нотолгоог бүрэн гүйцэд шалгах зорилгоор шүүх, прокурор, мөрдөн байцаагчаас даалгавар ирүүлсэн;

11.2.5.энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-д заасан баримт бичиг, эд зүйлийг эрж олох талаар байгууллага, иргэдээс хүсэлт ирүүлсэн;

11.2.6.эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээг Монгол Улстай байгуулсан гадаад улс, олон улсын байгууллагаас хүсэлт ирүүлсэн.

¹⁴ Авлигын эсрэг хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2006 он, №35

¹⁵ Мөн тэнд. 18 дугаар зүйлийн 18.4.5 дахь заалт

зөвшөөрлөөр, түүний хяналтан дор явуулдаг. Мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулах журам, зааврыг Тагнуулын ерөнхий газрын дарга Улсын ерөнхий прокурортой хамтран батлах¹⁶ ба авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор цагдан хорих байранд мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулж болохоор хуульчилжээ. Ийнхүү Авлигатай тэмцэх газрын холбогдох нэгжид “...авлигын гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор гүйцэтгэх ажил явуулах...” тусгай хүч, арга, хэрэгслийг ашиглах эрх олгосон нь далд аргаар үйлдэгдэг авлигын гэмт хэргийг үндсэндээ өөр аргаар илрүүлэх боломж маш багатай холбоотой юм.¹⁷

Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу гүйцэтгэх ажил явуулж, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий бусад байгууллагатай хамтран ажиллах¹⁸ бол Тагнуулын ерөнхий газар гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын үйл ажиллагаанд мэргэжлийн туслалцаа үзүүлж, хамтран ажиллах; Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9.1.2-9.1.6-д заасан байгууллагаас ирүүлсэн харилцаа холбооны сүлжээнд хяналт тавих, хуулийн дагуу тавьсан хүсэлтийг гүйцэтгэх техникийн нөхцөлийг бүрдүүлэх¹⁹ үүрэгтэй. Товчоор хэлбэл авлигын гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор гүйцэтгэх ажил явуулахад АТГ, ТЕГ, ЦЕГ хуулийн дагуу хамтран ажиллах боломжтой.

Монгол Улс 2005 оны 10 дугаар сарын 27-ны өдөр соёрхон баталсан Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 50 дугаар зүйл /мөрдөн байцаах тусгай арга хэрэгсэл/-д 1. Эрх бүхий байгууллагууд нь хяналтан дор хүргүүлэх ба ажиглан судлах болон нууц ажиллагааны цахилгаан болон бусад хэлбэр зэрэг мөрдөн байцаах бусад тусгай аргыг зохистой гэж үзсэн тохиолдолд нутаг дэвсгэртээ зохистойгоор ашиглахыг зөвшөөрөх, түүнчлэн түүнээс олж авсан нотлох баримтыг шүүхэд хүлээн зөвшөөрүүлэх талаар шаардлагатай байж болох арга хэмжээг оролцогч улс бүр бололцооныхоо хэрээр дотоодын эрх зүйн тогтолцооныхоо үндсэн зарчмаар зөвшөөрсөн хэмжээнд, дотоодын хууль тогтоомждоо заасан нөхцөлд нийцүүлэн авлигатай үр дүнтэй тэмцэхийн тулд

¹⁶ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 26.7 дугаар зүйлийн 6 дахь хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №40

¹⁷ М.Цогтоо. Гэмт хэрэг илрүүлэх үйл ажиллагаа ба гэмт хэргийн талаарх гүйцэтгэх ажлын мэдээ, баримт сэлт. Тусгаар тогтнол сэтгүүл, 2022 №3 (59). 116 дахь тал

¹⁸ Цагдаагийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 10.1.6 дахь заалтууд. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №06

¹⁹ Тагнуулын байгууллагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.9, 11.1.13 дахь заалтууд. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1999 он, №35

авна²⁰ гээд тусгай арга хэрэгслийг олон улсын түвшинд хамтран ажиллахад хэрэглэх талаар хоёр буюу олон талт хэлэлцээр байгуулахыг дэмжих, тохиролцоо байхгүй тохиолдолд шийдвэрийг хэрэг тухай бүрт гаргах, оролцогч улсуудын санхүүгийн ойлголцлыг харгалзахаар тусгасан байна. Мөн хяналтан дор хүргүүлэх аргыг олон улсын түвшинд хэрэглэх тухай шийдвэр нь бараа буюу хөрөнгийг замд нь саатуулж, хэвээр цааш явуулах эсхүл бүхлээр нь буюу хэсэгчлэн хураах буюу солих аргыг холбогдох оролцогч улсуудын зөвшөөрснөөр багтааж болно²¹ гэжээ.

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын 8 дугаар зүйлд оролцогч улс бүр авлигыг гэмт хэрэгт тооцож хуулийн болон бусад шаардлагатай арга хэмжээ авахыг заагаад 20 дугаар зүйлийн 1-д “Хэрэв дотоодын эрх зүйн тогтолцооны үндсэн зарчмууд зөвшөөрдөг бол оролцогч улс бүр өөрийн дотоодын хууль тогтоомжоор тодорхойлсон нөхцлүүдийн дагуу болон боломжийн хэмжээнд зохион байгуулалттай гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх зорилгоор тухайн нутаг дэвсгэрт өөрийн эрх бүхий байгууллагуудаас мөрдөн байцаалтын тусгай аргуудыг, түүний дотор цахим хяналт буюу хянах бусад хэлбэр, нууц ажиллагаа, хяналтан доорх нийлүүлэлтийг ашиглах боломж олгох шаардлагатай арга хэмжээг авна²²” гэсэн байна. Манай улс энэхүү конвенцод 2008 оны 05 дугаар сарын 16-ны өдөр нэгдэн оржээ.

2. Тусгай, нууц арга, хэрэгсэл: Гүйцэтгэх ажил нь төрийн эрх бүхий байгууллагаас хуульд заасан үндэслэл журмын дагуу ердийн ба тусгай, нууц арга, хэрэгсэл ашиглан явуулж байгаа ажиллагаа болохыг дээр өгүүлсэн. Тагнуул судлал, гүйцэтгэх ажлын салбарт “тусгай” гэдгийг тагнуул, нууц үйл ажиллагаатай холбон тайлбарладаг. Тэгвэл “тагнуулын арга” гэж үүрэг зорилгоо хэрэгжүүлэхэд ач холбогдол бүхий нууц болон бусад мэдээ, баримт, сэлтийг олох зорилгоор тусгай албаны ашиглаж буй арга хэмжээний цогцыг²³, “нууц арга, хэрэгсэл” гэж мэдээ, баримт сэлт нууцаар олоход зориулагдсан арга хэрэгслийг²⁴ ойлгоно. Гүйцэтгэх ажилд үг алдуулах, асуух, утсан харилцааг хянах, нууцаар ажиглах, шуудан харилцааг хянах, гүйцэтгэх ажлын (нууц)

²⁰ Төрийн мэдээлэл. 2005 он, №43(424). 873 дахь тал

²¹ Мөн тэнд. 50 дугаар зүйлийн 4 дэх хэсэг.

²² ГХЯ, ТЕГ, УЕПГ, МБ. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх чиглэлээр гаргасан баримт бичгийн эмхтгэл. УБ, 2020 он. 50 дахь тал

²³ Тагнуулын байгууллагын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалт. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1999 он, №35

²⁴ Мөн тэнд. 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалт

үзлэг, нэгжлэг, туршилт, загварчлал, холбооны техникийн сувгийг хянах, комбинаци, хуурч төөрөгдүүлэх, тагнуулч, туслагчаар нэвтрэх аргуудыг өргөн хэрэглэдэг. Ямар аргыг хэрхэн хэрэглэх нь гүйцэтгэх ажлын тухайн тодорхой нөхцөл байдлаас хамаарна.²⁵ Гүйцэтгэх ажлын арга, гүйцэтгэх ажлын арга хэмжээ гэх нэр томъёо ерөнхийдөө ижил утгатай бол арга болон хэрэгсэл нь өөр ойлголт. Хуульд тусгаснаар гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авах, илрүүлэхэд зориулагдсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ.²⁶ Зарим төрлийн нууц арга хэмжээг тусгай зориулалтын техник хэрэгслийн тусламжтайгаар гүйцэтгэнэ.

Гэмт хэргийг нууцаар мөрдөн шалгах ажиллагаанд дэлхийн олонхи улс орон дор дурдсан аргуудыг хэрэглэдэг. Үүнд: 1.гүйцэтгэх ажлын асуулга тавих, 2.нууцаар лавлагаа гаргуулах, 3.харьцуулан шинжилгээ хийхийн тулд дээж загвар цуглуулах, 4.шалгалт хийх зорилгоор худалдан авах, 5.эд зүйлс ба баримт бичгийг шинжлэх, 6.гүйцэтгэх ажлын ажиглалт хийх, 7.бие хүнийг нууцаар таниулах, 8.нууц үзлэг хийх, 9.шуудан, цахилгаан ба бусад харилцааны мэдээлэлд хяналт хийх, 10.утсан харилцааг хянах, 11.холбооны техникийн сувгаас мэдээлэл олж авах, 12.гүйцэтгэх ажлын нэвтрэх арга хэмжээг хэрэгжүүлэх, 13.хууль бус зөөвөрлөлтөд нууцаар хяналт хийх, 14.гүйцэтгэх ажлын туршилт хийх, 15.биечлэн мөрдөх, 16.хуулийн этгээдийг байгуулах, 17.хүний бие сэтгэл зүйн онцгой чадварыг ашиглах, 18.үйлдэгдсэн гэмт хэрэгтэй холбоотой этгээдийн сэтгэл зүйн хөрөг дүрийг бүтээх, 19.гэмт хэрэг үйлдсэн этгээд ба бусад иргэнтэй хэлэлцээр хийх гэх мэт.²⁷

Тухайлбал, эрх зүйн тогтолцоо, хуулийн зохицуулалт бараг ижил бидний хойд хөрш ОХУ-ын Шуурхай эрэн сурвалжлах ажиллагааны тухай хуулийн 6 дугаар зүйлд:

1. Асуулга,
2. Лавлагаа авах,
3. Харьцуулсан шинжилгээнд зориулж дээж цуглуулах,
4. Шалгалтын худалдан авалт,

²⁵ М.Цогтоо. Тагнуулын нэвтэрхий толь. УБ, 2014 он. 47 дахь тал

²⁶ Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1998 он, №3

²⁷ Л.Батдолгор. Тагнах үйл ажиллагааны эрх зүйг төгөлдөршүүлэх нь. УБ, 2014 он. 134 дэх тал

5. Эд зүйл, баримт бичгийг судлах,
6. Ажиглалт,
7. Нууц тодорхойлолт,
8. Байшин, барилга, газар орон, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх,
9. Шуудан илгээмж, цахилгаан мэдээг хянах,
10. Утасны яриаг чагнах,
11. Холбооны техникийн сувгаас мэдээлэл олзлох,
12. Нэвтрэлт,
13. Хяналттай хүргэлт,
14. Туршилт,
15. Компьютерийн мэдээлэл олж авах²⁸ арга хэмжээнүүдийг заасан байдаг.

Тагнуул, гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагааны янз бүрийн арга, хэрэгслүүдийг алба, нэгжийн чиг үүрэг, тухайн үйл ажиллагааны зорилго, чиглэл, тодорхой нөхцөл байдалтай уялдуулан холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр ашигладаг. Авлигатай тэмцэх газрын гүйцэтгэх ажилтан Гүйцэтгэх ажлын тухай хууль, эрх бүхий мөрдөгч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Мөрдөн шалгах нууц ажиллагааны журамд заасан нууц арга, хэрэгслийг прокурорын зөвшөөрөл, хяналт дор хэрэгжүүлнэ. Үүнд:

- харилцаа холбооны сүлжээнд хяналт тавих;
- шуудан харилцааг хянах;
- орон байр, барилга байгууламж, газар, тээврийн хэрэгсэл, ачаа, тээш, эд зүйлд нууц үзлэг хийх;
- нууцаар ажиглалт явуулах;
- хяналтын худалдан авалт;
- нууцаар сонсох, харах тусгай техник хэрэгсэл ашиглах;²⁹
- нууц туршилт;
- нууц таньж олуулах ажиллагаа;
- мөнгөн хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг нууцаар хянах;

²⁸ Федеральный закон от 12.08.1995 N 144-ФЗ «Об оперативно-розыскной деятельности» (последняя редакция) http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_7519/

²⁹ Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1998 он, №3

- тусгай техник хэрэгсэл ашиглан хяналт тогтоох;
- хяналттай хүргэлт³⁰ багтана.

Хуулийн үндэслэл, бодит шаардлагаар дээрх нууц ажилгаануудын аль нэгийг, эсхүл хэд хэдийг нь зэрэг хэрэгжүүлж болох ба гүйцэтгэх ажлын бусад арга болон мөрдөн шалгах ил ажиллагаатай хослуулан явуулна. Гүйцэтгэх ажлын заавар нь нууцын зэрэглэлтэй тул түүнд тусгасан аргууд ороогүй болно. Олон улсын жишиг, хөрш орнуудын туршлага, практикаар шалгарсан авлигын гэмт хэрэгтэй тэмцэхэд өргөн ашигладаг зарим аргуудын талаар дэлгэрүүлье.

· Олон улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх байгууллага (ФАТФ)-ын Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны зөвлөмжид тусгасан мөрдөн шалгах ажиллагааны аргуудад (76) нууцаар ажиглах, (80) хяналттай хүргэлт, (82) харилцаа холбооны сүлжээнд хяналт тавих, (84) халхавчилсан арга хэмжээ орно. Эдгээрийн онцлогийг тайлбарлавал:

- Сэжигтнийг нууцаар ажигласнаар санхүүгийн болон бусад бүртгэл, мэдээлэл хадгалагдаж буй газрыг зааж өгөхийн зэрэгцээ хөрөнгө, мөнгөний байрлалыг олж илрүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Түүнчлэн нууцаар ажиглах арга хэмжээ нь өмнө авагдсан санхүүгийн мэдээллийг бататгах, бусад сэжигтэн, хамтран оролцогчийг олж тогтооход ач холбогдолтой.³¹

- Хяналттай хүргэлт нь хууль сахиулах байгууллагын ажилтны зааварчилгаа эсхүл нууц ажиглалт дор улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон, хязгаарласан бараа бүтээгдэхүүн, валют, төлбөрийн хэрэгслийг сэжиглэгдэж буй этгээдэд тээвэрлэн хүргэхэд чиглэгдсэн мөрдөн шалгах ажиллагааны үр дүнтэй арга юм.³² Үүнийг гэмт хэрэг үйлдсэн хүнийг олж тогтоох, үйлдлийг нотлохын хамт сэжигтэн этгээдийн хууль бус хөрөнгийг илрүүлэх зорилгоор явуулдаг.

- Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд цахим хяналтын арга болох утсан харилцааг хянах, нууцаар сонсох, цахим шууданг олзлох, байршил тогтоох төхөөрөмж ашиглах зэрэг цахим хяналтын арга нэлээд үр дүнтэй

³⁰ “Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах журам”. Улсын ерөнхий прокурор, тагнуулын ерөнхий газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/116, А/177 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт.

³¹ ФАТФ-ын тайлан. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны зөвлөмж /2012 оны 6 дугаар сар/. УБ, 2017 он. 50-51 дэх тал

³² Мөн тэнд. 53 дахь тал

байдаг. Харилцаа холбооны сүлжээнд хяналт тавих арга хэмжээ нь хувь хүний алба, амины амьдрал, хувийн нууцад хөндлөнгөөс халддаг, их хэмжээний нөөц хөрөнгө шаарддаг, албадлагын шинжтэй гэдгийг харгалзан улс орнууд хуулийн дагуу, үр дүнтэй, зохистой ашиглах механизм бүрдүүлэх шаардлагатай³³ юм.

- Халхавчилсан арга хэмжээ гэдэгт хууль сахиулах эрх бүхий байгууллагын ажилтан, гүйцэтгэх ажилтан хууль сахиулах байгууллагын тодорхой заавар чиглэлийн дагуу нотлох баримт, мэдээлэл цуглуулахаар зохиомол аж ахуйн нэгж байгуулах, итгэл үнэмшилтэй дүрд хувирах үйл ажиллагаа явуулахыг хэлнэ. Арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд оролцох хүнийг сонгох, дэмжлэг үзүүлэх бүрэлдэхүүнд ажиллах, ашиглах тоног төхөөрөмжийн жагсаалт гаргаж бэлэн байдлыг хангах, төлөвлөгөө боловсруулж төсөв зохиох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүч, хэрэгсэл, нөөц боломжийг тодорхойлох хэрэгтэй. Мөн чанарын хувьд эрсдэлтэй гэдэг утгаараа энэ төрлийн мөрдөн шалгах ажиллагааны аргыг гарцаагүй нөхцөл байдал үүссэн үед хэрэгжүүлдэг. Гагцхүү өндөр түвшинд бэлтгэгдсэн нууц ажилтан халхавчилсан арга хэмжээнд оролцох ёстой.³⁴

БНХАУ-ын Улс төрийн ба хууль зүйн ухааны Их сургуулийн профессор Фанг Чонг-и “Авлигын гэмт хэргийг гүйцэтгэх ажлаар шалгах ба илрүүлэх ажиллагааны нууцлал, техникийн хэрэгслийн найдвартай байдлыг хангасан нөхцөлд гүйцэтгэнэ. Авлигын гэмт хэргийг шалгах ба илрүүлэх ажиллагааны үндсэн агуулгад дараах зүйлүүд багтана. Үүнд: сэжигтэй этгээдийг нууцаар ажиглах, нууц үзлэг хийх, нотлох баримтыг нууцаар таньж авах, чагнах ба бичлэг хийх, шуудан харилцааг замаас нь барьж авах, нүд ба чихээр шалгаж тогтоох”³⁵ гэж бичсэн байдаг.

Гүйцэтгэх ажлын туршилтыг хяналтын дор амжилттай зохион байгуулах, үйлдэл дээр нь гэмт этгээдийг баривчлах ажиллагааг өнөө үед хээл хахуультай тэмцэх үндсэн шийдвэрлэх арга гэж үздэг. Гэмт этгээдүүдэд оноосон ялын 80 гаруй хувь чухамдаа энэхүү арга хэмжээний үр дүнд цуглуулсан баримт нотолгоонд тулгуурладгийг судлаачид тогтоожээ. Гүйцэтгэх ажлын туршилтыг зөвхөн хүнд гэмт хэрэг буюу хээл хахуулийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох онцгой тохиодолд урьдчилан сэргийлэх зорилгоор гүйцэтгэх ажил

³³ Мөн тэнд. 54-55 дахь тал

³⁴ Мөн тэнд. 55-56 дахь тал

³⁵ Л.Батдолгор. Авлигын гэмт хэрэг ба түүнийг гүйцэтгэх ажлаар шалгаж илрүүлэх тухай ойлголт. АТГ.Шударга ёс. Мэдээлэл, онол, аргазүйн улирал тутмын цуврал, 2010 №1 (2). 35 дахь тал

эрхэлдэг байгууллагын даргын тогтоолоор зохион байгуулдаг³⁶ бөгөөд гүйцэтгэх ажлын туршилтын үр дүн нь түүнийг зохиох явцад олсон шалгагдаж буй албан тушаалтны тухай болон түүний гэмт санаархал, хань харилцаа, гэмт хэрэг үйлдсэн шалтгаан, аргын тухай болон туршилтын зарим чухал хэсгүүдийг баримтжуулсан материал (аудио, видео хальс зэрэг зүйлсийг хавсаргасан)-аас гүйцэтгэх ажилтны бүрдүүлсэн лавлагаа, түүнчлэн гүйцэтгэх ажлын туршилтын явцад тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэн нь илэрсэн боловч янз бүрийн нөхцөл байдлын улмаас туршилтын эцэст таслан зогсоогдоогүй тухай гүйцэтгэх ажилтны бичсэн тэмдэглэл³⁷ зэрэгт агуулагдана. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд прокурорын зөвшөөрлөөр явуулах мөрдөн шалгах нууц туршилтыг мөрдөгч хийж болно.³⁸

Нууц гүйцэтгэх ажилтнууд болон төлөөлөгчид нь авлигын гэмт хэргийн мөрдөн байцаалтын үед мэдээлэл цуглуулахад маш чухал үүрэг гүйцэтгэдэг.³⁹ Өөр байгууллагад халхавчийн дор ажиллаж байгаа тусгай албаны ажилтныг нууц гүйцэтгэх ажилтан⁴⁰ гэх бөгөөд нууц гүйцэтгэх ажилтан гүйцэтгэх ажлын зорилтыг хэрэгжүүлэхээр гэмт орчинд нэвтрэн орохыг гүйцэтгэх ажлын нэвтрэлтийн арга хэмжээ гэнэ. Зохион байгуулалттай гэмт бүтцийн холбоо сүлжээг тогтоох, тэдний гэмт үйл ажиллагааны явц, төлөвлөгөө, санхүү – эдийн засгийн нууц эх сурвалж зэргийг тогтоох, тэдний хүчийг дотроос нь сарниулахад гүйцэтгэх ажлын нэвтрэлтийг ашиглах нь шалгарсан арга юм.⁴¹ Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуульд нийтийн албан тушаалтан хахууль авах (22.4 дүгээр зүйл) хахууль өгөх (22.5 дугаар зүйл)⁴² гэмт хэргүүдийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол хүндрүүлж үзэхээр тусгасан байдаг. Авлигад автасан албан тушаалтнууд зохион байгуулалттай гэмт хэргийн ертөнцөд тодорхой байр суурь эзлэх⁴³ бөгөөд гэмт бүлгийн хууль бус үйл ажиллагааг далдлах, дэмжлэг үзүүлэх байдлаар хамтардаг. Олон

³⁶ ХЗҮХ, АНУ-ын Азийн сан. Авлига, албан тушаалын гэмт хэрэг /Хуульчдад зориулсан гарын авлага/. УБ, 2014 он. 143 дахь тал

³⁷ Г.Гэрэлчулуун. Авлига, хил дамнансан гэмт хэрэг, мансууруулах бодис, сэтгэгцэд нөлөөлөх эм бэлдмэл, зэвсэг, галт хэрэгслийн хууль бус худалдаатай тэмцэхэд тагнуулын байгууллагын оролцоо. УБ, 2010 он. 19-20 дахь тал

³⁸ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 23.5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг. Төрийн мэдээлэл эмхтгэл 2017 он, №23

³⁹ ЕАБХАБ. Авлигатай тэмцэх гарын авлага. УБ, 2016 он. 221 дэх тал

⁴⁰ Тагнуулын байгууллагын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалт. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1999 он, №35

⁴¹ З.Төрмандах. Д.Адьяабазар. Зохион байгуулалттай гэмт хэргтэй тэмцэх үндэс. УБ, 2005 он. 76 дахь тал

⁴² Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2016 он, №07

⁴³ З.Төрмандах. Д.Адьяабазар. Зохион байгуулалттай гэмт хэргтэй тэмцэх үндэс. УБ, 2005 он. 11 дэх тал

улсын гэмт хэргийн байгууллагуудыг хянах нь чухал ажил боловч авлигын асуудлыг зөвхөн эрүүгийн эрх зүйн үүднээс шийдэх гэж оролдох нь илэрхий учир дутагдалтай⁴⁴ байж мэднэ.

3. Хэрэгцээ шаардлага, ач холбогдол: Авлига тухайн улс, орны төр, нийгэм, эдийн засгийн бүх салбарт нэвчин хууль ёсыг ганхуулж, шударга бусыг цэцэглэн хөгжүүлдэгээрээ туйлийн хортой тул боломжит бүх аргаар тэмцэх шаардлагатайг дахин онцлоё.

Гэмт хэрэгтэй тэмцэх нэг хэлбэр бол түүнээс урьдчилан сэргийлэх бөгөөд гэмт хэргийн шалтгаан нөхцлийг тогтоож, арилгах нь барьж шийтгэхээс илүү үр өгөөжтэй байдаг тул хойш тавьж болохгүй. Нууц ажиллагааг зарим тохиолдолд шударга байдлыг сорих, албан хаагч болон ажлын хэвшил авлигыг эсэргүүцэх түвшинг үнэлэх зэрэг өөр зорилгоор ашигладаг.⁴⁵ Өөрөөр хэлбэл гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах бус гэмт хэрэгт нөлөөлж буй шалтгааныг олж тогтоох зорилгоор тагнан ярилцлага, нууц ажиглалт, нууц туршилт гэх мэт арга хэмжээг хийж болно гэсэн үг. Хамгийн гол нь хууль зөрчиж, хүний эрх, эрх чөлөөнд халдах ёсгүй. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд Авлигатай тэмцэх газрын гүйцэтгэх ажил явуулах эрхийг заахдаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гэж тусгаагүй (бусад гүйцэтгэх байгууллагын гүйцэтгэх ажил явуулах эрхэд тусгасан) байна. Гэвч гүйцэтгэх байгууллага, гүйцэтгэх ажилтан гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж завдаж байгаа тухай, түүнчлэн улс, нийгмийн аюулгүй байдалд хохирол учруулахуйц үйл ажиллагааны тухай мэдээ, мэдээлэл авмагц гарч болох аюул хохирлыг багасгах, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тус тусын чиг үүргийн дагуу шуурхай авах; өөрийн болон гүйцэтгэх, туслах ажилтны аюулгүй байдлыг хангах, хууль тогтоомжоор хүлээсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулж тэдгээрт учирч болох халдлагаас урьдчилан сэргийлэх⁴⁶ үүрэгтэйгээс гадна гүйцэтгэх ажлын үр дүнг гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг эрэн сурвалжлах, нотлох баримт цуглуулах, тэдгээрийн эх сурвалжийг олж тогтоох⁴⁷ зорилгоор ашиглах учиртай.

Түүнчлэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тусгай чиглэлд

⁴⁴ Сьюзан Роуз-Аккерман. Авлига, төр хоёр /шалтгаан, үр, шинэтгэл/. УБ, 2007 он. 267 дахь тал

⁴⁵ ЕАБХАБ. Авлигатай тэмцэх гарын авлага. УБ, 2016 он. 221 дэх тал

⁴⁶ Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн 13.3.2, 13.3.4 дэх заалтууд. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1998 он, №3

⁴⁷ Мөн тэнд. 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт.

зохион байгуулалттай гэмт бүлгийн үйл ажиллагааг таслан зогсоох, тэдгээрийн хоорондын харилцаа холбоо, гэмт хэргийн улмаас олсон ашиг орлого, хөрөнгө мөнгөний урсгалыг таслан зогсоох; зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэхдээ тэдгээрийн гүйцэтгэсэн үүрэг, оролцооноос хамааран ялгамжтай авч үзэх, тэдгээрийн зүгээс хууль сахиулах байгууллагатай сайн дураараа хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; гэмт хэргийг илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн хууль сахиулах байгууллагатай хамтран ажилласан этгээдийн аюулгүй байдлыг хангах; гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг арилгах, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх; төсвийн хөрөнгийг зарцуулах үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах;⁴⁸ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан нэг бүрчилсэн чиглэлийн хүрээнд гэмт хэрэг үйлдэж болзошгүй, үйлдэхээр бэлтгэж байгаа этгээдийг цаг тухайд нь олж тогтоох, гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнө таслан зогсоох; гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор гэмт хэрэг үйлдэж, хорих ял шийтгүүлж суллагдсан хүнд хяналт тавих; хуульд заасны дагуу гэмт хэргийг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, баримт сэлт өгөх болон бусад байдлаар туслалцаа үзүүлсэн гэрч, хохирогч, шаардлагатай тохиолдолд түүний хамаарал бүхий этгээдийг гэмт халдлагаас хамгаалах⁴⁹ үйл ажиллагааг тусгай, нууц арга, хэрэгсэлгүйгээр хэрэгжүүлэхэд учир дутагдалтай юм.

Авлигын олон төрөл байх бөгөөд тэдгээрийг янз бүрээр ангилсан байдаг боловч үндсэнд нь 3 бүлэгт хуваан үзэж болно. Үүнд:

- Жижиг авлига – бага албан тушаалын албан хаагчид хамааралтай байдаг, авлигын хохирогчид нь нийтлэг шинжтэй олныг хамарсан жирийн иргэд байдаг. Жижиг авлигыг хүнд суртлын гэж бас нэрлэдэг.

- Том авлига – улс төр, санхүү, захиргааны томоохон албан тушаалтнууд бодлого боловсруулах, хэрэгжүүлэх явцад албан тушаалаа хувийн ашиг хонжоо олоход ашигласан их хэмжээний мөнгөн дүнтэй үйлдлийг ойлгоно.

- Улс төр, захиргаа, бизнесийн авлига – Голдуу сонгууль, эрх мэдлийн төлөөх үйл явцтай уялдаа холбоотойгоор илрэлээ олдог.⁵⁰ Тэгвэл манай улсад

⁴⁸ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.2.1, 8.2.4, 8.2.5, 8.2.6 дахь заалтууд. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2019 он, №42

⁴⁹ Мөн тэнд. 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2, 9.2.7 дахь заалтууд

⁵⁰ Б.Одонтунгаа, Х.Болормаа. Монгол Улс дахь авлига, албан тушаалын гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал. МУИС-ХЗС. “Албан тушаалын гэмт хэрэг: Эрүүгийн эрх зүй,

эдгээр бүх түвшиний авлига идэвхтэй оршин буйг авлигын гэмт хэргийн нөхцөл байдал, авлигын индексийн үзүүлэлтээс дүгнэж болно.

Улсын хэмжээнд сүүлийн 4 жилд бүртгэгдсэн авлигын гэмт хэргийн тоо мэдээлэл (2020 онд 314, 2021 онд 335, 2022 онд 475, 2023 онд 569)⁵¹- ээс харвал тогтмол нэмэгджээ. Энэ оны эхний 9 сарын байдлаар мөрдөн шалгах ажиллагаанд 879 хэрэг шалгагдаж байна⁵² гэхээр 2024 онд мөн л гэмт хэргийн статистик өссөн дүнтэй гарна. Авлигын гэмт хэргийн өсөлтийг гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн тоо, хэргийн илрүүлэлттэй холбон үзэж болох ч энэ нь тун бага хувь эзэлнэ. Криминологийн онол ёсоор нэг илэрсэн гэмт хэргийн цаана гурваас арван нуугдмал гэмт хэрэг байдаг гэж⁵³ тооцвол нөхцөл байдлыг улам хүндрүүлнэ.

Авлигын төсөөллийн индексээр Монгол улс 2021 оноос хойш 5-6 байраар ухарч, өнөөдрийн байдлаар дэлхийн 180 улсаас 121-т⁵⁴ эрэмблэгдэж байна. Улсын төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулж байгаа эсэх, төрийн нийтийн албан хаагч албан тушаалаа урвуулан ашиглаж байгаа эсэх, авлигын гэмт хэрэгт холбогдсон төрийн албан тушаалтанд хариуцлага тооцож байгаа эсэх, төр засаг нь авлигын эсрэг үр дүндтэй тэмцэж, шударга байдлыг төрийн салбарт хэрэгжүүлж байгаа эсэх, авлигыг мэдээлсэн шүгэл үлээгч, сэтгүүлч нарыг хамгаалсан хууль эрх зүйн орчин⁵⁵ гэх мэтийг үнэлж хэмжин авлигын жагсаалтыг гаргадаг учир эдгээр ба бусад харгалзах хүчин зүйлүүдэд доголдол байгаа нь батлагдана.

Гүйцэтгэх ажлын шугамаар урьдчилан сэргийлж таслан зогсоосон, шалгаж баримтжуулсан авлигын гэмт хэрэг, эрэн сурвалжилсан хүн, эд зүйл, байршлыг тогтоосон мөнгө, хөрөнгийн төрийн нууцад хамаарах тоо судалгааг энд мэдээлэх боломжгүй ч авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаанд тусгай, нууц, арга хэрэгслийг ашигласнаар авлигын гэмт хэргийн шалтгаан нөхцлийг тогтоож, арилгах тусгай болон нэг бүрчилсэн арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэх, авлигын гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээд, тэдний хууль бус орлого, эд хөрөнгийг

эрүүгийн процессын эрх зүйн тулгамдсан асуудал” эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ, 2015 он. 39 дэх тал

⁵¹ https://www.1212.mn/mn/statistic/statcate/573071/table-view/DT_NSO_2300_001A1

⁵² <https://iaac.mn/post/160119>

⁵³ Ц.Цэлмэг. Криминологи. УБ, 2005 он. 79 дэх тал

⁵⁴ <https://www.transparency.org/en/cpi/2023>

⁵⁵ <https://ikon.mn/n/32cp>

цаг алдалгүй илрүүлэх, шаардлагатай мэдээлэл олж авах, нотлох баримтыг шуурхай, бүрэн бүрдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой болох нь тодорхой юм.

Дүгнэлт, санал

Монгол улсад авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, мөрдөхөд эрх бүхий байгууллага (Авлигатай тэмцэх газар)-аас хууль тогтоомж (Гүйцэтгэх ажлын тухай хууль, Тагнуулын байгууллагын тухай хууль, Авлигын эсрэг хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гүйцэтгэх ажлын заавар, Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах журам), нэгдэн орсон Авлигын эсрэг болон Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенциудад заасан гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах тусгай арга, нууц ажиллагааг дангаар эсхүл бусад мөрдөн шалгах болон гүйцэтгэх байгууллагатай хамтран явуулах эрхтэй. Товчхондоо авлигатай тэмцэхэд тусгай, нууц арга, хэрэгслийг ашиглах эрх зүйн орчин бүрдсэн байна. Гэхдээ гэмт хэрэг мөрдөн шалгах нууц ажиллагаанд олон улсад өргөн хэрэглэдэг, тэр дундаа ОХУ-ын Шуурхай эрэн сурвалжлах ажиллагааны тухай хуульд заасан гүйцэтгэх ажлын дийлэнх арга хэмжээнүүд манай улсын холбогдох хуульд байхгүй бөгөөд гүйцэтгэх байгууллагуудын маш нууцын зэрэглэлтэй заавар, журмаар зохицуулагдаж байна. Тэгэхээр заавар, журамд тусгасан тэдгээр аргуудыг Гүйцэтгэх ажлын тухай хуульд орууснаар нэг талаас авлигын болон бусад гэмт хэрэгтэй тэмцэхэд нууц арга, хэрэгсэл ашиглах хэд хэдэн нөхцөл хуульчлагдан баталгаажиж, нөгөө талаас мөрдөн шалгах ажиллагааны явцад хүний эрх зөрчигдөхөөс сэргийлэх боломж нэмэгдэнэ.

ФАТФ-ын Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны зөвлөмж, гадаад орнуудын туршлага, нөхцөл байдлаас харвал авлигын гэмт хэрэгтэй тэмцэхэд түүний онцлогоос шалтгаалан гүйцэтгэх ажлын туршилт, нэвтрэлт, нууц ажиглалт, харилцаа холбооны сүлжээг хянах зэрэг аргууд илүү үр дүнтэй ажээ. Эдгээр арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэхэд сайтар боловсруулсан төлөвлөгөө, бэлтгэгдсэн нууц гүйцэтгэх ажилтан, найдвартай техник хэрэгсэл зайлшгүй шаардлагатай төдийгүй нууцлал, аюулгүй байдлыг хангах, хууль бусаар хүний эрх, эрх чөлөөнд халдахгүй байх, нөөц хүч, хөрөнгийг зохистой, үр ашигтай зарцуулах тал дээр анхаарах хэрэгтэй болдог байна. Нууц ажиллагааг авлигын гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгахаас гадна гүйцэтгэх байгууллага, гүйцэтгэх ажилтан гэмт үйлдлийг таслан зогсоох, учирч болох аюул, халдлагаас урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлэх хүрээнд,

мөн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тусгай болон нэг бүрчилсэн арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр явуулах хуулийн зохицуулалт, практик шаардлага бий. Хуульд зааснаар тагнуул, цагдаа, цэргийн тагнуул, шүүхийн шийдвэр шийдвэр биелүүлэх байгууллага гүйцэтгэх ажил явуулахдаа гэмт хэрэг, халдлага, заналхийллээс “урьдчилан сэргийлэх” эрхтэй бол Авлигатай тэмцэх газрын гүйцэтгэх ажил явуулах зорилгод үүнийг тусгаагүй байна. Нэгэнт гүйцэтгэх ажлын үр дүнг гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх... зорилгоор ашиглах тул Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.6-д “Авлигатай тэмцэх газар нь авлигын гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох” гэсний дараа “урьдчилан сэргийлэх” зорилгоор гүйцэтгэх ажил явуулах гэж орууснаар асуудлыг шийднэ.

Олон улсын байгууллагын авлигын индексийн үзүүлэлт, дотоодын авлигын гэмт хэргийн тоо мэдээллээс дүгнэн үзвэл цаашид энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдал хүндэрч, тэр хэрээр авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, мөрдөн шалгахад тусгай, нууц арга, хэрэгсэл ашиглах хэрэгцээ шаардлага улам өсөх хандлагатай байна. Авлигын гэмт хэрэгтэй тэмцэхэд гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагааны ач холбогдол асар их тул гадаадын хууль сахиулах байгууллага болон дотоодын мөрдөх, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх, Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах, гүйцэтгэх нэгжийн хүч хэрэгслийн нөөц, мөрдөгч, гүйцэтгэх ажилтан нарын мэдлэг, ур чадвар, туршлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн олон талт арга хэмжээнүүдийг тогтмол авч хэрэгжүүлбэл зохилтой юм.

Эх сурвалж

Нэг.Олон улсын гэрээ, хууль тогтоомж:

1. Авлигын эсрэг конвенц.Төрийн мэдээлэл. 2005 он, №43
2. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц
3. Авлигын эсрэг хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2006 он, №35
4. Гүйцэтгэх ажлын тухай хууль.Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1998 он, №3
5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2019 он, №42
6. Тагнуулын байгууллагын тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1999 он, №35
7. Цагдаагийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №06

8. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №40
9. Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2016 он, №07
10. Авлигатай тэмцэх таван үйл ажиллагаа. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 сарын 08-ны өдрийн 49 дүгээр тогтоол
11. Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах журам. Улсын ерөнхий прокурор, тагнуулын ерөнхий газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/116, А/177 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт
12. Федеральный закон от 12.08.1995 N 144-ФЗ “Об оперативно-розыскной деятельности”

Хоёр. Эрдэм шинжилгээний бүтээл, эмхэтгэл:

1. Л.Батдолгор. Тагнах үйл ажиллагааны эрх зүйг төгөлдөршүүлэх нь. УБ, 2014 он
2. Г.Гэрэлчулуун. Авлига, хил дамнасан гэмт хэрэг, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, зэвсэг, галт хэрэгслийн хууль бус худалдаатай тэмцэхэд тагнуулын байгууллагын оролцоо. УБ, 2010 он
3. С.Нарангэрэл. Монголын эрх зүйн эх толь бичиг. Дөрөв дэх хэвлэлт. УБ, 2015 он
4. Х.Нямбаатар, Д.Мөрөн нар. Эрүүгийн эрх зүй (ерөнхий ба тусгай анги). УБ, 2017 он
5. Сьюзан Роуз-Аккерман. Авлига, төр хоёр /шалтгаан, үр, шинэтгэл/. УБ, 2007 он
6. З.Төрмандах. Д.Адъяабазар. Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үндэс. УБ, 2005 он
7. М.Цогтоо. Тагнуулын нэвтэрхий толь. УБ, 2014 он
8. Ц.Цэлмэг. Криминологи. УБ, 2005 он
9. ЕАБХАБ. Авлигатай тэмцэх гарын авлага. УБ, 2016 он
10. ФАТФ-ын тайлан. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны зөвлөмж /2012 оны 6 дугаар сар/. УБ, 2017 он
11. ХЗҮХ, АНУ-ын Азийн сан. Авлига, албан тушаалын гэмт хэрэг /Хуульчдад зориулсан гарын авлага/. УБ, 2014 он
12. ГХЯ, ТЕГ, УЕПГ, МБ. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй

олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх чиглэлээр гаргасан баримт бичгийн эмхтгэл. УБ, 2020 он

- 13.Л.Батдолгор. Авлигын гэмт хэрэг ба түүнийг гүйцэтгэх ажлаар шалгаж илрүүлэх тухай ойлголт. АТГ.Шударга ёс. Мэдээлэл, онол, аргазүйн улирал тутмын цуврал, 2010 №1 (2)
- 14.Б.Баярсайхан. Авлигын гэмт хэргийн шалтгааныг тодорхойлох нь. АТГ. Шударга ёс. Мэдээлэл, онол, аргазүйн хагас жил тутмын цуврал 2020 (20)
- 15.Д.Баярсайхан. Албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа ба хүний эрх. МУИС-ХЗС. “Албан тушаалын гэмт хэрэг: Эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын эрх зүйн тулгамдсан асуудал” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ, 2015 он
- 16.Б.Одонтунгалаг, Х.Болормаа. Монгол Улс дахь авлига, албан тушаалын гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал. МУИС-ХЗС. “Албан тушаалын гэмт хэрэг: Эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын эрх зүйн тулгамдсан асуудал” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ, 2015 он
- 17.М.Цогтоо. Гэмт хэрэг илрүүлэх үйл ажиллагаа ба гэмт хэргийн талаарх гүйцэтгэх ажлын мэдээ, баримт сэлт. Тусгаар тогтнол сэтгүүл, 2022 №3 (59)

Гурав. Цахим эх сурвалж:

<https://iaac.mn/>

<https://www.legalinfo.mn/>

<https://www.1212.mn/mn/statistic/>

<https://ikon.mn/>

<https://toli.query.mn/>

<https://www.transparency.org/>

<http://www.consultant.ru/>



Д.ОЧБАЯР

*АТГ-ын ТХ-ийн нягтлан бодогч-ажилтан, комиссар, докторант
Accountant, commissioner Administration Department of the IAAC*

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАЛТ: ОНЦЛОГ, АВЛИГААС АНГИД ЯВУУЛАХ НЬ

Public Procurement: Key Characteristics and Strategies for Eliminating Corruption

*Авлига нь хөгжилд чиглэсэн хөрөнгийг өөр тийш нь чиглүүлж,
Засгийн газрын үндсэн үйлчилгээ үзүүлэх чадавхийг алдагдуулж,
тэгш шударга бус байдлыг өдөөж, гадаадын хөрөнгө оруулалт,
тусламжийг үргээх замаар орлого багатай иргэдэд хохирол учруулдаг.¹*

Corruption significantly impacts low-income citizens by misappropriating development funds, weakening the government's capacity to deliver essential services, exacerbating inequality, and deterring foreign investment and aid.

Хураангуй: Төрийн худалдан авалтын ач холбогдол нь эдийн засгийн хувьд төр төрийн худалдан авалтад зарцуулсан мөнгөний үнэ цэнэ, түүний үр дүнг хамгийн бага өртгөөр бий болгох, хууль зүйн хувьд төр худалдан авах ажиллагааг шударгаар, өрсөлдөөний тэгш байдлыг хангаж, ил тод зохион байгуулснаар тодорхойлогдоно. Төрийн худалдан авалт нь эрчим хүчний хэмнэлтээс авахуулаад эрүүл мэндийн үйлчилгээ

Abstract: The economic significance of public procurement is highlighted by the value of substantial funds allocated to it and the achievement of outcomes at minimal cost. The legal aspect is fair and transparent processes. Public procurement is a crucial public policy tool, impacting citizens' lives, from energy efficiency to healthcare. Given the extensive

¹ UNITED NATIONS CONVENTION AGAINST CORRUPTION, Foreword, https://www.unodc.org/documents/treaties/UNCAC/Publications/Convention/08-50026_E.pdf

хүртэл иргэдийн амьдралд нөлөөлдөг засгийн газрын үйлчилгээ үзүүлэх төрийн бодлогын хэрэгсэл юм. Зардлын хэмжээ нь асар их учраас сайн засаглалтай төрийн худалдан авалт нь төрийн байгууллагын үр ашгийг дээшлүүлэх, иргэдийн итгэлийг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг төдийгүй төрийн бодлогыг хэрэгжүүлэх хэрэгсэл, эдийн засгийн өсөлтийг дэмжих хөшүүрэг болдог.

Төрийн худалдан авалтад авлига байсаар байгаа нь:

- төсвийн зардлын багагүй хувийг буюу “дэлхийн хэмжээнд засгийн газрын жилийн зардлын 50 хүртэлх хувь”²-тай тэнцэх хэмжээний мөнгийг зарцуулдагтай холбоотой. Үнэн хэрэгтээ зарим зах зээлд авлига, хээл хахууль нь бизнес эрхлэх ердийн арга зам бөгөөд хялбараар баяжих хэрэгсэл гэдгийг хамгийн нэр хүндтэй бизнес эрхлэгчид ч хүлээн зөвшөөрдөг³ байна. Дэлхийн банкны судалгаагаар төрийн худалдан авалт дахь авилга нь “тухайн төслийн зардлын 10-30 хувийг эзэлдэг”⁴ байна. Авлига нь - худалдан авах ажиллагааны хүрэх үр дүнд нөлөөлж, мөнгөний үнэ цэнийг бууруулснаар эдийн засгийн өсөлтийг саармагжуулах сөрөг нөлөөтэй тул төсвийн мөнгөний зарцуулалтыг сайжруулах, иргэдийн амьжиргааны түвшинг нэмэгдүүлэх, орлогын тэгш хуваарилалтыг дэмжих зорилгоор дэлхийн улсууд төрийн худалдан авалт дахь “авилга”-ын асуудлыг төрийн бодлогын түвшинд авч үзэн шийдвэрлэх арга замыг эрэлхийлдэг.

expenditure involved, effective public procurement governance is vital for enhancing the efficiency of public institutions, fostering public trust, implementing government policies, and stimulating economic growth. Despite its importance, corruption remains prevalent in public procurement, often consuming a significant portion of the budget—up to 50% of annual government expenditure globally. Corruption and bribery are commonplace in some markets, even among reputable business owners. A World Bank study indicates that corruption in government procurement can account for 10-30% of a project’s cost. Corruption negatively impacts economic growth by distorting procurement outcomes and diminishing value for money. Consequently, countries worldwide are addressing corruption in public procurement to improve public spending, elevate citizens’ living standards, and promote equitable income distribution, seeking policy-level solutions.

² НҮБ-ийн тайлан. Cause of corruption in public procurement, According to Ferguson (2018) <https://www.unodc.org/e4j/zh/anti-corruption/module-4/key-issues/corruption-in-public-procurement.html>

³ OECD “Bribery in Public Procurement” METHODS, ACTORS AND COUNTER-MEASURES

⁴ Public Intrastucture, <https://thedocs.worldbank.org/en/doc/911661611783412604-0090022021/original/>

Түлхүүр үг: төсөв, ДНБ, эдийн засгийн өсөлт, хувийн ашиг сонирхол.

Keywords: budget, GDP /Gross Domestic Product/, economic growth, self-interest

Төрийн худалдан авалт: Төрийн худалдан авах ажиллагаа

Төрийн худалдан авалт нь төрийн үйл ажиллагаа явуулах, бодлогын үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор шаардлагатай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах үйл явц бөгөөд энэ нь төсөв, засаглал, аудит, хариуцлагын тогтолцоо гэх тодорхой хяналттайгаар хэрэгждэг худалдан авалтын иж бүрэн систем юм.⁵ Иймд төрийн худалдан авалтыг “төрийн худалдан авах ажиллагаа” гэж тодорхойлон онолын болон практик түвшинд нэгдмэл, цогц байдлаар нь судалдаг.

Түүнчлэн, төрийн худалдан авах ажиллагааг ямар ч луйвар, авлигагүйгээр явуулах нь түүнд зарцуулагдаж байгаа мөнгөний үнэ цэнийг цаг хугацааны хувьд тогтворжуулж, хэрэгжилтээс хүртэх үр дүнг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлнэ. Нэгдсэн үндэсний байгууллага (НҮБ)-аас тооцоолсноор дэлхийн хэмжээнд авлигын хохирол дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ний 5 хувьтай тэнцэж байгаа бөгөөд 2023 оны дэлхийн ДНБ 105.44⁶ их наяд ам.доллараас тооцоход 5.1 их наяд ам.доллар буюу эдийн засгийн үзүүлэлтээрээ дэлхийд дөрөвт⁷ эрэмбэлэгдэг Япон улсын жилийн ДНБ-ээс өндөр үзүүлэлт юм.⁸

Төрийн худалдан авах ажиллагааны орчин нь хурдацтай хөгжиж буй технологи, бүтээгдэхүүний сонголт, байгаль орчны асуудал, олон улсын болон бүс нутгийн худалдааны хэлэлцээрүүдийн нарийн төвөгтэй байдлаас шалтгаалан байнга өөрчлөгдөж байдаг тул түүний процесс, үйл ажиллагааны тогтолцоог сайжруулах замаар нийгэм, эдийн засгийн зорилгод хүрэх хэрэгсэл болгон ашигладаг.⁹ Гэхдээ энэ нь эдийн засгийг идэвхжүүлэх цорын

[PublicInfrastructure.pdf](#)

Дэлхийн банк нь олон улсын стандарт, аргачлал дээр үндэслэн мэдээллийг боловсруулж, улс орнуудаас хараат бусаар бие даан үйл ажиллагаа явуулаг. Эдгээр шалтгаанаар Дэлхийн банкны мэдээллийг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн, найдвартай эх сурвалж гэж үзэж судлаачид судалгааны эх сурвалж болгон ашигладаг.

⁵ Corruption in public procurement, March 2017, Vienna. <https://www.unodc.org/dohadecclaration/index.html>

⁶ Дэлхийн банкны нээлттэй мэдээллээс, <https://data.worldbank.org/indicator/NY.GDP.MKTP.CD>

⁷ GDP (million US\$) by country Japan GDP = 4,212 millions dollar.

⁸ Global Infrastructure Anti-Corruption Centre, <https://giacentre.org/the-cost-of-corruption/>

⁹ IPOC8 Book, Khi V. Thai, Paul J. Salia and Frederick A. Mwakibinga, Chapter 1, Introduction, 2018.

ганц нөлөөлөх хүчин зүйл биш бөгөөд төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан нийгэмд ашиг тус хүртэх, төрийн өргөн хүрээний бодлогыг хэрэгжүүлэх хэрэгсэл болохын хувьд энэ системийг судалж, сайжруулж байх нь чухал.

Эдгээр шалтгааны улмаас төрийн худалдан авах ажиллагаа нь дотоодын эрэлт, нийлүүлэлтийн хэрэгцээг хангахад чиглэгдсэн чиг үүргээс хальж, олон нийтийн үнэ цэнийг хамтран бүтээх бодлогын хэрэгсэл болтлоо хөгжсөн нь эдийн засагт нэн чухал ач холбогдолтой гэдгийг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч, эрдэмтэн, судлаачид асуудлын оновчтой онол, практик туршлагад дүн шинжилгээ хийх замаар улам нарийвчлан хөгжүүлж байна. Учир нь:

1. Төрийн худалдан авалт нь төсвийн зардлын ихэнх хувийг эзэлдэг.
2. Төрийн худалдан авалтад татвар төлөгчдийн мөнгийг зарцуулдаг.
3. Төрийн худалдан авалтын үр дүнг зөвхөн харилцаанд оролцогч хоёр тал биш нийтээрээ хүртдэгт оршино.

Дэлхийн улс орнууд, жилийн төсвийн зардлын хэдэн хувийг төрийн худалдан авалтад зарцуулдаг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1. Төрийн худалдан авалтын ДНБ-д эзлэх хувь¹⁰:

№	Улс	ДНБ ² (тэрбум доллар)	ДНБ (хувь) ¹	Төрийн худалдан авах ажиллагааны зардал ³ (тэрбум доллар)
1	Австрали	1,349.0	13.15%	177.4
2	Австри	382.1	13.51%	51.6
3	Бельги	455.0	14.43%	65.7
4	Канад	1,559.6	13.44%	209.6
5	Чех	186.8	14.52%	27.1
6	Дани	301.3	14.16%	42.7
7	Эстони	22.6	14.06%	3.2
8	Финланд	232.5	17.54%	40.8
9	Франц	2,438.2	14.58%	355.5
10	Герман	3,375.6	15.05%	508.0
11	Грек	195.5	11.10%	21.7


¹⁰ Khi V. Thai, Paul J. Salia and Frederick A. Mwakibinga, (2022) Chapter 1, INTRODUCTION.
Source: 1 OECD (2018). 2 World Bank (2018). 3 Author's calculation, based on OECD and the World Bank data in Columns 2 and 3 of the table.

12	Унгар	122.9	16.02%	19.7
13	Исланд	16.9	13.81%	2.3
14	Ирланд	290.6	7.30%	21.2
15	Израиль	299.1	14.23%	42.6
16	Итали	1,832.9	10.36%	189.9
17	Япон	4,395.0	16.22%	712.9
18	Солонгос	1,382.8	12.54%	173.4
19	Латви	27.0	12.02%	3.2
20	Люксембург	57.8	11.96%	6.9
21	Мексик	1,169.6	5.15%	60.2
22	Нидерланд	758.0	20.18%	153.0
23	Шинэ Зеланд	177.6	14.69%	26.1
24	Норвеги	386.7	13.85%	53.6
25	Польш	477.4	12.17%	58.1
26	Португал	199.4	9.83%	19.6
27	Бүгд Найрамдах Словак	87.5	17.28%	15.1
28	Словени	43.1	13.38%	5.8
29	Испани	1,197.8	10.46%	125.3
30	Швед	497.9	16%	79.7
31	Швейцарь	679.3	8.76%	59.5
32	Турк	859.8	10.85%	93.3
33	Их Британи	2,885.6	13.70%	395.3
34	АНУ	18,120.7	9.35%	1,694.3
Дүн		46,463.5	13.11%	5,514.1

Хүснэгтээс, Мексик Улс ДНБ-нийхээ 5.15% хувийг, Нидерланд Улс ДНБ-ийхээ 20.18% хувийг гэх зэргээр улс орнууд төрийн худалдан авалтад нэг тэрбум доллараас багагүй зарцуулсан байна. Дэлхийд эдийн засгаараа тэргүүлэгч АНУ ДНБ-нийхээ 9.35% зарцуулсан нь 1,694.3 тэрбум доллар буюу мөнгөн дүнгээр хамгийн их худалдан авалтыг хийсэн байна. Үүнээс, улс орнуудын зарцуулалтын хувиас тооцсон ДНБ-д эзлэх дундаж хувь 13.11% байна.¹¹

¹¹ Khi V. Thai, Paul J. Salia and Frederick A. Mwakibinga, (2022) Chapter 1, INTRODUCTION. Source: 1 OECD (2018). 2 World Bank (2018). 3 Author's calculation, based on OECD and the

График 1. Монгол Улс 2023 оны ДНБ¹²,



World Bank data in Columns 2 and 3 of the table.

¹² <https://data.worldbank.org/indicator/NY.GDP.MKTP.CD?locations=MN>

Манай улсын ДНБ 2023 онд 19,872,180.37 мянган америк доллар буюу 68,688,191.45 сая төгрөг байсан бөгөөд тооцоолсон дунджаар ДНБ-нийхээ 13.11 хувийг зарцуулсан гэж тооцвол 9,003,203.68¹³ сая төгрөг буюу 2,602.4 сая доллар зарцуулсан байна.

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлд “Монгол Улсын төсвөөс 2023 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээ 16,949,914.6 сая төгрөг байна”¹⁴ гэснээс тооцоолоход, нийт төсвийн 53 хувийг төрийн худалдан авах ажиллагаанд зарцуулсан байна.

Төрийн худалдан авах ажиллагааны зөв тогтолцооны хамгийн сайн хэмжүүр нь “татвар төлөгчдийн мөнгийг үр ашигтай, хариуцлагатай, шударга байдлаар зарцуулах”¹⁵ гэдэгтэй судлаачид санал нэгтэй байдаг.

Монгол Улсын Сангийн яамнаас жил бүр “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн тайлан”-г нэгтгэн гаргадаг бөгөөд 2023 оны тайланд “...тайлант хугацаанд нийт 8,817.11 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 5,601 тендер шалгаруулалтыг төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд, төсөвт байгууллагууд зохион байгуулсан...”¹⁶ гэжээ. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан үндэслэлээр шууд худалдан авах босго үнээс дээш дүнтэй худалдан авах ажиллагаанд зарцуулсан дүн болохыг тодотгож байна.

Төрийн худалдан авах ажиллагаа: Авлигаас ангид явуулах нь

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь “Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаар байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд”¹⁷ юм. Төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээд, төрийн байгууллага, албан газарт улсын төсвөөс олгосон хөрөнгийг

¹³ $19,872,180.37 * 3,459,50 \text{ төгрөг} = 68,688,191,448.91 \text{ сая төгрөг} * 13.11\% = 9,003,203.68 \text{ сая төгрөг}$.
2023.10.01-ний өдрийн Монгол банкны албан ханшаар тооцов.
<https://www.mongolbank.mn/mn/currency-rate>

¹⁴ Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль.

¹⁵ Tania Ghossein, Asif Mohammed Islam and Federica Saliola (2018), In “Public Procurement and the Private Business Sector: Evidence from Firm-Level Data,”

¹⁶ Монгол Улсын Сангийн яам Хууль эрх зүйн газар “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн тайлан”, 2024.04.05-ны өдөр <https://mof.gov.mn/article/entry/2023TEZTAILAN>

¹⁷ Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, 13-14 дүгээр зүйл.

Монгол Улсын Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулж тайлагнахыг эрхийг олгосон байдаг. Эдгээр төрийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагуудад олгох улсын төсвийн хөрөнгийн тодорхой хувийг иргэд, аж ахуйн нэгжээс хураан авч буй татварын орлого бүрдүүлдэг.

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд “Монгол Улсын төсөвт 2023 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлого 15,184,583.6 сая төгрөг байна”¹⁸ гэж, мөн хуулийн 3 дугаар зүйлд төсвийн ерөнхийлөн захирагчдын тухайн онд төсвийн орлогод бүрдүүлэх мөнгөн дүн тус бүрийг дэлгэрэнгүй баталсан. Үүнд, жагсаалтын 11-д “...Татварын ерөнхий газар 7,710,317.6 сая төгрөгийн төсвийн орлого төвлөрүүлэх...”-ээр заасан. Энэ нь 2023 онд төрийн худалдан авах ажиллагаанд зарцуулсан гэж тооцсон 9,003,203.68 сая төгрөгийн 85 хувьтай тэнцүү дүн юм.

Иймд бид татвар төлөгчдийн татварын орлогоос бүрдүүлсэн “төсөв”¹⁹-ийн хөрөнгийн зарцуулалтад зайлшгүй оролцох, түүний зарцуулалтын ил тод, шударга байдлыг хянах, шаардах, алдаа, луйвар, авлигыг таслан зогсоох ёстойг харуулж байна.

Төрийн худалдан авах ажиллагаанд ил тод, хариуцлагатай байж одоогийн мөнгөний ирээдүйн үнэ цэнийг нэмэгдүүлэх, оролцогч талуудын тэгш, шударга өрсөлдөөнийг хангах нь туйлын чухал. Төрийн худалдан авах ажиллагаа нь:

- эцсийн дүндээ төрийн олон нийтийн өмнө хүлээх хариуцлага болдог;
- илүү өргөн хүрээний оролцогч талууд болох төр, аж ахуйн нэгж, бизнес эрхэлгчид, ард иргэд, үйлчлүүлэгчид, үйлчилгээний ашиг хүртэгчид, татвар төлөгчид, олон нийтийн сэтгэл ханамжийг хангах ёстой;
- ёс зүй, нийгмийн тогтвортой байдал, байгаль орчныг хамгаалах гэх мэт Үндсэн хуульт ёсны үнэт зүйлсэд чиглэсэн үр дүнд илүү их анхаарал хандуулахыг төрөөс шаарддаг;
- төр нийтийг засагладаг гэдэг утгаараа худалдан авалт нь илүү өргөн хүрээтэй байж, хувийн хэвшлээс илүү нарийн шаардлагуудыг хангасан байх ёстой.

¹⁸ Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль.

¹⁹ Монгол Улсын төсвийн тухай хууль, 4 дүгээр зүйлийн 4.1.5 “төсөв” гэж төрийн болон орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогцыг.

- ихэвчлэн төсвийн хязгаарлалт, бэлэн мөнгөний хязгаарлалт, үр ашгийн зорилгод өртөж, төсвийн санхүүжилтээс олох мөнгөний үнэ цэнийг нэмэгдүүлэх, үйлчилгээний тодорхой түвшинд хүрэх зорилгод чиглэдэг.²⁰

Иймд худалдан авах ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх асуудал нь өрсөлдөөний стратегийн зардлыг багасгах гэхээсээ илүү “мөнгөний ирээдүйн үнэ цэнэ”-ээс хүртэх өгөөжөөр үйлчилгээний түвшинг хадгалах эсвэл сайжруулахад оршино.

Мөнгөний үнэ цэнийг бий болгож, үйлчилгээг үр ашигтай хүргэхэд үр дүнтэй хувь нэмэр оруулахын тулд төрийн худалдан авах ажиллагааны практикт ёс зүйн хатуу байр суурийг баримтлахыг шаарддаг. Тухайлбал, бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон төрийн албан тушаалтан, албан хаагчид төрийн худалдан авалтад төлөвлөлтөөс үл хамааран шууд болон шууд бусаар үүргээ зохих ёсоор, нягт нямбай, хариуцлагатай гүйцэтгэх үүрэгтэй. Учир нь, энэхүү худалдан авалт нь төрийн үндсэн зорилго болох нийтийн эрх ашигт нийцсэн байх, нийтэд хүртээмжтэй байх, худалдан авалтын үр дүнд шууд чиглэсэн байх, ач холбогдолтой байх ёстой ба эцсийн дүндээ төрийн худалдан авалт нь нийтийн эрх ашигт нийцсэн байхад чиглэгддэг байна.

Манай улс нь төсвийн хөрөнгийн үр ашигтай зарцуулалтыг хангахад төрийн худалдан авах ажиллагаа чухал үүрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрч, төрийн бодлогод суурилсан чанар, үнэ цэнийг хамгийн сайн хангасан өрсөлдөөний тэгш нөхцөлтэй, үйл ажиллагааны процесс бүрийг маш сайн хуульчилсан боловч хуулийн зорилгод үйл ажиллагаа нь хүрч чадахгүй байна.

Энэ нь төрийн худалдан авах ажиллагааг зохион байгуулагчийн хамгийн бага үнээр төрийн худалдан авах ажиллагаанд оролцох талаа олж авч, хамгийн өндөр үнийг төлөх гэсэн ашиг сонирхлын амин ч үзлээр хязгаарлагдаж байна. Энэ үүргийн гажуудал, үнийн зөрүү нь “Авлига” юм.

“Авлига” нь гэж олон тодорхойлолтыг иш татаж болох ч эцсийн дүндээ хувьдаа ашиг хүртэх гэсэн хувь хүний санаатай (үйлдэл, эс үйлдэхүйгээр илэрнэ) шууд холбогддог.

Өнөө үед дэлхий нийтээр “Авлига” гэдэг нэр томъёонд тодорхойлолт өгөхөөс татгалзаж, харин авлигын янз бүрийн үйлдлийг хээл хахууль өгөх, хээл хахууль авах (хээл хахууль=шан, харамж, бэлэг, урамшуулал өгөх,

²⁰ BRAC University, Md. Mahraj Hossain, Degree of Masters “Getting Value for Money from Public Procurement”, January, 2015

авах гэх мэт), хөрөнгө шамшигдуулах, өөрт олгосон эрх мэдлээ хэтрүүлэх, эрх мэдлээ ашиглах гэх зэрэг үйлдлээр нь эрүүгийн гэмт хэрэг гэж тодорхойлж²¹ байх ба хэлбэрээсээ хамаарч төрийн байгууллага төдийгүй төрөл бүрийн салбарт өөр өөр хэлбэрээр илэрч байгааг судлаачид онцолжээ. Жишээлбэл, төрийн худалдан авалтын шударга бус байдал нь авлигад хүргэдэг бол энэ нь хээл хахууль, хөнгөвчлөх төлбөр, тохиролцоо зэрэг хэд хэдэн үйлдлээр тодорхойлогддог; ашиг сонирхлын зөрчлийн журмыг зөрчих, тендер будлиантуулах, нөлөөллийн наймаа хийх гэх мэт. Хээл хахуулийн хувьд татвар хураах, шүүх эрх мэдэл, нийтийн аж ахуй зэрэг төрийн бусад салбартай харьцуулахад “Төрийн худалдан авах ажиллагааны гэрээ” нь авлигад илүү өртөмтгий гэж үздэг.²²

Төрийн худалдан авах ажиллагаа авлигаас ангид явагдахгүй байгаа нь:

1. Төрд төвлөрсөн их хэмжээний мөнгө төрөөс эрх олгосон байдлаар зарцуулагдахад бэлэн байдаг (төсөвлөгддөг);
2. Худалдан авах ажиллагааг хариуцан хийдэг төрийн байгууллагууд (захиалагч) нь арилжааны бус буюу ашиг олох үйл ажиллагаа явуулдаггүй субъектууд байдаг;
3. Төрийн албан тушаалтны эрх мэдлээр тухайн худалдан авалтын үйл ажиллагаа шийдэгдэж явагддаг. Тухайлбал, ямар этгээдийг тендерт урихаа шийдэх, тухайн компанид ашигтай үнэлгээний шалгуурыг боловсруулах, гэрээ байгуулах үйл явцыг удирдан чиглүүлэх зэргээр албан тушаалын эрх мэдлээ зүй бусаар ашиглах боломжтой байдаг.²³ зэрэг шалтгаантай.

Төрийн худалдан авах ажиллагаа дахь авлига нь худалдан авах ажиллагааны хууль, журмыг зөрчсөн эсхүл хууль ёсны хазайлтаас үүдэлтэй байж болно.

КЭЙС 1.²⁴ М.С нь Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрчим хүчний сайдаар ажиллаж байхдаа албан үүргийн хувьд гүйцэтгэх ёсгүй үйлдэл буюу

²¹ UNODC, Module Series on Anti-Corruption “Module 4. Public Sector Corruption”, <https://www.unodc.org/e4j/zh/anti-corruption/module-4/key-issues/corruption-in-public-procurement.html>

²² OECD, ‘Government at a Glance 2009’, Online. <http://dx.doi.org/10.1787/72422730045>

²³ Corruption in public procurement, March 2017, Vienna,

²⁴ Авлигатай тэмцэх газар “Авлигын гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн эмхэтгэл” (2020он II боть), 5-11 дэх тал, 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн Монгол Улсын Дээд Шүүхийн 98 дугаар тогтоол.

тус яамны төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулагдсан “Дарханы дулааны цахилгаан станцад үнсэн сан шинээр барих” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны даргад “Х” компанийг “шалгаруул” гэсэн хууль бус үүрэг амаар өгөх байдлаар шууд нөлөөлж, тендерт шалгаруулсны хариуд “Х” компаниас тендерийн үнийн дүнгийн 10 хувийг “зуулчлалын хөлс” болгон авах агуулга бүхий “Түншлэлийн гэрээ”-г өөрийн үүсгэн байгуулсан “З” ХХК-тай байгуулж, хоёр удаагийн үйлдлээр нийт 266.0 сая (хоёр зуун жаран зургаан сая) төгрөгийн хахуулийг “Х” ХХК-ын захирал А.Х-аас авсан болох нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, бэхжүүлсэн тухайн хэрэгт хамааралтай нотлох баримтаар нотлогдсон байна.

Шүүхээс шүүгдэгч М.С-ыг нийтийн албан тушаалтан хахууль өгөгчийн ашиг сонирхолын үүднээс гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийж, бусдаар дамжуулан хахууль авсан гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож нийтийн албанд томилогдох эрхийг 2 жил хасаж, 4 жил хорих ял шийтгэж, хахуульд авсан 266.0 сая (хоёр зуун жаран зургаан сая) төгрөгийг гаргуулж, улсын орлого болгохоор шийдсэн байна.

КЭЙС 2.²⁵ Д.Э нь Булган аймгийн Засаг даргаар ажиллаж байхдаа албан тушаалын байдлаа урвуулан ашиглан, А.Г, Ц.Д, Б.П нартай урьдчилан үгсэн тохиролцож Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 800.0 сая (найман зуун сая) төгрөгөөр хог хаягдлыг ландфилын аргаар дарж булахад зориулагдсан техник, тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлыг хэрэгжүүлэхдээ техникийн үнэ ханш өссөн эсэхийг судалж, үндэслэлтэй тооцоо судалгаа хийхгүйгээр валютын ханш өссөн үндэслэлээр техникийн тодорхойлолт, тоног төхөөрөмжийн нэр төрөл, тоо ширхгийг өөрчлөн шууд гэрээ байгуулах аргаар худалдан авалтыг хийж, улсад 347.5 сая (гурван зуун дөчин долоо сая таван зуун мянга) төгрөгийн хохирол учруулжээ.

Шүүхээс “Гэрээний дагуу авахаар болсон 16 ширхэг, нэг бүр нь 50.0 сая (тавин сая) төгрөгийн үнэтэй трактор нь тухайн үедээ 28.28 сая (хорин найман сая хоёр зуун наян мянга) төгрөгийн үнэлгээтэй байсан болох нь шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон тул гэмт хэргийн улмаас учирсан 347.5 сая (гурван

²⁵ Авлигатай тэмцэх газар “Авлигын гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн эмхэтгэл” (2020он II боть), 101-106 дахь тал, 2020 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн Монгол Улсын Дээд Шүүхийн 371 дүгээр тогтоол.

зуун дөчин долоо сая таван зуун мянга) төгрөгийн хохирлыг бодит байдлаар тогтоогдсон” гэж үзжээ.

КЭЙС 3.²⁶ Б.Ц нь Төв аймгийн Өндөр ширээт сумын Засаг даргаар ажиллаж байхдаа албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж бусдад давуу байдал болгож, өвс тэжээлийн нөөц байгуулахаар хуваарилагдаж ирсэн 12.0 сая (арван хоёр сая) төгрөгийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд зааснаар сонгон шалгаруулалт явуулахгүйгээр Засаг даргын Тамгын газрын жолооч (өөрийн жолооч)-ийн эзэмшлийн “ХНТУ” ХХК-д шилжүүлж, улмаар тус компаниас 11.0 сая (арван нэгэн сая) төгрөгийг банк бус санхүүгийн байгууллагын дансанд шилжүүлж өөрийн зээлийн үлдэгдлийг төлсөн албан тушаалын байдлаа урвуулан ашигласан... зэрэг гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож нийтийн албанд томилогдох эрхийг 2 жил хасаж, 2 жил хорих ял шийтгэж, БЦ-ээс 12.0 сая (арван хоёр сая) төгрөгийг гаргуулж, улсын орлого болгохоор шийдсэн байна.

Шүүх “шүүгдэгч Ц.Б нь хуулиар хамгаалагдсан, нийгмийн ашиг сонирхлыг зөрчиж материаллаг хохирол учруулснаас гадна төрийн үйл ажиллагаанд хууль дээдлэх, шударга ёсыг хангах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалж ажиллах зарчмыг ноцтой зөрчиж, төрд итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулж, төрийн байгууллагын үнэлэмжийг сулруулах зэрэг бусад хор уршиг учруулдгаараа нийгмийн аюулын шинж ихтэй байдаг. Энэ хэргийн хувьд Ц.Б нь өөрт олгогдсон албаны эрх мэдэл, албан тушаалаа урвуулан, хэтрүүлэн ашиглаж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудад тусгагдсан хуулийн зохицуулалтыг зөрчиж өөртөө болон бусдад давуу байдал бий болгосон үйлдэл нь төрийн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн үр шимийг шударгаар хүртэх байсан иргэдийн хууль ёсны ашиг сонирхол, түүнчлэн дээрх харилцааг зохицуулахад чиглэсэн төрийн үйл ажиллагааны хууль ёсны байдал зэрэгт хор хохирол учруулсан байх тул “эрх мэдэл, албан тушаал”-ын гэмт хэргийн шинжийг бүрэн хангасан” гэж дүгнэжээ.

²⁶ Авлигатай тэмцэх газар “Авлигын гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн эмхэтгэл” (2020он III боть), 116-128 дахь тал, 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн Төв аймаг дахь Сум Дундын Эрүүгийн Хэргийн Анхан Шатны Шүүхийн 2020/ШЦТ/452 дугаар шийтгэх тогтоол.

Дээрхээс төрийн худалдан авах ажиллагаанд:

Эдийн засгийн талаас, төрийн худалдан авах ажиллагаанд баримтлах жишиг стандартыг худалдан авалтын ангилал тус бүрээр гаргаж, үйл ажиллагаанд мөрдүүлэх. Жишээлбэл: “Техникийн тодорхойлолт”-ын хувьд худалдан авах тоног төхөөрөмж нь технологийн хамгийн сүүлийн үеийн шаардлагыг хангасан, техник үзүүлэлт нь хэрэглээнд ашиглагдаж буй хамгийн сүүлийн үеийн стандартад нийцсэн, загвар дизайны хамгийн сүүлийн үеийн шийдлийг бүрдүүлсэн байх зэрэг хувьсан өөрчлөгдөж буй хөгжлийн чиг хандлагад бүрэн нийцсэн, тодорхой цаг хугацаанд үнэ цэнээ алдахгүй байх нөхцлийг тусгах нь худалдан авалтын мөнгөний үнэ цэнийг бий болгож, хэрэгжилтийн үр дүнг сайжруулах;

Хууль зүйн талаас, төрийн худалдан авах ажиллагаанаас учирсан “шууд хохирол”-ыг өөрөөр хэлбэл хээл хахууль авсан мөнгөн дүн, тендерийн үнийг үндэслэлгүй нэмэгдүүлсэн дүн, хэрэгжээгүй гэрээний үнийн дүн зэргийг гэмт хэрэг үйлдсэн этгээдээр төлүүлж байсан байна. Цаашид тухайн төрийн худалдан авах ажиллагааг хууль ёсоор, цаг хугацаанд нь, чанартай явуулаагүйгээс худалдан авалтын үр дүнд учирсан “хор уршиг”²⁷-ийг тооцож нөхөн төлүүлбэл, төрийн худалдан авах ажиллагааны эсрэг гэмт хэрэг, гэмт үйлдэл, зүй бус үйлдэл, эс үйлдэхүй багасгах ач холбогдолтой гэсэн дүгнэлтийг хийж байна.

Ашигласан эх сурвалж:

Монгол Улсын төсвийн тухай хууль

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль.

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах тухай хууль

Эрүүгийн хууль

Tania Ghossein, Asif Mohammed Islam and Federica Saliola (2018), In

²⁷ Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 2.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “1 Энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдэж хохирол учруулсны улмаас үүссэн үр дагаврыг гэмт хэргийн хор уршигт тооцно”

“Public Procurement and the Private Business Sector: Evidence from Firm-Level Data,”

BRAC University, Md. Mahraj Hossain, Degree of Masters “Getting Value for Money from Public Procurement”, January, 2015

UNODC, Module Series on Anti-Corruption “Module 4. Public Sector Corruption”,

Corruption in public procurement, March 2017, Vienna,

Авлигын гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн эмхэтгэл (2020он II боть)

Авлигын гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн эмхэтгэл (2020он III боть)

<https://www.unodc.org/e4j/zh/anti-corruption/module-4/key-issues/corruption-in-public-procurement.html>

Public Infrastructure, <https://thedocs.worldbank.org/en/doc/911661611783412604-0090022021/original/PublicInfrastructure.pdf>

<https://data.worldbank.org/indicator/NY.GDP.MKTP.CD>

<https://www.unodc.org/dohadeclaration/index.html>

<https://www.unodc.org/e4j/zh/anti-corruption/module-4/key-issues/corruption-in-public-procurement.html>

<https://giaccentre.org/the-cost-of-corruption/>

<https://www.mongolbank.mn/mn/currency-rate>

<https://mof.gov.mn/article/entry/2023TEZTAILAN>



Н.БАДАМЦЭЦЭГ

*Нийслэлийн Шүүх шинжилгээний газрын
Бүртгэл хариуцсан мэргэжилтэн, цагдаагийн дэслэгч*

СОНСГОЛ, ХЭЛ ЯРИАНЫ БЭРХШЭЭЛ ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХЭД ХӨНГӨРҮҮЛЭХ ХҮЧИН ЗҮЙЛ БОЛОХ НЬ

HEARING AND SPEECH PROBLEMS AS MITIGATING FACTORS IN CRIMINAL LIABILITY

Хураангуй: Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний биеийн хөгжил, хэлгүй, дүлий байдлаас шалтгаалсан оюуны хоцрогдол, сэтгэцийн эрүүл мэндийг харгалзан үзэж, шударга, энэрэнгүй ёсны зарчимд тулгуурлан ялыг ялгамжтай оногдуулах нь зүй ёсны асуудал болж байна.

Abstract: Considering the physical development, mental retardation, and mental health of the hearing and speech impaired person, it is a legitimate issue to impose a different sentence based on the principle of fairness and compassion.

Түлхүүр үг: Хэлгүй, дүлий, сэтгэцийн эмгэг, гэмт хэрэг, хариуцлага.

Key words: Mute, deaf, mental disorders, crime, responsibility.

Аливаа эрх зүй нь талуудын эрх, үүрэг, түүнийг дагаж мөрдсөн болон зөрчсөнөөс үүсэх үр дагаврыг тодорхойлсон хэм хэмжээний тогтолцоо байдаг бөгөөд үр дагаврыг тодорхойлсон хэсгийг эрх зүйн (хууль зүйн) хариуцлага гэдэг бол эрүүгийн эрх зүй нь хамгаалах чиг үүрэг бүхий эрх зүйн салбар болохын хувьд нийгмийн бүхий л төрлийн харилцааны нийгэмд аюултай буюу

криминаль гэгдэх харилцаанаас хүмүүсийн нийтлэг эрх ашгийг хамгаалсан хориг тогтоож, тэрхүү хоригийг зөрчсөний улмаас үүдэн гарах хууль зүйн үр дагаврыг тодорхойлж байдаг.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь тухайн этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт нь тохирсон буюу гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдалд тохирсон байх ёстой. Энэ нь ялын тогтолцоо, төрөл, ял оногдуулах, эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх тухай хэм хэмжээнд тусгагддаг.

Улмаар шүүх, шүүгч сэтгэл хөдлөлд автахгүйгээр үйлдэгдсэн гэмт хэргийн хор аюул, шүүгдэгчийн хувийн байдал, ялыг хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдлыг тал бүрээс нь харгалзан алагчлахгүйгээр, эрх зүйн ухамсрыг удирдлага болгон үйлдсэн хэрэгт нь яв цав тохирсон ял оногдуулбал сая шударга ёсны зарчим хэрэгжиж байгаагийн нотолгоо болно¹.

Аль ч Улс орны хувьд эрүүгийн эрх зүйн тулгуур зарчмуудад:

- Хүнлэг, энэрэнгүй ёсны зарчим;
- Шүүх, хуулийн болон хууль, шүүхийн өмнө хэн боловч эрх, тэгш байх зарчим;
- Хуулийг дээдлэх буюу шүүхийн прецедент²², шударга шүүхийг хүндэтгэх зарчим;
- Гэмт хэргийн төрөл, хор аюул, үр дагаварт ялын санкц, хэр хэмжээ авцалдаж, тохирсон буюу тэнцвэртэй шударга байх зарчим;
- Гэм буруутай этгээдэд хариуцлага зайлшгүй байх зарчим;
- Гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр нотлогдоогүй буюу тогтоогдоогүй нөхцөлд гэмт хэрэгт үл тооцох зарчим;
- Ялыг хүнлэг бус хэрцгий хэлбэрээр эдлүүлэхээс зайлсхийх зарчим;
- Эрүүгийн хуулийг эрх зүйн зөвшөөрөгдсөн хүрээнд уян хатан зөв хэрэглэх зарчим;

¹ Жанцан, Б. Бат-Эрдэнэ, Б нар. “Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар”.-Уб., 2010. 46 дахь тал

² Шүүхийн прецедент (Precedent of law. Prevedenm of court) гэдэг ойлголт нь латин “Praecedens, Praecedentis-өмнөх тогтсон зүйл” гэсэн утгатай агаад орчин үеийн агуулга нь нийтлэг хэм хэмжээг тогтоосон шүүхийн шийдэл бүхий акт гэсэн утгатай ажээ. Адил төст хэргийг адил төст практикаар буюу аргаар шийдэх, жишгийг тогтоох гэсэн зориулалтыг хангаж 13 дугаар зууны үед Англид үүсжээ.

- Эрүүгийн хууль, тогтоомж, цаг хугацаа, нутаг дэвсгэрийн болон субъект, объектын харьяалал, орон зайн хүрээнд үйлчлэх³ зарчмууд үйлчилдэг байна.

Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний үйлдсэн гэмт хэрэгт оногдуулж байгаа эрүүгийн хариуцлагын бодит байдал нь шударга, энэрэнгүй зарчим зайлшгүй холбогдох асуудал бөгөөд сонсгол, хэл ярианы бэрхшээлээс үүсэх байдлыг:

Нийгмийн байдал: Итгэл, үнэмшил, таамаглал, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоонд саад бэрхшээлийг бий болгож, хамт олны дунд амьдрах боломж муу, харилцааны хүрээлэл хязгаарлагдмал, институтэд илүү найдаж байгаа нь тэднийг бусдын хараат болгож, бусдаас салангид байхад нөлөөлдөг⁴. Аливаа харилцаанд оролцохдоо 3 дахьч хүний тусламжийг зайлшгүйшаарддаг. Ажил эрхлэлтийн байдлаар сонсголын бэрхшээлтэй 304, ярианы бэрхшээлтэй 68 хүн ажил эрхэлж байна⁵.

Боловсрол, соёлын байдал: Монгол Улсын хэмжээнд зөвхөн Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуульд сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүүхдүүдэд боловсрол олгож байгаа бөгөөд 2024 оны нэгдүгээр улирлын байдлаар тус сургуульд 21 аймаг, 9 дүүргээс нийт 262 хүүхэд суралцаж байна.

Тус сургуульд 1 дүгээр ангид элсэн суралцаж буй сурагчдын нас харилцан адилгүй буюу 06- 15 наснаас элсэн суралцдаг. Монгол дохионы хэл 3000 дохиотой⁶, тогтсон стандартгүй, дохионы хэл нь зөвхөн нэр үгээр дохиж, хоорондоо харилцдаг. Жишээ нь: нэг гарын алгыг дээш харуулж, нөгөө гарын алгыг дэлгэж хөндлөнгөөр нь дэлгэсэн гарын алга дээр тавьж, байдаг гэдэг үгийг илэрхийлдэг. Энэ дохио: Байна, байдаг, байсан, байх гэдгээр илэрхийлэгддэг. Нэг үг олон хувилбартай⁷ байдаг. Тус сургуулийн бүрэн дунд боловсрол эзэмшиж, төгссөн хүүхдүүд хос хэлний чадвар болох эх хэл болох дохионы хэл, үгийн утгыг уншаад бүрэн ойлгох, бичгээр өөрийгөө бүрэн илэрхийлэх чадварыг эзэмшиж чаддаггүй, (Зураг 01) үгийн утгыг ойлгомжгүй байдлаар бичдэг. (Зураг 02)


³ Баярсайхан, Д. Харьцуулсан эрүүгийн эрх зүй.-Уб., 2012. 70 дахь тал.

⁴ Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн тайлан. 2010. 11 дэх тал

⁵ Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2022 оны жилийн эцсийн статистик мэдээ

⁶ Монгол дохионы хэлний толь бичиг-Уб., 2006. 1 дэх хэвлэл

⁷ Дохионы хэлний зөвлөх багш, Монгол дохионы хэлний орчуулагч, Б.Саранчимэг



Зураг 01

Зураг 02

Дохионы үгийн тогтсон стандартгүйгээс зарим үгийн утгыг ойлгохгүй, гайхах, алмайрах, эргэлзэх, буруу ойлгох байдалд хүрдэг. Сонсголгүй хүний эрүүл хүнээс ялгарах соёлын онцлог нь харилцан яриаг нүд, хараагаар хүртэж хүлээж авдаг,

Сэтгэл судлалын шинжлэх ухаанд: Нийтлэг байдал нь сэтгэл зүйн тулгамдсан асуудал, сэтгэл гутрал ихтэй, сонсохгүй, ярихгүй байгаа дутуу дулимаг мэдрэмж өндөр, алсын хараа, ирээдүйн талаарх мөрөөдөл харанхуй, төсөөлөл хязгаарлагдмал, нийгэмших, бие даах, өөртөө итгэлтэй байх чадвар танин мэдэхүйн хөгжил дутуу байдлаас болж хүнд итгэмтгий байдалтай⁸ байдаг.

Шүүх, сэтгэцийн эмгэг судлалд: Сонсож, ярьж чадахгүй байгаагаас үүдсэн оюуны хөнгөн хомсдол, зан төрхийн өөрчлөлт буюу /F70.1/ сэтгэцийн эмгэгт байдлыг эмгэг сэтгэл судлалын шинжилгээгээр тогтоолгоход 66 хувь буюу оюуны хөнгөн хомсдолын түвшинтэй гардаг бол **66 хувь гэдэг нь 9-12 насны хүнд илэрдэг хэмжээ юм. /нэг тохиолдол/** Оюун ухаан, танин мэдэхүй, хийсвэрлэн сэтгэхүй, хэл яриа, нийгэмд бие дааж амьдрах чадвар муудах байдлаар илрэх өвчин болох оюуны саатлыг доорх хэлбэрээр ангилна⁹.

⁸ Зураглах амьдрал “Сонсголгүй хүүхдийн сэтгэл зүй” НЕБС-ийн 29 дүгээр сургуулийн сэтгэл зүйч Ж.Батлхагва. 2023.02.23

⁹ Баярхүү, Б. Шүүхийн сэтгэц, эмгэг судлал.-Уб., 2019. 119 дэх тал

Оюуны хөнгөн саатал	Оюуны хүндэвтэр саатал	Оюуны хүнд саатал	Оюуны маш хүнд саатал	Оюуны хөгжлийн бусад саатал	Оюуны хомсдол өвчин
Оюуны коэффициент 50-60 хувь	Оюуны коэффициент 35-49 хувь	Оюуны коэффициент 20-34 хувь	Оюуны коэффициент 20 хувиас доош	Хэлгүй, дүлий	Үр хөврөлийн үеийн согог хөгжил
Нийгэмд өөр өөртөө үйлчилж чадна Онош: дүйнгэ тэнэг	Бусдын тусламж шаардлагатай Онош: Мангүү, тэнэг	Мэдрэл, гажиг илэрч орчинтой харьцаж чадахгүй Онош: мангүү, тэнэг	Бусдын асрамж, тусламжгүй бол амьдрах боломжгүй, онош: усан тэнэг	Мэдрэхүй эрхтний тахир, дутуу согогоос үйлдэл хийж чадахгүй	ДНК, РНК-н байрлал холбооны гажиг бүхий гадна, дотор шалтгаант эмгэг байх

Зураг 03 Сонсгол, хэл ярианы бэрхшээлт байдал нь оюуны хөгжилд үзүүлэх нөлөө

Танин мэдэх, оюун сэтгэхүйн хөгжлийн хоцрогдол давамгайлсан сэтгэцийн дутуу хөгжил бүхий эмнэл зүйтэй, даамжирдаггүй явцтай, янз бүрийн шалтгаантай бүлэг эмгэгийг **оюуны хомсдол** гэдэг¹⁰.

Оюуны хомсдолыг үүссэн байдлаар нь:

а/ төрөлхийн буюу олигофрени

б/ **олдмол буюу деменци** гэж ангилдаг бөгөөд хүний төрөлхийн оюуны хомсдолыг хүний оюун ухаан, сэтгэцийн үйл ажиллагаанд нөлөөлөх байдлаар шүүхийн сэтгэц, гэм судлалын шинжлэх ухаанд дибиль, имбицель, идиот гэсэн 3 зэрэглэлд ангилдаг байна¹¹.

Анагаах ухаанд сонсгол, хэл ярианы бэрхшээлт байдлаас үүсэх байдлыг: ярианы төвийн, ярианы сонсгол, ярианы хөдөлгөөн, бичгийн хэлний төвийг унших, бичихийн төв хэмээн дөрөв хуваан үздэг.

-Ярианы сонсголын төв. Чамархайн хэсгийн дээд атирааны хойд хэсэгт (Верникын төв) дотор тал руу төвлөрнө. Энэ төв бүрэлдсэнээр яриаг ухамсарлан ойлгоно. Хэрэв гэмтвэл авиа сонсох ч хүний хэлийг ойлгохгүй.

¹⁰ Гантөмөр, Г. Дурьдсан бүтээл. 159 дэх тал

¹¹ Баярхүү, Б. "Шүүхийн сэтгэц эмгэг судлал".- Уб., 2019. 52 дахь тал

-Ярианы хөдөлгөөний төв. Духны доод атирааны хойд үзүүр буюу төвийн өмнөх атирааны ойролцоо gyrus frontalis inferior (Broca) pars opercularis орчимд төвлөрнө. Энэ төв хэл, уруул, төвөнхийн булчин зэргийг удирдан үг хэлэх (хүүхдийн хэлд орох үеэр тогтоно) ажиллагааг удирдах ба энэ төвийн гэмтлээр хүний хэлсэн үгийг ойлгох боловч үг хэлж чадахгүй болно¹² хэмээн тэмдэглэсэн байв.

Төрөлхийн болон олдмол сонсголгүйдэлтэй хүмүүс	Төрөлхийн ба олдмол хэл ярианы бэрхшээлтэй буюу хэлгүй хүмүүс	Төрөлхийн сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй буюу хэлгүй, дүлий хүмүүс
Ярих чадвартай байдаг ч сонсох чадваргүйгээс өдөр тутмын харилцаа нь төөрөлдөж, бусад хүмүүст ойлгомжгүй байдалтайгаар хүн хоорондын харилцаанд ордог	Бусдын яриг сонсох чадвартай ч харилцан бодол санаа, асуултад хариулах чадваргүй;	Бусдын яриг сонсох чадваргүй, зөвхөн хараагаар гаднаас ирэх үйлдэл, мэдээллийг хүлээн авч, бодол санаа мэдрэмжээ үгээр илэрхийлэх боломжгүй зөвхөн дохио, зангаагаар харилцаанд ордог

Зураг 04: Сонсгол, хэл ярианы бэрхшээлийн ялгаа

Сонсголын алдагдал нь хүний амьдралын бүхий л асуудал болон сэтгэцийн эрүүл мэндийн байдал, ерөнхийдөө амьдралын чанарт шууд нөлөөлдөг буюу:

1. Тархинд сэтгэлзүйн ядаргаа, стрессийн ачаалал нэмэгдэх;
2. Санах ойн үнэ цэний бууралт;
3. Анхаарлаа төвлөрүүлэх асуудал;
4. Сэтгэцийн эрүүл мэнд;
5. Нийгмийн тусгаарлалт;
6. Сэтгэлийн хямрал зэрэг нийтлэг шинжтэй байдаг¹³.

Сонсголын алдагдал нь танин мэдэхүйн чадварт сөргөөр нөлөөлж, (санах ой, анхаарал, оронзайн чиг баримжаа, сэтгэцийн үйл ажиллагаа, яриа, сэтгэн бодох чадвар гэх мэт) тогтмол буурч байгааг олон тооны баримтуудаас харж болно.

¹² [https://mn.wikipedia.org/wiki/ төв мэдрэлийн тогтолцоо](https://mn.wikipedia.org/wiki/төв_мэдрэлийн_тогтолцоо)

¹³ Энхзаяа, Д. /Стив Паркер “Хүний бие” орчуулга/-УБ., 2013. 58 дахь тал.

Сонсголын бэрхшээлтэй өндөр настай хүмүүсийн танин мэдэхүйн ойлголт, хоцрогдол нь харьцангуй хэвийн сонсголотой үе тэнгийнхнээсээ 41% илүү байгааг Жонс Хопкинсийн Их Сургуулийн эрдэмтэд судалгаагаар нотолсон байна¹⁴.

Хүний яриаг хүлээн зөвшөөрөх, ойлгох нь оюун санааны хүчин чармайлт шаарддаг танин мэдэхүйн салшгүй хэсэг болдог бол сонсгол алдагдах, сонсгол сулрах байдал нь гаднаас ирж буй мэдээллийг зөв боловсруулахад илүү их хүчин чармайлт шаардагдаж, тархины нөөцийн дахин хуваарилалт, санах ой, сэтгэцийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг байна.

№	1 шат	2 шат	3 шат
1	Сонсгол нь чихнээс тархинд шууд очдог үйлчлэл юм.	Харилцагч ярих үед чих дохиог аваад тархи руу дамжуулж, боловсруулагддаг	Үр дүн нь юу хэлж байгааг ойлгох үйл явц явагддаг.

Хүснэгт 01: Сонсголын чадвар ба тархи

Сонсгол бууралтын тархинд үзүүлэх нөлөө

Сонсголын алдагдал нь сэтгэцийн янз бүрийн эмгэг үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж, сэтгэлийн хямралд оруулж байдаг. Сонсголын алдагдал буюу дууны өдөөлтийг хүлээн авах үйл ажиллагаа явагдахгүй байхад тархины үйл ажиллагаа буурч, сэтгэцийн өвчин тусах эрсдэлтэй байдал нэмэгддэг байна.

Сэтгэцийн хувьд эрүүл байна гэдэг нь “аливаа хүн бие эрүүл, сэтгэл хөдлөл, бодол санаагаа захирч чаддаг, зан төлөв, төрх үйл нь орчинтойгоо зохицож, өөрийгөө хамт олны гишүүн гэдгээ ухамсарлаж, нийгэмд гүйцэтгэх үүргээ биелүүлж чаддаг байхыг хэлнэ¹⁵” гэсэн тодорхойлолт байна.

Гэтэл хүний чухал хэрэгцээ буюу ярих, сонсох, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэн гаргаж, нийгмийн харилцаанд чөлөөтэй оролцож чадахгүй байдлаас сэтгэцийн хямрал үүсэж удаан хугацааны туршид хадгалж явах нь сэтгэцийн эмгэгтэй болох магадлалыг нэмэгдүүлж байгаа явдал юм.

Хэрэг хариуцах чадвар:

Манай Улсын Эрүүгийн эрх зүйд: Гэмт хэргийг нийгмийн аюулын шинж

¹⁴ <https://krieger.jhu.edu/cle/language-programs/>

¹⁵ Эрдэнэбаяр, Л. Сэтгэц судлал. Уб., 2012. 79 дэх тал

Сонгоол, хэл ярианы бэрхшээл эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд хөнгөрүүлэх хүчин зүйл болох нь

чанар, хор хэмжээг зөвөөр ухамсарлан, ойлгох чадварыг илэрхийлсэн бие махбод, сэтгэц, оюун ухааны хувьд эрүүл, үйлдлээ ойлгох, удирдах чадвартай, гэмт хэрэг үйлдсэний улмаас үүсэх үр дагаврыг ойлгох чадвартай, сэтгэхүйн хөгжлийн түвшинг харгалзан эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаарыг эрүүгийн хуульд тодорхойлсон байна.

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг тал бүрээс нь харгалзан үзнэ гэх заалтыг:

- Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн сургалт, үйлдсэн гэм буруугаа ухамсарлах, хөдөлмөрт хандах хандлага, хариуцлагаа ухамсарлах чадвар,
- Зан төлөв, хөдөлмөрлөх чадвар, гэр бүлийн байдал, эрүүл мэнд, ялтай байдал зэргийг хамааруулан, ялын төрөл, хэмжээг тогтооход согтууруулах болон мансууруулах бодис хэрэглэдэг эсэх,
- Гэр бүл, нийгмийн хэв журам зөрчиж байсан эсэхийг харгалзан үзэх,
- Бие махбодийн (хөгжлийн хоцрогдол, сонсгол хэл ярианы бэрхшээлт байдал нь оюуны хоцрогдолдоруулж буй байдлаар ойлгох нь зүй юм) гэсэн байна.

№	Эрүүгийн хууль 2002 он	Эрүүгийн хууль 2017 он		
1	Нэгдүгээр бүлэг Монгол Улсын Эрүүгийн хуулийн зорилт, зарчим	Зургадугаар бүлэг Эрүүгийн хариуцлага хүлээлгэх, чөлөөлөх үндэслэл, журам		-Хохирогчийн хууль бус, зүй бус үйлдлээс шалтгаалан гэмт хэрэг үйлдсэн /бэрхшээлтэй байдлыг доромжилсон, гутаах байдалаас үүснэ, хахирогч гэм буруутай этгээдийн бие эрхний гажиг, захисгүй байдал, өвчин эмгэгээр нь илтэд тохуурхан доромжилсон, хүч хэрэглэж бусдын бие эрхтэнд нь халдан тодож, гэмтэл учруулах, айсан сурдуулаж, санаа сэтгэл, ид материал, ахуйн талаар хүчтэй дарамт үзүүлэх, хүч чадлаар дээрлэх үйлдлийг ойлгоно! -Нөхцөл байдлыг буруугаар төсөөлж андуурсны улмаас гэмт хэрэг үйлдсэн. /сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүн бусад хүний гаднах төрхөд хууртагдан төсөөлөөр хүртэх/ Эрүүгийн хуулийн 6.5 дугаар зүйлийн 1.4 Эрүүгийн хуулийн 6.5 дугаар зүйлийн 1.6 Зураг 04
	10 дугаар зүйл. хариуцлага хүлээлгэх үндэслэл 10.1.Энэ хуульд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агүүлсан хэрэг үйлдэгдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.	6.1 дүгээр зүйл. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх 2. Эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэргийн үйлдсэн хүний хувийн байдал, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг тал бүрээс нь харгалзан үзнэ...	Эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл	Шийдвэр гаргахаар зөвлөдөгх

Хүснэгт 02: өмнө мөрдөгдөж байсан эрүүгийн хуулийн ижил зохицуулалтай харьцуулсан байдал

Дээрх хоёр хуулийн зүйл заалтыг харьцуулахад эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл, хамаарах бүлгийн нэр өөрчлөгдөн, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг тал бүрээс нь харгалзан үзнэ гэж оруулсан байна.

Бусад хуульд, тухайлбал “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль¹⁶”-ийн 17.4 дүгээр зүйлийн 5, “Шүүх шинжилгээний тухай хууль¹⁷”-ийн 39 дүгээр зүйлийн 39.1.6, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль” зэрэг хуулиудад хэрэг хариуцах чадвартай байдлыг тогтоолгох тухай тусгагдсан байна.

Хэрэг хариуцах чадвартай байдлыг:

Гэм буруугийн тухай асуудал нь гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдлийн нийгмийн хор аюулыг ойлгон ухамсарлах, удирдан жолоодох чадвартай байхыг шаардах ба ийм чадвар зөвхөн хэрэг хариуцах чадвартай этгээдэд байдаг¹⁸.

Гэмт хэргийн субъектийн зайлшгүй байх шинжийн нэг бол тухайн гэм буруутай этгээд нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдсэний төлөө хариуцлага хүлээх чадвартай:

- Сэтгэхүйн хувьд үйлдлээ хариуцан тайлбарлах чадвартай байх
- Ухаан санааны хувьд үйл ажиллагаа удирдан жолоодох чадвартай байх зэрэг шалгуураар тодорхойлогдоно.

Гэмт хэргийн субъектийн эрүүгийн эрх зүйн шинжийг:

- Нийгмийн
- Физиологийн гэж хуваан авч үзэж болох юм.

Гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектийн нийгмийн шинжид албан тушаал, мэргэжил, харьяалал зэрэг;

¹⁶ Шүүх хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэх үндэслэл тогтоогдвол шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн 5.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 5.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 5.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 6.7 дугаар зүйлд заасныг баримтлан прокурорын саналын хүрээнд шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай шийдвэр гаргана

¹⁷ Эрүүгийн хэргийн гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч хэрэгт ач холбогдол бүхий байдлыг бодитой тусгаж, зөв мэдүүлэг өгөх чадвартай эсэхэд эргэлзээ төрвөл түүний сэтгэцийн байдлыг тодорхойлох

¹⁸ Гантөмөр, Г. Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол.-Уб., 2011. 200 дахь тал.

физиологийн шинжид гэмт этгээдийн нас, хүйс, сэтгэл мэдрэлийн чадварыг тус тус оруулан ангилна. Энэ талаар Монгол Улсын Эрүүгийн хуулийн 6 дугаар зүйлд гэмт этгээдэд хариуцлага хүлээлгэх насны хязгаарыг, мөн хэрэг хариуцах чадваргүй байдлын талаар тодорхой хуульчлан заасан байна.

Хэрэг хариуцах чадваргүй байдал нь өөртөө эрүүгийн ял оногдуулахгүй гэсэн эрх зүйн үр дагаврыг бий болгох ба гэмт хэрэг үйлдсэн этгээд нь хэрэг хариуцах чадвартай, чадваргүй эсэхийг түүнд тавигдах дараах 2 шалгуурыг үндэслэн тогтооно:

а/Эмнэлгийн буюу биологийн шалгуур

б/Хууль зүйн буюу сэтгэл зүйн шалгуур

Эмнэлгийн буюу биологийн шалгуур нь хэрэг хариуцах чадваргүй байдлыг тогтоох анхдагч шалгуур юм.

Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний харилцах хүрээ хязгаарлагдмал, зөв буруугийн ялгаатай байдлын заагийн талаар ойлголтгүйгээс шалтгаалан өөрийн хувь ертөнцдөө амьдарч, хүний хувийн эд зүйл, бусдын биед халдах, гутаан доромжлох, өөрийн зөв гэж бодсон тохиолдолд түрэмгий үйлдэл гаргахаа хэвийн зүйл мэт хүлээн авах нь элбэг.

Чухамдаа хэвийн сонсголттой хүмүүс эргэн тойрон, орчны талаарх мэдээллийг өөрийн сонсголоор дамжуулан бүрэн ойлгож, хүлээн авдаг бол сонсголын бэрхшээлтэй хүнд ийм боломж байдаггүй, танин мэдэхүй, бусад төсөөлөл нь сөргөөр нөлөөлөх хандлагатай байдаг.

Эрүүгийн эрх зүйд үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар ба хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, хуульд заасан ял хөнгөрүүлэх буюу хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзан хуульд тогтоосон санкцын хэмжээ хязгаарт багтаан ял ногдуулах¹⁹... тухай заасан байдаг ч эрх зүйн чадамжтай, хариуцлагаа ухамсарладаг, хэвийн эрүүл бие махбод, сэтгэхүйтэй гэмт хэрэг үйлдсэн хүнтэй сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүнийг адилтган үзэж, ижил төрөл, хэмжээтэйгээр ялыг оногдуулсаар байна.

Хөгжлийн бэрхшээлтэй буюу сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний биеийн хөгжил, хэлгүй, дүлий байдлаас шалтгаалсан оюуны хоцрогдол, сэтгэцийн эрүүл мэндийг харгалзан үзэж, шударга, энэрэнгүй ёсны зарчимд

¹⁹ Нарангэрэл, С. “Монголын эрх зүйн англи, орос, латин хадмал эх толь бичиг”.-Уб., 2015. дөрөв дэх хэвлэлт

тулгуурлан ялыг ялгамжтай оногдуулах нь зүй ёсны асуудал болж байна.

Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний хувийн байдал нь зайлшгүй бусдын тусламжтайгаар нийгмийн харилцаанд орж, бусдын тусламж, дэмжлэгтэйгээр харилцаа үүсгэдэг бидний анхаарал хандуулах ёстой эмзэг бүлэг бөгөөд тухайн хүн гэм зэмгүй байсан эсхүл гэмт хэрэг үйлдсэн эсэхээс үл хамааран хаана ч хангагдаж байх ёстой эрхтэй юм.

ДҮГНЭЛТ

Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй гэмт хэрэг үйлдсэн этгээдийн зан чанар, оюуны хөгжлийн хоцрогдолтой байдал эрүүгийн хууль тогтоомжид хуульчилж ирсэн уламжлал, Олон Улсын эрх зүйн баримт бичиг, гадаад болон дотоодын эрүүгийн хуульд тусгасан байдал, эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт, хуулийн хүрээний хэрэгжилтийг онол, практикийн түвшинд судалж, дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

1. Эрүүгийн эрх зүйн сонгодог онолд ял оногдуулах нь шударга, хүнлэг, энэрэнгүй байх тухай байдаг бол криминологи, биологийн онолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн оюуны хоцрогдол, сэтгэцийн эрүүл мэндийн талаар эмчлэх, эмнэх олон арга туршлагаудыг дэвшүүлсэн байна. Харин сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний оюуны хоцрогдлоос үүссэн тэнэгрэл нь зөв, буруугийн ойлголтын тухайд хэрхэн хүлээн авах, оюуны хоцрогдлын зэргийг хэрхэн шинжлэн тогтоох гэх асуултыг үлдээсэн байна.
2. Гэмт хэрэг үйлдсэн хүн бүрт эрүүгийн хариуцлага тооцож, ял эдлүүлэх ёстой гэх бодлого нь эрүүгийн хариуцлагын зорилгоос холдож, шударга, энэрэнгүй, хүмүүнлэг ёсны зарчимд тулгуурлан, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй этгээдийн оюуны хоцрогдол, тухайн хүний хувийн байдалд тохирсон ялыг оногдуулах хэрэгцээ шаардлагатай.
3. Хүний үйлдсэн гэм бурууд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлийг гэмт хэргийн бүрэлдэхүүний онолын үүднээс нийгэмд аюултай үйлдлийг гэм буруугийн санаатай эсхүл болгоомжгүй хэлбэрээр үйлдсэн байх явдал бөгөөд нийгмийн хор аюулыг ухамсарлаж, өөрийгөө удирдан жолоодох чадвартай байсан эсэхээс тухайн этгээдийн хэрэг хариуцах чадварыг илэрхийлдэг.

САНАЛ

1. Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний бэрхшээлт байдал нь оюуны хоцрогдолд шууд хүргэдэг. Үйлдлийн нийгмийн хор аюулыг бүрэн ухамсарлаж, ойлгох, мэдэх боломжгүй байдлыг харгалзаж эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр бол хөнгөрүүлэх нөхцөл байдалд хамааруулан үзэх;
2. Хэрэв ял оногдуулж байгаа тохиолдолд хувь хүний онцлогыг харгалзан шүүхээс хорихоос өөр төрлийн ялыг оногдуулахдаа сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүн тогтмол орлогогүй, халамжийн тэтгэвэр 375.000 төгрөгийн орлоготой болохыг харгалзан үзэж, торгох ялаас өөр төрлийн ял болох нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зорих эрх хязгаарлах ялыг түлхүү оногдуулах, эсхүл албадлагын арга хэмжээ хэрэглэх;
3. Хэрэг хариуцах чадваргүй байдлыг тогтоох анхдагч шалгуур эмнэлгийн буюу биологийн шалгуураар сонсох чадваргүй, ярих чадваргүй, нийгмийн харилцаагүй байгаа байдал нь сэтгэцийн хямрал, фоби, психоз болон бусад эмгэгийн хөгжлийг өдөөдөг механизм оюуны хомсдолд нөлөөлсөн байдалд шинжээч томилон хөгжлийн хоцрогдол, хөгжлийн түвшинг үнэлэх дүгнэлтийг гаргадаг байх;
4. Гэмт хэрэг үйлдсэн сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй этгээдэд хорих ял эдлүүлэхдээ дэглэм, зэрэглэлийг харгалзан үзэж, нэг хорих ангид төвлөрүүлж, ял эдлүүлэх ажиллагаанд зохицуулалт оруулснаар сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй байдлаас шалтгаалан харилцаагүй байх явдал үгүй болно.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Хууль, тогтоомжийн акт

1. Монгол улсын Эрүүгийн хууль. Уб., 2002
2. Оюуны хоцрогдолтой хүний эрхийн тухай тунхаглал. 1971.
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц.
2006. <file:///C:/Users/ASPIRE/Downloads/6606d8a1e44c4991bcf0c5a00be8fce2>
4. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц. 2004.

Хоёр. Эрдэм шинжилгээний бүтээл, ном

1. Б.Баярхүү. “Шүүхийн сэтгэц эмгэг судлал” Уб., 2019.
2. Г.Гантөмөр “Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол”. Уб., 2011.
3. С.Жанцан нар Монгол улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал, /1911-2009/. Уб.,2011
4. С.Жанцан нар Монгол улсын Эрүүгийн эрх зүйн онол /Гэмт хэргийн тухай сургааль Нэгдүгээр боть. Уб.,2010 14.С.Жанцан, Эрүүгийн эрх зүйн онол /гэмт хэргийн сургааль 1 боть Уб., 2009.
5. С.Нарангэрэл, Монгол улсын Эрүүгийн эрх зүй /тусгай анги/. УБ.,1999
6. Ч.Нямсүрэн, Гэмт хэргийн виктимологи, Уб., 2006.
7. Эрдэнэбаяр, Л. Сэтгэц судлал. Уб., 2012.
8. Энхзаяа, Д. /Стив Паркер “Хүний бие”орчуулга/-Уб., 2013.

Гурав. Илтгэл, өгүүлэл

1. Хөгжлийн Бэрхшээлтэй Хүмүүсийн Эрхийн Тухай НҮБ-ын Конвенцийн Хэрэгжилтийн Талаарх Монгол Улсын Анхдугаар Илтгэл 2011.
2. Хүн ам, орон сууцны тооллого, хөгжлийн бэрхшээл сэдэвчилсэн судалгаа 12, 2021.
3. Мэндсайхан ахлагчтай судалгааны багаас хийсэн “Монгол Улсын Эрүүгийн хуулийг шинэтгэх төслийн санал”, ХЗҮХ-гээс 2004, 2009

онуудад хийсэн “Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн төлөв байдал” гэсэн суурь судалгаа, ХЗДХЯ-ны Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсгээс боловсруулсан зарим баримт, бичигт дурдсан схем, шүүмж, санал, дүгнэлт, зөвлөмжүүд, Академич С.Нарангэрэлийн боловсруулсан “Эрүүгийн төрөлжсөн хуулийн төсөл”

4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр
5. Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны 2022 оны жилийн эцсийн судалгаа

Дөрөв. Цахим эх сурвалж

1. <https://krieger.jhu.edu/cle/language-programs/>
2. ЭЕШ вэб сайт олон нийт “Удирдамж” дохионы хэл дээрх хувилбар ЕОС YouTube суваг 2022.11.15
3. <https://aurorathedawn.worldpress.com> Body language буюу биеийн хэлэмж: Илтгэл 2015.04.14
4. <https://mn.wikipedia.org/wiki/>